

**ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛСАН
СУДАЛГАА**

Улаанбаатар хот

ҮНДСЭН ХЭСЭГ

НЭГ. ГЭР БҮЛИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1. Бүгд Найрамдах Солонгос Улс

1) Гэрлэлт цуцлалт, гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцох, гэрлэлт цуцлахтай холбоотой гэм хорын нэхэмжлэл, гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох

(1) Гэрлэлт цуцлалт

Гэрлэлтийг дараах аргаар цуцалж болно.

- а. Харилцан тохиролцох журмаар(захиргааны)¹
- б. Шүүхийн журмаар²

Харилцан тохиролцох журмаар гэрлэлт цуцлах(захиргааны)

Гэрлэлт цуцлуулах хүсэлт гаргах, шүүхийн харьяалал

Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулахаар харилцан тохиролцсон бол оршин сууж байгаа газрын харьяа Гэр бүлийн шүүхэд гэрлэлтээ цуцлуулах тухай хүсэлтийг хамтдаа гарган шийдвэр гаргуулах бөгөөд гадаадад оршин сууж байгаа тохиолдолд Сөүл хотын Гэр бүлийн шүүхэд хүсэлт гарган шийдвэр гаргуулна.³

Зөвлөгөө, түүний хугацаа

Харилцан тохиролцож гэрлэлтээ цуцлуулах тухай хүсэлт гаргасан гэрлэгчид нь Гэр бүлийн шүүхийн гэрлэлт цуцлуулахтай холбоотой зөвлөгөөг авах ёстой бөгөөд шүүх шаардлагатай гэж үзвэл тусгай мэдлэгтэй мэргэжлийн туршлагатай хүнээс зөвлөгөө авахыг санал болгож болно.⁴

Шүүхийн гэрлэлт цуцлах шийдвэр гаргах хугацаа

¹ БНСУ-ын Иргэний хуулийн 834 дүгээр зүйл. Гэрлэгчид нь харилцан тохиролцох журмаар гэрлэлтээ цуцлуулж болно. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

² БНСУ-ын Иргэний хуулийн 840 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

³ БНСУ-ын Гэр бүлийн бүртгэлийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 836.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

Гэр бүлийн шүүх нь гэрлэгчид харилцан тохиролцож гэрлэлтээ цуцлуулахаар хүсэлт гаргаж шүүхийн зөвлөгөөг авч эхэлсэн өдрөөс зөвшилцөх хугацаа олгох бөгөөд тухайн хугацаа өнгөрсөнөөс хойш гэрлэлт цуцалсан тухай шийдвэр гаргана.⁵

- а) Тэжээн тэтгэх хүүхэд байгаа(жирэмсэн бол мөн адил) бол 3 сар
- б) Тэжээн тэтгэх хүүхэд байхгүй бол 1 сар

Харин хүчирхийлэлийн улмаас гэрлэлтийг цуцлуулах нөхцөл байдал байгаа тохиолдолд дээрх хугацааг богиносгох эсхүл харгалзахгүй байж болно.⁶

Гэрлэлт цуцлах тухай талуудын хүсэл зоригийг тогтоох

Гэрлэгчид харилцан тохиролцож гэрлэлтээ цуцлуулахаар хүсэлт гаргаж шүүхийн зөвлөгөөг авч эхэлснээс хойш хуульд заасан зөвшилцөх хугацаа өнгөрсөн тохиолдолд шүүхэд хамтдаа ирж мэдүүлэг өгөх бөгөөд насанд хүрээгүй хүүхдийн хууль ёсны асран хамгаалалт болон түүнийг тэжээн тэтгэх тухай тохиролцоог баталгаажуулсан шийдвэрийг хүлээн авна.⁷

Гэрлэлт цуцалсан тухай тодорхойлолт

Гэр бүлийн шүүх нь гэрлэгчидийн гэрлэлтээ цуцлуулах тухай хүсэлтийг тодруулан энэ тухай тодорхойлолт үйлдэж насанд хүрээгүй хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч, тэжээн тэтгэхтэй холбоотой асуудлыг шалган дүгнэж энэ тухай мөн тодорхойлолт үйлдэнэ.⁸

Насанд хүрээгүй хүүхдийн хууль ёсны асран хамгаалалт болон тэжээн тэтгэхтэй холбоотой талуудын тохиролцоо хүүхдэд хохиролтой гэж үзвэл дахин зөвшилцөн тохиролцохыг даалгаж болох бөгөөд талууд хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Гэр бүлийн шүүх нь тэжээн тэтгэхтэй холбоотой тэтгэлэгийн тохиролцоог баталгаажуулсан тодорхойлолтыг үйлдэхгүй байх эрхтэй.⁹

Шүүхийн захиргааны ажилтан нь гэрлэлтийг цуцалсан тухай тодорхойлолтыг шүүх баталгаажуулмагц нэн даруй гэрлэлт цуцалсан тухай тодорхойлолт, насанд

⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 836.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁶ БНСУ-ын Иргэний хуулийн 836.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.
<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁷ БНСУ-ын Гэр бүлийн улсын бүртгэлийн журам 74 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=261573&efYd=20240719#0000>

⁸ БНСУ-ын Гэр бүлийн улсын бүртгэлийн журам 78 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=261573&efYd=20240719#0000>

⁹ БНСУ-ын Гэр бүлийн улсын бүртгэлийн журам 78 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=261573&efYd=20240719#0000>

хүрээгүй хүүхэдтэй бол тэтгэлэг тогтоосон тохролцоог баталгаажуулсан шүүхийн тодорхойлолт зэргийг талуудад хүргүүлнэ.¹⁰

Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах

а) Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

Шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулах бол эхлээд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулсан байна. Өөрөөр хэлбэл гэрлэлтээ цуцлуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргахаас өмнө эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хүсэлт гаргах ёстой бөгөөд энэхүү хүсэлтийг гаргаагүй бол шүүх эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахаар шилжүүлнэ. Дараах тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахгүйгээр шүүхийн журмаар гэрлэлт цуцлах ажиллагааг явуулж болно.¹¹

1. Олон нийтэд зарлахаас бусад тохиолдолд гэрлэгчдийг дуудан ирүүлэх боломжгүй бол
2. Шүүх эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахаар шилжүүлсэн ч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүй нь тогтоогдсон бол

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах тухай хүсэлт гаргахдаа хөрөнгө хуваах, гэм хор, тэтгэлэг, хууль ёсны асран хамгаалагчийн талаар талууд тохиролцоогүй бол энэ талаар мөн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахаар хүсэлт гаргаж болно.¹²

Шүүхийн харьяалал

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хүсэлтийг дараах Гэр бүлийн шүүхэд гаргана.¹³

1. Гэрлэгчид нэг Гэр бүлийн шүүхийн харьяалалд хамаарахаар байвал тухайн Гэр бүлийн шүүхэд
2. Гэрлэгчид хамгийн сүүлд хамт бүртгэлтэй байсан хаягт хамаарах шүүхийн харьяалалд гэрлэгчдийн хэн нэг нь хамаарах бол тухайн Гэр бүлийн шүүхэд
3. Дээр дурьдсан 1,2-д хамаарахгүй бол хариуцагчийн харьяалах Гэр бүлийн шүүхэд
4. Гэрлэгчид харилцан тохиролцсон Гэр бүлийн шүүх

¹⁰ БНСУ-ын Гэр бүлийн улсын бүртгэлийн журам 78 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=261573&efYd=20240719#0000>

¹¹ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1.1.4 дэх хэсэг, 50 дугаар зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

¹² БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

¹³ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйл, 51 дугаар зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

Гэр бүлийн шүүхийн шалгах ажиллагаа

Гэр бүл болгон амьдралын нөхцөл байдал зэргээс шалтгаалж гэр бүлээ цуцлуулахад хүргэсэн шалтгаан нь өөр өөр байдаг тул эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахдаа Гэр бүлийн шүүх энэхүү хувийн болон тодорхой нөхцөл байдлыг харгалзан үзэх хэрэгцээ шаардлага бий болдог тул эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахаас өмнө гэр бүлийн бодит байдлын талаар шалгах ажиллагааг явуулж болно.¹⁴

Энэхүү шалгах ажиллагааны хүрээнд шаардлагатай гэж үзвэл цагдаагийн байгууллага, захиргааны байгууллага болон бусад байгууллага эсхүл хувь хүнээс(банк, сургууль гэх мэт) гэрлэгчдийн дансны мэдээлэл, хөрөнгийн байдал, орлого, боловсролын байдал болон бусад шаардлагатай мэдээллийг нягтлан шалгаж болно.¹⁵

Гэрлэгчид эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох, мэдүүлэг өгөх

Шүүхээс эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах өдөр товлогдсон бол талууд болох гэрлэгчид эсхүл тэдний хууль ёсны төлөөлөгч болон шаарлагатай бол бусад этгээдийг байлцуулан мэдүүлэг авч эвлэрүүлэх ажиллагааг явуулна.¹⁶

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах өдөр эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах хүсэлт гаргасан этгээд ирээгүй бол дахин тов тогтоох бөгөөд дахин тогтоосон өдөр мөн ирээгүй мөн түүнээс хойш шинээр тов тогтоосон өдөр ирээгүй бол хүсэлтээсээ татгалзсан гэж үзэх¹⁷ бөгөөд мөн адил нөгөө тал ирээгүй бол эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл эсхүл эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эрхэлсэн шүүгч холбогдох шийдвэрийг гаргана.¹⁸

Эвлэрэл хүчин төгөлдөр болох

¹⁴ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйл, 56 дугаар зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

¹⁵ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын 3 дугаар зүйл(Дээд шүүхийн журам).

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=210085&efYd=20190802#0000>

¹⁶ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

¹⁷ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 49 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 31 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=213779&efYd=20200305#0000>

¹⁸ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 49 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 30,32 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=213779&efYd=20200305#0000>

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад талууд гэрлэлтээ цуцлуулах тохиролцоонд хүрсэн бол эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тэмдэглэлд тусгаснаар эвлэрсэн гэж үзнэ.¹⁹ Энэхүү эвлэрэл нь шүүхийн хуралдааны явцад эвлэрсэнтэй адил хууль зүйн үр дагавартай байна.²⁰

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны шийдвэр

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах өдөр ирээгүй, талууд тохиролцоонд хүрч чадаагүй, талуудын тохиролцоог зүй бус гэж үзвэл эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл эсхүл эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эрхэлсэн шүүгч холбогдох шийдвэрийг гаргах мөн талуудыг эвлэрүүлэх санал бүхий зохих шийдвэрийг гаргаж болно.²¹

Дээрх шийдвэртэй холбогдуулан талууд шийдвэрийг хүлээн авснаас хойш 2 долоо хоногын дотор гомдол гаргаагүй, гомдлоосоо татгалзсан, гомдлыг хүлээн авахаас татгалзсан шийдвэр хүчин төгөлдөр болсон шүүхийн шатанд эвлэрсэн тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсонтой адил хууль зүйн үр дагавар бий болно.²²

Шүүхийн журмаар гэрлэлт цуцлуулах

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахгүй байхаар шийдвэрлэсэн,²³ эвлэрүүлэн зуучлал хүчин төгөлдөр болоогүй,²⁴ эвлэрүүлэн зуучлах ажиллагааны шийдвэртэй холбогдуулан талуудын гаргасан гомдлыг хүлээн авсан шийдвэр хүчин төгөлдөр бус болсон²⁵ бол эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болсон гэж үзэн хэргийг шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэнэ.

¹⁹ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

²⁰ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

²¹ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12, 49 дүгээр зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 30,32 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=213779&efYd=20200305#0000>

БНСУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 225 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249995&efYd=20231019#0000>

²² БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 49 дүгээр зүйл, 59 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 34 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=213779&efYd=20200305#0000>

БНСУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 231 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249995&efYd=20231019#0000>

²³ БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 26 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=213779&efYd=20200305#0000>

²⁴ БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=213779&efYd=20200305#0000>

²⁵ БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 34 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=213779&efYd=20200305#0000>

Шүүхээр шийдвэрлэх ажиллагаа

Гэрлэгчид буюу нэхэмжлэгч хариуцагчид шүүх хуралд өөрийн биеэр эсхүл хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан оролцож нэхэмжлэлийн шаардлагаа танилцуулж, хариу тайлбар гаргахаас гадна шүүхийн шалгах ажиллагаа, нотлох баримтын талаар мэдүүлэг өгч холбогдох тайлбарыг гаргана.²⁶

Шүүхийн шийдвэр

Гэрлэлт цуцлахтай холбоотой шүүхийн шийдвэр гарснаар хүчин төгөлдөр болно.²⁷ Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүх хүлээн авч шийдвэрлэсэн бол тухайн шийдвэр нь гуравдагч этгээдэд мөн адил хууль зүйн хүчин төгөлдөр үр дагавартай байна.²⁸ Нөгөөтэйгүүр шүүх нэхэмжлэлийг хүлээн аваагүй бол нэхэмжлэгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангаанаар оролцож чадаагүй гэдгээ нотолж чадаагүй бол тухайн асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхгүй байна.²⁹ Шүүхийн шийдвэрийн эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногын дотор давж заалдах журмаар³⁰ болон хяналтын журмаар гомдол гаргах боломжтой байна.³¹

(2) Гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцох

Үндэслэл

Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулах тухай харилцан хүсэл зоригоо илэрхийлэн өмнө дурьдсан хуулиар тогтоосон гэрлэлт цуцлах ажиллагааны дагуу гэрлэлтээ цуцлуулах ёстой бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр гэж үзэхгүй бөгөөд гэрлэгчдэд мэдэгдэлгүй гэрлэлтийг цуцалсан³², гэрлэгчдэд мэдэгдэлгүй гадаад гэрлэлт цуцлах тухай шүүх хурал болж гэрлэлт

²⁶ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйл, 17 дугаар зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

БНСУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 287 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249995&efYd=20231019#0000>

²⁷ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

БНСУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 205 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249995&efYd=20231019#0000>

²⁸ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

²⁹ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

³⁰ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

³¹ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#>

³² БНСУ-ын Иргэний хуулийн 834 дүгээр зүйл. Гэрлэгчид харилцан тохиролцож гэрлэлтээ цуцлуулж болно. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

цуцалсан тухай шүүхийн шийдвэр гарсан³³, гэрлэлт цуцлалтыг улсын бүртгэлт бүртгүүлэхээс өмнө гэрлэгчид гэрлэлт цуцлахаас татгалзсан боловч бүртгэсэн³⁴ мөн өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгох чадваргүй байх үедээ гэрлэлт цуцалсан бол гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцох үндэслэл болно.

Шүүхийн харьяалал

Гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцуулах тухай нэхэмжлэлийг Гэр бүлийн шүүхэд гаргана.³⁵

1. Гэрлэгчид нэг Гэр бүлийн шүүхийн харьяалалд хамаарахаар байвал тухайн Гэр бүлийн шүүхэд
2. Гэрлэгчид хамгийн сүүлд хамт бүртгэлтэй байсан хаягт хамаарах шүүхийн харьяалалд гэрлэгчдийн хэн нэг нь хамаарах бол тухайн Гэр бүлийн шүүхэд
3. Дээр дурьдсан 1,2-д хамаарахгүй бол гэрлэгчид хэн нэгийг хариуцагчаар нэхэмжлэл гаргасан бол хариуцагчийн харьяалах Гэр бүлийн шүүхэд, гэрлэгчдийг хариуцагчаар нэхэмжлэл гаргасан бол хэн алины харьяалах Гэр бүлийн шүүхэд
4. Гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан бол нөгөө гэрлэгчийн харьяалах Гэр бүлийн шүүхэд
5. Гэрлэгчид нас барсан бол гэрлэгчдийн хэн алины хамгийн сүүлд харьяалах оршин сууж байсан хаягт харьяалах Гэр бүлийн шүүхэд

Нэхэмжлэгч, нэхэмжлэл гаргах хугацаа

Гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцуулах үндэслэл байвал гэрлэгчид, тэдний хууль ёсны төлөөлөгч эсхүл тэдгээрийн 4 дүгээр үед багтах төрөл садан хэдийд ч Гэр бүлийн шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.³⁶

Хариуцагч

Гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцуулах маргааны хариуцагчаар гэрлэгчдийн хэн нэг нь байна.³⁷ Гуравдагч этгээд нэхэмжлэл гаргасан бол гэрлэгчид хариуцагч болох бөгөөд гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан бол нөгөө гэрлэгч хариуцагч

³³ БНСУ-ын Сөүл хотын Гэр бүлийн шүүхийн шийдвэр, 서울가법 1993. 12. 9. 선고 92 드 68848 판결, [https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/\(92%EB%93%9C68848\)](https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/(92%EB%93%9C68848))

³⁴ БНСУ-ын Дээд шүүхийн шүүхийн шийдвэр, 대법원 1994. 2. 8. 선고 93 도 2869 판결, [https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/\(93%EB%8F%842869\)](https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/(93%EB%8F%842869))

³⁵ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйл, <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#>

³⁶ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 23 дугаар зүйл, <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#>

³⁷ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#0000>

байна.³⁸ Харин хариуцагч болох хүн нас барсан бол прокурор хариуцагч байна.³⁹ Гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн шийдвэрт гомдол гаргахад шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцож чадаагүйгээ нотолж чадаагүй бол гомдол гаргах эрхгүй байна.⁴⁰

Эвлэрүүлэн зуучлал

Гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцуулах маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хийхгүй.⁴¹

Шүүхийн шийдвэрийн хууль зүйн үр дагавар

Гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцож шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь гуравдагч этгээдэд мөн адил хууль зүйн үр дагавар бий болгоно.⁴² Мөн гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор гэрлэлтийг анхнаасаа хүчин төгөлдөр байсан гэж үзнэ.

Давж заалдах гомдол гаргах

Гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцож шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргана.⁴³ Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг мөн хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор дээд шүүхэд гомдол гаргах эрхтэй байна.⁴⁴

(3) Гэрлэлт цуцлалтыг хүчингүй болгох

Үндэслэл

Гэрлэлт цуцлуулах эсэхийг гэрлэгчид сайн дураар хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлж шийдвэрлэх тул хэн нэгний албадлаганд орж эсхүл залилан мэхлүүлж

³⁸ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

³⁹ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁴⁰ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁴¹ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁴² БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁴³ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁴⁴ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

гэрлэлт цуцлуулах тухай хүсэл зоригоо илэрхийлсэн бол гэрлэлт цуцлалтыг хүчингүй болгуулахаар Гэр бүлийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхэй байна.⁴⁵

Шүүхийн харьяалал

Шүүхийн харьяалалыг дараах байдлаар хуульчилсан байна.⁴⁶

1. Гэрлэгчид нэг Гэр бүлийн шүүхийн харьяалалд хамаарахаар байвал тухайн Гэр бүлийн шүүхэд
2. Гэрлэгчид хамгийн сүүлд хамт бүртгэлтэй байсан хаягт хамаарах шүүхийн харьяалалд гэрлэгчдийн хэн нэг нь хамаарах бол тухайн Гэр бүлийн шүүхэд
3. Дээр дурьдсан 1,2-д хамаарахгүй бол гэрлэгчид хэн нэгнийг хариуцагчаар нэхэмжлэл гаргасан бол хариуцагчийн харьяалах Гэр бүлийн шүүхэд, гэрлэгчдийг хариуцагчаар нэхэмжлэл гаргасан бол хэн алины харьяалах Гэр бүлийн шүүхэд
4. Гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан бол нөгөө гэрлэгчийн харьяалах Гэр бүлийн шүүхэд
5. Гэрлэгчид нас барсан бол гэрлэгчдийн хэн алины хамгийн сүүлд оршин сууж байсан хаягт харьяалах Гэр бүлийн шүүхэд

Нэхэмжлэл гаргах хугацаа

Хууран мэхлэгдэж эсхүл албадлагаар гэрлэлтээ цуцлуулсан бол хууртсанаа мэдсэн өдөр эсхүл албадлагаас чөлөөлөгдсөн өдрөөс хойш 3 сарын дотор гэрлэлт цуцлалтыг хүчингүй болгуулахаар шүүхэд гомдол гаргах бөгөөд энэхүү хугацаа хэтэрсэн бол нэхэмжлэл гаргах эрхгүй байна.⁴⁷

Хариуцагч

Гэрлэлт цуцлалтыг хүчингүй болгуулах маргааны хариуцагчаар гэрлэгчдийн хэн нэг нь байна.⁴⁸ Гуравдагч этгээд нэхэмжлэл гаргасан бол гэрлэгчид хариуцагч болох бөгөөд гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан бол нөгөө гэрлэгч хариуцагч байна.⁴⁹ Харин хариуцагч болох хүн нас барсан бол прокурор хариуцагч байна.⁵⁰

⁴⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 838 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁴⁶ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁴⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 823 дүгээр зүйл, 839 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁴⁸ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁴⁹ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁵⁰ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

Эвлэрүүлэн зуучлал

Гэрлэлт цуцлалтыг хүчингүй болгуулахаар маргааныг шүүхээр шийдвэрлэхийн тулд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулсан байна.⁵⁴

Шүүхийн шийдвэрийн хууль зүйн үр дагавар

Гэрлэлт цуцлалтыг хүчингүй болгож шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь гуравдагч этгээдэд хүчин төгөлдөр хууль зүйн үр дагварыг бий болгоно.⁵² Тиймээс гэрлэлт цуцлуулах шалтгаан нөхцөлийг бий болгосон гуравдагч этгээдэд холбогдуулан эдийн ба эдийн бус гэм хор нэхэмжлэх эрхтэй байна.

Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор гэрлэлт анхнаасаа хүчин төгөлдөр хэвээ байсан гэж үзэх бөгөөд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохоос өмнө талуудын хэн нэг нь бусадтай гэрлэлтээ бүртгүүлсэн бол хүчин төгөлдөр бус гэж үзнэ.⁵³

Давж заалдах гомдол гаргах

Гэрлэлт цуцлалтыг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргана.⁵⁴ Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг мөн хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор дээд шүүхэд гомдол гаргах эрхтэй байна.⁵⁵

(4) Гэрлэлт цуцлахтай холбоотой гэм хорын нэхэмжлэл

Гэм хорын нэхэмжлэлийн ойлголт

Гэрлэлт цуцлагдсан тохиолдолд гэрлэлт цуцлуулахад хүргэсэн буруутай талаас эдийн бус гэм хорыг нэхэмжилж өөрт учирсан гэм хорыг нөхөн төлүүлэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл гэрлэлт цуцлуулах болсон шалтгаан нөхцөл нь нөгөө талынхаа сэтгэл санаанд гэм хор учруулсан гэж үзвэл шүүхэд нэхэмжлэл гарган

⁵¹ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1.1.1 дэх хэсгийн хэсэг, 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁵² БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁵³ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대법원 1984. 3. 27. 선고 84 르 9 판결, [https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/\(84%EB%AF%809\)](https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/(84%EB%AF%809))

⁵⁴ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁵⁵ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#0000>

шийдвэрлүүлэх бөгөөд энэхүү гэм хорыг мөнгөн хэлбэрээр гаргуулах боломжтой байна.⁵⁶

Гэм хорын нэхэмжлэлийг шүүхийн журмаар, захиргааны буюу харилцан тохиролцож гэрлэлт цуцлуулах, гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцуулах, гэрлэлт цуцлалтыг хүчингүй болгох тохиолдолд нэгэн адил гаргах боломжтой байхаар хуульчилсан байна.⁵⁷⁵⁸ Гэхдээ талууд харилцан буруутай байх тохиолдолдыг харгалзан үзэх ёстой⁵⁹ бөгөөд харилцан буруутай байх тохиолдолд гом хорын нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэнэ.⁶⁰

Эрх шилжүүлэх, өвлүүлэх

Эрх зүйн зарчмын хувьд гэм хорыг шаардах эрхийг бусдад шилжүүлэх эсхүл өвлүүлэх боломжгүй гэж үзэж болох боловч талууд нэгэнт тохиролцсон тухай хэлцэл хүчин төгөлдөр болсон эсхүл шүүхэд нэхэмжлэл гаргаснаас хойш эрх шилжүүлж өвлүүлж болно гэж үздэг байна.⁶¹

БНСУ-ын Дээд шүүхийн шүүхийн шийдвэр⁶²

Гэм хор шаардах эрх нь тухайн хүнд байх онцгой эрх бөгөөд түүнийг шилжүүлэх, өв залгамжлуулах нь зарчмын хувьд боломжгүй гэж үзэж болох боловч энэ нь өмчлөх эрхийн онцгой эрх байх тул түүнийг хэрэгжүүлэх эрхийн хүрээнд авч үзвэл тухайн шаардах эрхээ хэрэгжүүлэхээр хүсэл зоригоо тодорхой илэрхийлэн нэхэмжлэл гаргаж байгаа зэргээс харахад энэхүү эрхийг бусдад шилжүүлэх эсхүл өвлүүлэх боломжтой гэж үзэхээр байна.

Гэм хорын нэхэмжлэл ба хөрөнгө хуваах

Эдийн бус гэм хор шаардах асуудал нь гэрлэгчдийн хэн алины буруутай үйлдлээс шалтгаалан гэрлэлт цуцлагдсанаар нөгөө гэрлэгчид үүсэх эдийн бус гэм буюу сэтгэл санааны хохиролыг нөхөн төлүүлэх зорилго бүхий бол гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваахтай холбоотой асуудал гэрлэгчдийн хамтын оролцоотойгоор бий

⁵⁶ БНСУ-ын Иргэний хуулийн 806 дугаар зүйл, 843 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁵⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 806 дугаар зүйл, 825 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000Й>

⁵⁸ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1.1. □,

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁵⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 396 дугаар зүйл, 763 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁶⁰ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대법원 1994. 4. 26. 선고 93 무 1273 판결,

[https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/\(93%EB%AF%801273\)](https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/(93%EB%AF%801273))

⁶¹ БНСУ-ын Иргэний хуулийн 806 дугаар зүйл, 843 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁶² БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대법원 1993. 5. 27. 선고 92 무 143 판결,

[https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/\(92%EB%AF%80143\)](https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/(92%EB%AF%80143))

болсон хөрөнгөд оруулсан тус бүрийн оролцоонд үндэслэл хуваах ойлголт байдаг тул эдгээрийг шаардах эрх үүсэх үндэслэл зэрэг нь эрх зүйн тогтолцоо, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог зэргээс шалтгаалан бие даасан тусдаа журмаар зохицуулдаг байна. Тиймээс хөрөнгө хуваах бол гэм хор нэхэмжлэх тухай нэхэмжлэлийг тусад нь гарган шийдвэрлүүлэх боломжтой байдаг байна.⁶³

(5) Гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох

Үндэслэл

Доор дурьдсан аль нэг тохиолдол байгаа бол гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.⁶⁴

1. Гэрлэгчид гэрлэхээр хүсэл зоригоо илэрхийлээгүй бол
2. 8 үед багтах цусан төрлийн (өргөж авсан этгээдэд хамаарна) хоорондоо гэрлэсэн бол
3. Гэрлэгч талууд цусан төрлийн холбоотой ба холбоотой байсан бол
4. Гэрлэгч талуудын эцэг эхүүд төрөл садны холбоотой байсан бол

Нэхэмжлэгч, нэхэмжлэл гаргах

Дээр дурьдсан гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл байвал гэрлэгчид болон тэдний хуул ёсны төлөөлөгч эсхүл 4 дүгээр үед багтах төрөл садангийн хүн Гэр бүлийн шүүхэд нэхэмжлэл гаргана.⁶⁵

Гэрлэгчдийн аль нэг нь нэхэмжлэл гаргасан бол нөгөө тал нь, гуравдагч этгээд нэхэмжлэл гаргасан бол гэрлэгчид, гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан бол нөгөө тал нь, хариуцагч нас барсан бол прокурор хариуцагч байна.⁶⁶

Эвлэрүүлэн зуучлал

⁶³ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대법원 2001. 5. 8. 선고 2000 다 58804 판결, [https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/\(2000%EB%8B%A458804\)](https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/(2000%EB%8B%A458804))

⁶⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 809 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 815 дугаар зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁶⁵ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 23 дугаар зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁶⁶ Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1-3 дахь хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

Гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцуулахад Гэр бүлийн шүүхийн эвлэрүүлэх зуучлах ажиллагааг явуулсан байхыг шаардахгүй.⁶⁷

Шүүхийн шийдвэр хууль зүйн үр дагавар

Гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон бол гэрлэлт анхнаасаа хүчин төгөлдөр бус байх тэдний дундаас төрсөн хүүхдийг гэрлэлтээс гадуур төрсөн хүүхэд гэж ойлгоно.⁶⁸

Нэг талын хайхрамжгүй байдлаас болж гэрлэлт хүчин төгөлдөр бус болсноос болж нөгөө талд нь эдийн болон эдийн бус гэм хор учирсан бол нөхөн төлүүлэхээр шаардаж болно.⁶⁹

(6) Гэрлэлтийг хүчингүй болгох

Үндэслэл

Доор дурьдсан аль нэг тохиолдол байгаа бол гэрлэлтийг хүчингүй болгох үндэслэл болно.

1. Талууд 18 насанд хүрээгүй бол⁷⁰
2. Насанд хүрээгүй хүн эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрлэсэн бол⁷¹ (жирэмсэн болсон бол гэрлэлтийг хүчингүй болгуулах боломжгүй⁷²)
3. 6-р үеийн цусан төрөлд багтах гэрлэгч, гэрлэгчийн 6 дугаар үеийн цусан төрөл, гэрлэгчийн 4 дүгээр үеийн цусан төрөлд багтах хүнтэй гэрлэсэн бол⁷³ (жирэмсэн болсон бол гэрлэлтийг хүчингүй болгуулах боломжгүй⁷⁴)

⁶⁷ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1.1. ᠒-а 1, <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#0000>

⁶⁸ БНСУ-ын Иргэний хуулийн 885 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁶⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 806 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг, 825 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁷⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 807 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁷¹ БНСУ-ын Иргэний хуулийн 808 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁷² БНСУ-ын Иргэний хуулийн 819 дүгээр зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁷³ БНСУ-ын Иргэний хуулийн 809 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁷⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 820 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

4. Үрчлэн авсан эцгийн 6 дугаар үеийн цусан төрлийн хүн, үрчлэн авсан эхийн 4 дүгээр үеийн хүнтэй гэрлэсэн бол⁷⁵ (жирэмсэн болсон бол гэрлэлтийг хүчингүй болгуулах боломжгүй)⁷⁶
5. Гэрлэсэн бол⁷⁷
6. Гэрлэх үед талуудын аль нэг нь гэр бүлийн амьдралаа хэвийн үргэлжлүүлэхэд саад болхуйц муу зан чанар эсвэл бусад ноцтой шалтгаан байгааг мэдээгүй бол⁷⁸ (талууд энэ тухай мэдсэнээс хойш 6 сар өнгөрсөн бол гомдол гаргах эрхгүй байна⁷⁹)
7. Хууран мэхлэгдэж эсхүл албадлагаар гэрлэсэн бол(талууд энэ тухай мэдсэнээс хойш 3 сар өнгөрсөн бол гомдол гаргах эрхгүй⁸⁰)

Нэхэмжлэгч, хариуцагч

Гэрлэгчдийн хэн нэг нь нэхэмжлэл гаргасан бол нөгөө тал нь, гуравдагч этгээд нэхэмжлэл гаргасан бол гэрлэгчид, гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан бол нөгөө тал нь хариуцагч болох бөгөөд хариуцагч нас барсан бол прокурор хариуцагч байна.⁸¹

Эвлэрүүлэн зуучлал

Гэрлэлтийг хүчингүй болгоход Гэр бүлийн шүүхийн эвлэрүүлэх зуучлах ажиллагааг явуулсан байна.⁸²

Шүүхийн шийдвэр хууль зүйн үр дагавар

Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор гэрлэлт тухайн цаг хугацаанаас эхлэн хүчингүй болох бөгөөд гэрлэлт хүчингүй болохоос өмнө төрсөн хүүхэд гэрлэлтийн үед төрсөн хүүхдийн нэгэн адил эрхтэй байна.

⁷⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 809 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁷⁶ БНСУ-ын Иргэний хуулийн 820 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁷⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 810 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁷⁸ БНСУ-ын Иргэний хуулийн 816 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁷⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 822 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁸⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 823 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

⁸¹ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1,2,3 дахь хэсэг.

⁸² БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1.1. 1, 2, 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

2) Хамтран амьдрагчийг адилтгах, тэдгээрийн хөрөнгийн маргаан

Хамтран амьдрагчийг адилтгах

Тус улсын Иргэний хуулийн 812 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэрлэлтийг Гэр бүлийн бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн бол хууль ёсны гэр бүл болсонд тооцдог байна.⁸³ Гэхдээ хууль ёсны дагуу улсын бүртгэлд бүртгүүлээгүй боловч гэр бүлийн хэлбэрийг агуулан дундаасаа хүүхэдтэй болсон, нэг хаяганд оршин суудаг, хамтран хөрөнгө бий болгосон гэх мэт олон талаар хууль ёсны гэр бүлийн нэгэн адил хэлбэрийг бий болгон амьдарч буй тохиолдлыг гэрлэлттэй адилтган үзэж шийдвэрлэх тохиолдол шүүхийн практикт нэгэнт тогтсон байна.⁸⁴

Үүнийг дагаад гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хууль ёсны гэр бүлтэй адилтгах нөхцөл байдал бий болсонд тооцогдсон бол тэдний эд хөрөнгийн асуудал гэр бүлийн дундын эд хөрөнгийн зохицуулалтын дагуу шийдэгдэх боломжтой байдаг байна.⁸⁵

Гэвч гэрлэлтээ бүртгүүлээгүй хосуудын хэн нэг нь нас барсан тохиолдолд өв залгамжлах эрх зүйн харилцаа бий болдоггүй байна.⁸⁶ Өөрөөр хэлбэл гэрлэлтийг адилтгах харилцааны хувьд хосуудын хэн нэг нь нас барсан тохиолдолд хууль ёсны гэр бүлийн адил үлдсэн эхнэр эсхүл нөхөр нь хөрөнгийг өв залгамжлах эрхтэй байдаг бол энэ тохиолдолд өв залгамжлах эрхийг гэрлэлтээ бүртгүүлээгүй тохиолдолд хязгаарладаг байна.

Дээрхээс харахад гэрлэлтээ хуульд заасны дагуу бүртгүүлээгүй боловч бусад олон нөхцөл байдлыг харгалзан үзээд хосуудыг гэрлэлттэй адилтган үзэж гэр бүлийн дундын эд хөрөнгийн зохицуулалтын хүрээнд хөрөнгийн адил эрхтэй байхаар шийдвэрлэх боловч хэн нэг нь нас барснаар үүсэх өв залгамжлалын эрх зүйн харилцааг зөвхөн хууль ёсны дагуу гэрлэлтээ бүртгүүлсэн хосуудын хүрээнд хүчин төгөлдөр байхаар хуульчилсан нь хуулийн дагуу гэрлэлтээ бүртгүүлэх нь хууль зүйн дагуу аливаа эрхээ хамгаалуулах боломжтой байна гэж ойлгож болох юм.

3) Үрчлэлт, үрчлэлтийг хүчингүйд тооцох, үрчлэлтийг шүүх шийдвэрлэх журам

Үрчлэлтийг шүүх шийдвэрлэх журам

⁸³ БНСУ-ын Иргэний хуулийн 812 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#J812:0>

⁸⁴ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 1965.7.6,65 므 12 등, 대판 2001.4.13,200 다 52943.

⁸⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 827-832 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#J812:0>

⁸⁶ 송덕수, 민법강의, 박영사, 2023, 1593 면.

БНСУ-ын хувьд үрчлэлт хүчин төгөлдөр болохын тулд юуны өмнө талууд хүлээн зөвшөөрсөн байхыг шаардана.⁸⁷ Талуудын тохиролцоо байхгүй хүсэл зоригийн илэрхийлэл баталгаажаагүй бол хууль зүйн үр дагавар бий болох боломжгүй бөгөөд **үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл** болно.⁸⁸ Энэхүү хүсэл зоригийн илэрхийлэл нь үрчлэлттэй холбоотой хүсэлт гаргах, хүсэлтийг хүлээн авч шийдвэр гаргах явцад мөн хүчин төгөлдөр хэвээр байхыг шаарддаг байна.

Гэр бүлийн шүүхийн ажиллагаа, үрчлэлтийн зөвшөөрөл

Насанд хүрээгүй хүүхдийг үрчлэх бол Гэр бүлийн шүүхийн зөвшөөрөлийг авах ёстой⁸⁹ бөгөөд Гэр бүлийн шүүх нь үрчлэгдэх хүүхдийн ирээдүй аж амьдралын нөхцөл байдал, үрчлэх болсон шалтгаан, үрчлэн авч буй этгээдүүдийн хүүхэд өсгөн хүмүүжүүлэх болон асран хамгаалах чадвар, бусад нөхцөл байдлыг харгалзан үзээд үрчлүүлэх зөвшөөрөл олгохгүй байж болно.⁹⁰

Гэр бүлийн шүүх нь үрчлэлттэй холбоотой шийдвэр гаргахдаа эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар өөрийгөө илэрхийлэх боломжгүй байхаас бусад тохиолдолд заавал дор дурьдсан хүний саналыг авах ёстой.⁹¹

1. 13 дээш насны үрчлэгдэгч
2. Үрчлэгдэж буй хүний хууль ёсны төлөөлөгч
3. Үрчлэгдэж буй хүний эцэг, эх (Иргэний хуулийн 870 дугаар зүйлд⁹² заасны дагуу эцэг, эхийн зөвшөөрөл шаардлагатай тохиолдолыг ойлгоно)
4. Үрчлэгдэгчийн эцэг, эхийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч
5. Үрчлэгч

⁸⁷ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대법원 2004. 4. 9. 선고 2003 무 2411 판결,

[https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/\(2003%EB%AF%802411\)](https://www.law.go.kr/%ED%8C%90%EB%A1%80/(2003%EB%AF%802411))

⁸⁸ БНСУ-ын Иргэний хуулийн 883 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#J883:0>

⁸⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 886 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#J883:0>

⁹⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 886 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#J883:0>

⁹¹ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.9 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#J45:9>

⁹² БНСУ-ын Иргэний хуулийн 870 дугаар зүйл (Насанд хүрээгүй хүүхдийг үрчлэх зөвшөөрөл)

1. Үрчлэгдэж байгаа насанд хүрээгүй хүүхдийн эцэг эхийн зөвшөөрлийг авна. Доор дурьдсан аль нэг тохиолдолд байвал зөвшөөрөл авахгүй байж болно.

- 1) 869 дүгээр зүйлийн 1,2 дахь хэсэгт зааснаар зөвшөөрсөн бол
- 2) Эцэг, эх байх эрхээ хасуулсан бол
- 3) Эцэг эхийг нь хаана байгааг тогтоох боломжгүй байгаа бол

2. Гэр бүлийн шүүх нь доор дурьдсан аль нэг тохиолдол байвал эцэг, эх зөвшөөрөл шаардахгүйгээр энэ хуулийн 867 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу үрчлүүлэх зөвшөөрөл олгож болно.

- 1) Эцэг эх нь 3 жилээс хугацаагаар хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй бол
- 2) Эцэг эх нь хүүхдээ хүчирхийлсэн, хаясан эсхүл хүүхдийн сайн сайхан байдалд ноцтой хохирол учруулсан бол
- 3) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрөлийг энэ хуулийн 867 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу үрчлүүлэх зөвшөөрөл олгохоос өмнө татгалзаж болно.

6. Үрчлэнийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч

Гэр бүлийн шүүх үрчлэгдэгчийн эрх ашгийн төлөө шаардлагатай гэж үзвэл доор дурьдсан мэдээллийг гаргуулахаар холбогдох байгууллагад даалгаж болох бөгөөд тухайн байгууллага нь хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй бол холбогдох мэдээллийг шүүхэд гаргаж өгнө.⁹³

1. Үрчлэгчийн оршин суугаа хаяг, гэр бүлийн байдлыг тодруулах зорилгоор хот, дүүрэг, сумын дарга нарт хандан тодорхойлолт гаргуулах
2. Үрчлэгчийн орлогыг тодруулах зорилгоор татварын байгууллагын даргад хандан хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын тайлан мэдээлэл гаргуулах
3. Үрчлэгчийн гэмт хэрэг үйлдэж ял эдэлж байсан эсэхийг тодруулах зорилгоор цагдаагийн байгууллагын даргад хандан тодорхойлолт гаргуулах
4. Үрчлэгчийн тэжээн тэтгэх чадвар чадамж, сэтгэцийн болон биеийн эрүүл мэндийн байдлыг тодруулах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар эрүүл мэндийн байгууллагын дарга мөн Иргэдийн эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар Иргэдийн эрүүл мэндийн даатгалын байгууллагын даргад хандан эмчилгээний түүхтэй холбоотой мэдээллийг гаргуулах

Үрчлэлтийг бүртгүүлэх

Үрчлэлтийг хуульд заасны дагуу шүүх шийдвэрлэсэн бол талууд үрчлэлтийг гэр бүлийн бүртгэлд бүтгүүлнэ. Хэрэв үрчлэгдэгч 13 нас хүрээгүй бол үрчлүүлэхийг зөвшөөрсөн хууль ёсны төлөөлөгч бүртгүүлнэ.⁹⁴

Үрчлэлтийг бүртгүүлэх газар

Үрчлэлтийг үрчлэгчийн оршин байга газар эсхүл хүсэлт гаргагчийн оршин суугаа хот дүүрэг, сум, тосгоны бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.⁹⁵ Харин гадаад улсад түр болон байнга оршин сууж байгаа БНСУ-ын иргэний хувьд гадаад дахь иргэдийн бүртгэлийн байгууллагад (консул) бүртгүүлж болно.⁹⁶

⁹³ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.9 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#J45:9>

⁹⁴ БНСУ-ын Гэр бүлийн бүртгэлийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=252651&efYd=20240719#0000>

⁹⁵ БНСУ-ын Гэр бүлийн бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 1-2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=252651&efYd=20240719#0000>

⁹⁶ БНСУ-ын Гэр бүлийн бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=252651&efYd=20240719#0000>

Үрчлэлтийг бүртгүүлэх хүсэлт

Үрчлэлтийг бүртгүүлэх хүсэлтэд дараах мэдээллийг тусгана.⁹⁷

1. Талуудын овог нэр, төрсөн он сар өдөр, иргэний дугаар, хүйс
2. Гадаад улсын иргэн бол овог нэр, төрсөн он сар өдөр, гадаад иргэний үнэмлэхний дугаар, хүйс

Мөн дараах бичиг баримтын хавсаргана.

1. Үрчлэлтийг зөвшөөрсөн тодорхойлолт
2. Үрчлэлтийг зөвшөөрсөн Гэр бүлийн шүүхийн шийдвэр
3. Эцэг эхийн зөвшөөрөлтэй холбоотой гаргасан шүүхийн шийдвэр
4. Эцэг эх гадаад улсын иргэн бол нотлох бичиг баримтын хуулбар
5. Үрчлэгдэгч гадаадын улсын иргэн бол тухайн улсын хууль тогтоомжоор тухайн хүүхдийн болон гуравдагч этгээдийн зөвшөөрөл эсхүл зөвшөөрөл шаардлагатай бол шаардлагыг хангасан тухай бичиг баримт
6. Хүсэлт гаргагчийн иргэний үнэмлэхний хуулбар
7. Үрчлэгдэгчийн гэр бүлийн бүртгэлийн тодорхойлолт, үрчлэлттэй холбоотой тодорхойлолт(цахим бүртгэлийн сангаар баталгаажуулах боломжтой бол шаардахгүй)

Үрчлэлтийг бүртгүүлэх хугацаа

Үрчлэлтийг Гэр бүлийн бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгүүлэх бөгөөд бүртгүүлснээр хууль зүйн үр дагавар бий болно. Бүртгэлтэй холбоотой тухайлан тогтоосон хугацаа байхгүй болно.⁹⁸

Үрчлэлтийг хүчингүйд тооцох, гомдол гаргах хугацаа

БНСУ-ын Иргэний хуульд заасан үрчлэлттэй холбоотой журмыг зөрчсөн дараах үндэслэл байна гэж үзвэл Гэр бүлийн шүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцуулах тухай нэхэмжлэл гаргаж болно.

⁹⁷ БНСУ-ын Гэр бүлийн бүртгэлийн тухай хуулийн 61 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=252651&efYd=20240719#0000>

⁹⁸ БНСУ-ын Иргэний хуулийн 878 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#J883:0>

1. Насанд хүрээгүй хүн үрчлэгч болсон болон⁹⁹ БНСУ-ын Иргэний хуульд заасан үрчлэлтийг хүчингүйд тооцох дараах үндэслэл¹⁰⁰ байгаа бол үрчлэгч, үрчлүүлэгч болон тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч эсхүл цусан төрлийн хүн шүүхэд нэхэмжлэл гаргана.¹⁰¹
 - (1) Иргэний хуулийн 866,869.1,869.3.2, 870.1, 871.1, 873.1, 874 дэх зүйлийг зөрчсөн бол¹⁰²
 - (2) Үрчлэгч эсхүл үрчлүүлэгч нь үрчлэлтийн үед хэн аль нэг талын сөрөг ноцтой зан байдал болон бусад ноцтой байдлын талаар мэдээгүй бол¹⁰³
 - (3) Хууран мэхэлж эсхүл албадлагаар үрчлэлтийг хүлээн зөвшөөрүүлсэн бол¹⁰⁴
 - (4) Насанд хүрээгүй үрчлэгч насанд хүрснээр БНСУ-ын Иргэний хуулийн 866 дугаар зүйлд заасаныг зөрчсөн үндэслэлээр үрчлэлтийг хүчингүйд тооцуулахтай холбоотой **гомдол гаргах хугацаа дуусгавар** болно.¹⁰⁵
2. Хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг авалгүй 13 наснаас дээш насанд хүрээгүй хүнийг үрчилж авсан бол¹⁰⁶ үрчлэгдэгч эсхүл зөвшөөрөл өгөх эрхтэй этгээд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар гом дол гаргана.¹⁰⁷

Үрчлэгдэгч насанд хүрснээс хойш 3 сар өнгөрсөн эсхүл нас барсан тохиолдолд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар гомдол гаргах боломжгүй болно.¹⁰⁸ Мөн үрчлэлтийг хүчингүй болгуулах үндэслэл байгааг мэдсэн өдрөөс хойш 6 сар эсхүл хүчингүй болгуулах үндэслэл бий болсон өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн бол үрчлэлтийг

⁹⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 866 дугаар зүйл. Үрчлэгчийн чадамж.

Үрчлэгч насанд хүрсэн байна.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁰⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйл. Үрчлэлтийг хүчингүйд тооцох

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J883:0>

¹⁰¹ БНСУ-ын Иргэний хуулийн 885 дугаар зүйл. Үрчлэлтийг хүчингүйд тооцуулах нэхэмжлэл гаргах этгээд. Үрчилж авсан эцэг, эх, үрчлэгдэгч тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, цусан төрлийн хүн энэ хуулийн 866 дугаар зүйлд заасныг зөрчсөн үндэслэлээр үрчлэлтийг хүчингүй болгуулахаар Гэр бүлийн шүүхэд гомдол гаргаж болно.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁰² БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁰³ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁰⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁰⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 889 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁰⁶ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 869 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁰⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 886 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁰⁸ БНСУ-ын Иргэний хуулийн 891 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

хүчингүйд тооцуулахаар **гомдол гаргах хугацааг дуусгавар** болсонд тооцно.¹⁰⁹

3. Хууль ёсны төлөөлөгч хаана байгаа нь тодорхойгүй эсхүл холбогдох зөвшөөрлийг аваагүй бол үрчлэлтийг хүчингүй болгуулахаар үрчлэгдэгч эсхүл зөвшөөрөл өгөх эрхтэй этгээд¹¹⁰ Гэр бүлийн шүүхэд гомдол гаргана.¹¹¹
Үрчлэгдэгч насанд хүрснээс хойш 3 сар өнгөрсөн эсхүл нас барсан бол¹¹² мөн үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл байгааг мэдсэн өдрөөс хойш 6 сар өнгөрсөн эсхүл үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл бий болсон өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн бол **гомдол гаргах хугацаа дуусгавар болсон гэж үзнэ.**¹¹³
4. Үрчлэгдэгч 13 хүртэл насны насанд хүрээгүй хүүхэд эсхүл 13 дээш насны насанд хүрээгүй хүүхдийг түүний эцэг эхийн зөвшөөрөлгүй үрчилсэн бол үрчлэгдэгч болон үрчлэлтийг зөвшөөрөх эрхтэй хүн үрчлэлтийг хүчингүй болгуулахаар Гэр бүлийн шүүхэд гомдол гаргана.¹¹⁴ Үрчлэгдэгч насанд хүрснээс хойш 3 сар өнгөрсөн эсхүл нас барсан бол¹¹⁵ эсхүл үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл байгааг мэдсэн өдрөөс хойш 6 сар өнгөрсөн эсхүл үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл бий болсон өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн бол гомдол гаргах хугацаа дуусгавар болсон гэж үзнэ.¹¹⁶
5. Насанд хүрсэн үрчлэгдэгчийн эцэг, эх хаана байгаа нь тогтоогдоогүй үндэслэлээр тэдний зөвшөөрлийг авах боломжгүй байх нөхцөлөөс бусад нөхцөлд тухайн зөвшөөрлийг аваагүй бол зөвшөөрөл өгөх эрхтэй этгээд¹¹⁷ Гэр бүлийн шүүхэд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар гомдол гаргана.¹¹⁸ Үрчлэгдэгч нас барсан¹¹⁹ эсхүл үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэлийг

¹⁰⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 894 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹¹⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 886 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹¹¹ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.1, 869 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹¹² БНСУ-ын Иргэний хуулийн 891 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹¹³ БНСУ-ын Иргэний хуулийн 894 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹¹⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.1, 870 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹¹⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 891 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹¹⁶ БНСУ-ын Иргэний хуулийн 894 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹¹⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 886 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹¹⁸ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.1, 871 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹¹⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 891 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

- мэдсэн өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн бол **гомдол гаргах хугацаа дуусгавар** болсон гэж үзнэ.¹²⁰
6. Насанд хүрээгүй хүүхдийн эцэг эх нь эцэг эх байх эрхээ шүүхээр хасуулсан эсхүл хаана байгаа нь тодорхойгүй шалтгаан байхгүй байхад тэдний зөвшөөрлийг авалгүй үрчилсэн бол¹²¹ үрчлэгдэгч эсхүл зөвшөөрөл өгөх эрхтэй этгээд Гэр бүлийн шүүхэд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар гомдол гаргана.¹²² Үрчлэгдэгч насанд хүрснээс хойш 3 сар өнгөрсөн эсхүл нас барсан¹²³ эсхүл үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэлийг мэдсэн өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн бол **гомдол гаргах хугацаа дуусгавар** болсон гэж үзнэ.¹²⁴
7. Насанд хүрсэн асран хамгаалуулагч өөрийн асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр үрчилж авсан эсхүл үрчлэгдсэн¹²⁵ бол насанд хүрсэн асран хамгаалуулагч эсхүл түүний асран хамгаалагч нь Гэр бүлийн шүүхэд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар гомдол гаргана.¹²⁶ Асран хамгаалагчаар тогтоосон тухай шийдвэр хүчингүй болсноос хойш 3 сарын хугацаа өнгөрсөн¹²⁷ эсхүл үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл байгааг мэдсэн өдрөөс хойш 6 сар өнгөрсөн эсхүл үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл бий болсон өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн бол **гомдол гаргах хугацаа дуусгавар болсон** гэж үзнэ.¹²⁸
8. Эхнэр эсхүл нөхөртэй хүн хамт үрчлээгүй эсхүл аль нэг талынхаа зөвшөөрлийг авалгүй үрчлэгдсэн¹²⁹ бол эхнэр эсхүл нөхөр нь Гэр бүлийн шүүхэд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар гомдол гаргана.¹³⁰ Үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл байгааг мэдсэн өдрөөс хойш 6 сар өнгөрсөн эсхүл үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл бий болсон өдрөөс хойш 1

¹²⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 894 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹²¹ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.1, 870 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹²² БНСУ-ын Иргэний хуулийн 886 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹²³ БНСУ-ын Иргэний хуулийн 891 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹²⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 894 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹²⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.1, 873 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹²⁶ БНСУ-ын Иргэний хуулийн 887 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹²⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 893 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹²⁸ БНСУ-ын Иргэний хуулийн 894 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹²⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.1, 874 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹³⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 888 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

жилийн хугацаа өнгөрсөн бол **гомдол гаргах хугацаа дуусгавар болсон** гэж үзнэ.¹³¹

9. Үрчлэгч эсхүл үрчлэгдэгч нь үрчлэлтийн үед хэн аль нэг талын сөрөг ноцтой зан байдал болон бусад ноцтой байдлын талаар мэдээгүй бол талууд Гэр бүлийн шүүхэд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар гомдол гаргана.¹³² Үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл байгааг мэдсэн өдрөөс хойш 6 сар өнгөрсөн бол **гомдол гаргах хугацаа дуусгавар болсон** гэж үзнэ.¹³³
10. Хууран мэхэлж эсхүл албадлагаар үрчлэлтийг хүлээн зөвшөөрүүлсэн бол хууран мэхлэгдэж эсхүл албадлагад орж үрчлэлтийг хүлээн зөвшөөрсөн хүн Гэр бүлийн шүүхэд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар гомдол гаргана.¹³⁴ Хууран мэхэлсэн тухай мэдсэн эсхүл албадлага дууссанаас хойш 3 сарын хугацаа өнгөрсөн бол **гомдол гаргах хугацаа дуусгавар болсон** гэж үзнэ.¹³⁵

<i>Иргэний хуулийн 866 дугаар зүйл.</i> <i>Үрчлэгч насанд хүрсэн байна.</i>
<i>Иргэний хуулийн 869 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.</i> <i>Үрчлэгдэгч 13 дээш насны насанд хүрээгүй хүн бол хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлийг авна.</i>
<i>Иргэний хуулийн 869 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсэг.</i> <i>Хууль ёсны төлөөлөгч хаана байгаа нь тодорхойгүй зэрэг шалтгаанаар зөвшөөрөл авах боломжгүй бол. (869 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг. Гэр бүлийн шүүх доор дурьдсан аль нэг тохиолдол байвал энэ зүйл 1,2 дахь хэсэгт заасан зөвшөөрөлийг аваагүй боловч үрчлэлтийг зөвшөөрөх шийдвэр гаргаж болно.)</i>
<i>Иргэний хуулийн 870 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.</i> <i>Насанд хүрээгүй үрчлэгдэгчийг эцэг, эхийн зөвшөөрлийг авна.</i>

¹³¹ БНСУ-ын Иргэний хуулийн 894 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹³² БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹³³ БНСУ-ын Иргэний хуулийн 896 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹³⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 884 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹³⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 897, 823 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

Иргэний хуулийн 871 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Үрчлэгдэгч насанд хүрсэн бол эцэг эхийн зөвшөөрлийг авна. Харин эцэг эхийнх нь оршин суугаа газар тодорхойгүй зэрэг шалтгаанаар зөвшөөрөл авах боломжгүй бол хамаарахгүй.
Иргэний хуулийн 873 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Бусдын асрамжид хүн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр үрчилж үрчлэгдэнэ.
Иргэний хуулийн 874 дугаар зүйл. 1. Эхнэр эсхүл нөхөртэй хүн хамтран үрчилнэ. 2. Эхнэр эсхүл нөхөртэй хүн эхнэр эсхүл нөхөр нь зөвсөөрснөөр үрчлэгдэнэ.

Үрчлэлтийг хүчингүйд тооцуулах ажиллагаа

Нэхэмжлэгч

Дээр дурьдсан үрчлэлтийг хүчингүйд тооцуулах тухай үндэслэл тус бүрээр гомдол гаргах эрхтэй этгээд тогтоосон хугацаанд Гэр бүлийн шүүхэд гомдол гаргана.

Хариуцагч: (Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31, 24 дүгээр зүйл)

1. Үрчилж авсан эцэг, эх, үрчлэгдэгчийн аль нэг нь үрчлэлтийг хүчингүй болгох талаар шүүхэд нэхэмжлэл гаргавал нөгөө тал нь хариуцагч байна.
2. Гуравдагч этгээд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргавал үрчилж авсан эцэг, эх, үрчлэгдэгч хамтран хариуцагч байх бөгөөд эдгээрийн аль нэг нь нас барсан тохиолдолд бусад нь хариуцагч байна.
3. Хариуцагч болох тал бүгд нас барсан тохиолдолд прокурор хариуцагч байна.

Шүүхийн харьяалал

Үрчлэлтийг хүчингүйд тооцуулах үндэслэлээр гаргах нэхэмжлэлийг үрчилж авсан эцэг, эхийн хэн алины оршин суугаа газрын Гэр бүлийн шүүхэд гаргах бөгөөд үрчилж

авсан эцэг, эх бүгд нас барсан тохиолдолд тэдны хэн алины хамгийн сүүлд оршин сууж байсан газрын Гэр бүлийн шүүхэд гаргана.¹³⁶

Нэхэмжлэгч солигдох

Нэхэмжлэгч нас барах эсхүл бусад шалтгаанаар(хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн чадамжгүй болохоос бусад) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй болсон тохиолдолд өөр этгээд нэхэмжлэгчээр үргэжлүүлэн оролцож болно. Нэхэмжлэгчээр оролцох хүсэлтээ нэхэмжлэгч цаашид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй болсон тэр үеэс эхлэн 6 сарын дотор хүсэлт гаргах бөгөөд хүсэлт гаргаагүй бол нэхэмжлэлээсээ татгалзсанд тооцно.¹³⁷

Шүүхийн шийдвэрийн хууль зүйн үр дагавар

1. Үрчлэлтийг хүчингүйд тооцсон тухай шүүхийн шийдвэр нь гуравдагч этгээдэд мөн хууль зүйн үр дагавар бий болгох бөгөөд өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчоос бусад этгээдэд хамааруулж үрчлэлтийг хүчингүй болгуулахаар хандаж болно.¹³⁸
2. Үрчлэлтийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзсан шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиолдолд гомдол гаргагч шүүх хуралдаан дуусахаас өмнө шүүх хуралдаанд оролцох боломжгүй байсан тухай хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй бол дахин гомдол гаргах боломжгүй байна.¹³⁹

4) Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тооцох болон тус шийдвэрийг хүчингүйд тооцох

Асран хамгаалагч(насанд хүрээгүй хүнд) тогтоох, хүчингүй болгох

¹³⁶ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

¹³⁷ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйл. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

¹³⁸ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

¹³⁹ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

Насанд хүрээгүй хүүхдийг төлөөлөх хууль ёсны төлөөлөгч байхгүй эсхүл эрхээ хасуулсан, түдгэлзүүлсэн бол насанд хүрээгүй хүүхдэд асран хамгаалагчийг тогтооно.¹⁴⁰

Гэр бүлийн шүүх эцэг, эх нь хүүхдийг халамжлах үүргээ зөрчсөн эсхүл зөрчих бодиттой нөхцөл байдал бий болсон бол хүүхэд өөрөө болон хүүхдийн төрөл садан, эсхүл прокурор, орон нутгийн засаг захиргааны байгууллагын даргын гомдлоор эцэг, эх байх эрхийг хасах эсхүл түдгэлзүүлж болно.¹⁴¹

Харгалзан дэмжигч(насанд хүрсэн хүнд)

Эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээл, өндөр наслалт болон бусад шалтгаанаар сэтгэцийн хувьд өөрийгөө бүрэн илэрхийлэх боломжгүй насанд хүрсэн хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах, дэмжих зорилгоор харгалзан дэмжигчийн тогтооно.¹⁴²

5) Тэжээн тэтгэх

Тэжээн тэтгэх тухай шийдвэр

Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулах үед хүүхдийг тэжээн тэтгэх асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд харилцан тохиролцож чадаагүй бол Гэр бүлийн шүүх нэхэмжлэлийн дагуу эсхүл өөрийн санаачлагаар тэжээн тэтгэхтэй холбоотой шийдвэр гаргана.Үүнд:¹⁴³

1. Тэтгэлэг төлөгчийг тогтоох
2. Тэтгэлэгийн хэмжээг тогтоох
3. Насанд хүрээгүй хүүхэдтэй уулзах эрх, уулзалтын арга хэлбэрийг тогтоох

Тэжээн тэтгэх тухай шийдвэрийг өөрчлөх

Гэр бүлийн шүүх нь тэжээн тэтгүүлэгчийн ирээдүй, хэрэгцээ шаардлагыг харгалзан шаардлагатай гэж үзвэл эцэг, эх болон тэжээн тэтгүүлэгч, прокурорын

¹⁴⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 928 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁴¹ БНСУ-ын Иргэний хуулийн 924 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁴² БНСУ-ын Иргэний хуулийн 9, 12, 14.2 дугаар зүйл, 959.14 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁴³ БНСУ-ын Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 1,2,4 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

хүсэлтээр мөн өөрийн санаачилагаар тэжээн тэтгэх асуудлын өөрчлөх, түүнтэй холбоотой бусад арга хэмжээг авч болно.¹⁴⁴

Хууль ёс төлөөлөгчийг тогтоох (харилцан тохиролцож гэрлэлт цуцлахад)

Гэрлэлт цуцлах үед талууд тохиролцож хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийн сонгох бөгөөд хэрэв тохиролцоогүй эсхүл тохиролцоонд хүрээгүй бол шүүх тогтооно.¹⁴⁵ Мөн шүүх хүүхдийн ирээдүй, хэрэгцээ шаардлагыг харгалзан үзээд шаардлагатай бол хүүхдийн цусан төрлийн төрөл садан(4 дэх үеийн)гийн хүний гомдлоор Гэр бүлийн шүүх нь хууль ёсны төлөөлөгчийн өөрчилж болно.¹⁴⁶

Хууль ёс төлөөлөгчийг тогтоох (шүүхийн журмаар гэрлэлт цуцлахад)

Шүүхийн журмаар гэрлэлт цуцлахад Гэр бүлийн шүүх хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийг тогтооно.¹⁴⁷

Мөн адил Гэр бүлийн шүүх хүүхдийн ирээдүй, хэрэгцээ шаардлагыг харгалзан үзээд шаардлагатай бол хүүхдийн цусан төрлийн төрөл садан(4 дэх үеийн)гийн хүний гомдлоор хууль ёсны төлөөлөгчийн өөрчилж болно.¹⁴⁸

6) Хүүхдийн тэтгэлэг, тэтгэлгийн хэмжээ өөрчлөх, тэтгэлийг зориулалтын дагуу ашиглаагүй тохиолдол

Хүүхдийн тэтгэлэг

¹⁴⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁴⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 909 дүгээр зүйлийн 4 дүгээр хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйл 1.2 дахь хэсгийн Ү 5 .

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

¹⁴⁶ БНСУ-ын Иргэний хуулийн 909 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйл 1.2 дахь хэсгийн Ү 5 .

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁴⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 909 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁴⁸ БНСУ-ын Иргэний хуулийн 909 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйл 1.2 дахь хэсгийн Ү 5 .

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

Хүүхдийн тэтгэлэг гэж 19 хүртэл насны насанд хүүхдийг хамгаалах тэжээн тэтгэхэд шаардагдах зардлыг ойлгоно.¹⁴⁹ Тус улсын Иргэний хуулийн хүрээнд гэрлэлт цуцлуулах үед насанд хүүхдийн тэтгэлэгийн хэмжээг тогтоохдоо талуудын тохиролцоо хэрэв тохиролцож чадаагүй бол Гэр бүлийн шүүх талуудын хүсэлт, хүүхдийн санал, нас, эцэг, эхийн хөрөнгийн байдал болон бусад зүйлийг харгалзан үзэж хэмжээг тогтоохоор хуульчилсан байна.¹⁵⁰ Өөрөөр хэлбэл хүүхдийн тэтгэлэгийн хэмжээг шүүх өөрийн эрх мэдлийн хүрээнд тогтоож болох бөгөөд тусгайлсан хэмжээг хуулиар тогтоож өгөөгүй байна.

Хүүхдийн тэтгэлэг тогтооход харгалзах хүснэгт:

0~2 нас	621,000 264,000~ 686,000	752,000 687,000 ~ 848,000	945,000 849,000~ 1,021,00 0	1,098,000 1,022,000 ~1,171,00 0	1,245,00 0 1,172,00 0~1,323, 000	1,401,00 0 1,324,00 0~1,491, 000	1,582,000 1,492,000 ~1,685,00 0	1,789,000 1,686,000~ 1,893,000	1,997,000 1,894,000~ 2,046,000	2,095,000 2,047,000~ 2,151,000	2,207,000 2,152,000 дээш
3~5 нас	631,000 268,000~ 695,000	759,000 696,000 ~ 854,000	949,000 855,000~ 1,031,00 0	1,113,000 1,032,000 ~ 1,189,000	1,266,00 0 1,190,00 0~1,344, 000	1,422,00 0 1,345,00 0~1,510, 000	1,598,000 1,511,000 ~1,702,00 0	1,807,000 1,703,000~ 1,912,000	2,017,000 1,913,000~ 2,066,000	2,116,000 2,067,000~ 2,180,000	2,245,000 2,181,000 дээш
6~8 нас	648,000 272,000~ 707,000	767,000 708,000 ~ 863,000	959,000 864,000~ 1,049,00 0	1,140,000 1,050,000 ~ 1,216,000	1,292,00 0 1,217,00 0~1,385, 000	1,479,00 0 1,386,00 0~1,546, 000	1,614,000 1,547,000 ~1,732,00 0	1,850,000 1,733,000~ 1,957,000	2,065,000 1,958,000~ 2,101,000	2,137,000 2,102,000~ 2,224,000	2,312,000 2,225,000 дээш
9~11 нас	667,000 281,000~ 724,000	782,000 725,000 ~ 885,000	988,000 895,000~ 1,139,00 0	1,163,000 1,076,000 ~ 1,240,000	1,318,00 0 1,241,00 0~1,406, 000	1,494,00 0 1,407,00 0~1,562, 000	1,630,000 1,563,000 ~1,758,00 0	1,887,000 1,759,000~ 2,012,000	2,137,000 2,102,000~ 2,224,000	2,180,000 2,159,000~ 2,292,000	2,405,000 2,293,000 дээш
12~14 нас	679,000 295,000~ 734,000	790,000 735,000 ~ 894,000	998,000 895,000~ 1,139,00 0	1,280,000 1,140,000 ~ 1,351,000	1,423,00 0 1,352,00 0~1,351, 000	1,598,00 0 1,511,00 0~1,654, 000	1,711,000 1,655,000 ~1847,000	1,984,000 1,848,000~ 2,071,000	2,159,000 2,072,000~ 2,191,000	2,223,000 2,192,000~ 2,349,000	2,476,000 2,350,000 дээш
15~18 нас	703,000 319,000~ 830,000	957,000 831,000 ~ 1,092,0 00	1,227,00 0 1,093,00 0~1,314, 000	1,402,000 1,315,000 ~ 1,503,000	1,604,00 0 1,504,00 0~1,699, 000	1,794,00 0 1,700,00 0~1,879, 000	1,964,000 1,880,000 ~2,063,00 0	2,163,000 2,064,000~ 2,204,000	2,246,000 2,205,000~ 2,393,000	2,540,000 2,394,000~ 2,711,000	2,883,000 2,712,000 дээш

¹⁴⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 4 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

БНСУ-ын Хүүхдийн тэтгэлэг төлүүлэх, дэмжих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=261455&efYd=20240927#0000>

¹⁵⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 837 дугаар зүйл, 843 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

Тэтгэлэгийн хэмжээ өөрчлөх

Тэтгэлэгийн хэмжээг тогтооноос хойш талууд харилцан тохиролцож **тэтгэлэгийн хэмжээг өөрчилж болох** бөгөөд тохиролцоонд хүрээгүй бол шүүхэд хүсэлт гарган өөрчлүүлж болно.¹⁵¹ Түүнчлэн тэтгэлэг төлөгч ажилгүй болох, дампуурах болон бусад нөхцөл байдлын улмаас түүний санхүүгийн байдал хүндэрсэн бол **тэтгэлэгийн хэмжээг бууруулахаар** хүсэлт гаргаж болно. Мөн хүүхэдтэй хамт амьдарч буй тэжээн тэтгэгч ажил орох зэргээр санхүүгийн байдал нь дээрдсэн бол **тэтгэлэгийн хэмжээг бууруулахаар хүсэлт гаргаж** болно. Амжиргааны өртөг нэмэгдсэн эсхүл хүүхэд дэвшин суралцах зэргээр сургалтын төлбөрт өөрчлөлт орсон бол **тэтгэлэгийн хэмжээг нэмэгдүүлэхээр хүсэлт гаргаж** болно.

Тэтгэлийг зориулалтын дагуу ашиглаагүй тохиолдол

Иргэний хуульд зааснаар хүүхдийн тэтгэлэг нь хүүхдийн төлөө зарцуулагдах ёстой бөгөөд үүнийг зөрчсөн тохиолдолд Гэр бүлийн шүүхэд гомдол гаргах боломжтой байна. Гэхдээ тэтгэлэгийг хүүхдийн төлөө зарцуулаагүй бол гэсэн шууд заасан агуулга хууль байхгүй боловч Иргэний хуулийн 837 дугаар зүйлд зааснаар хүүхдийн төлөө буюу түүний өдөр тутмын хэрэглээ, боловсрол, эрүүл мэнд зэрэгт зарцуулагдах үндсэн зорилготой гэж ойлгоно.

Тиймээс хүүхдийг өсөж бойжих сурч боловсроход саад урчуулах болон хүчирхийлэх гэх мэт хүүхдийн эсрэг аливаа тохиолдол байна гэж үзвэл шүүх хэдийд ч хууль ёсны төлөөлөгчийг сольж болно.¹⁵²

Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар хүүхдэд хэрэгцээ шаардлага байна гэж үзвэл өөрийнх нь болон эцэг, эх, прокурорын хүсэлтээр эсхүл шүүх тэтгэлэгийн хэмжээг багасгах, нэмэгдүүлэх эсхүл хууль ёсны төлөөлөгчийг солих хүртэл арга хэмжээ авч болдог байна. Үүнд хүүхдийн тэтгэлэгийг зориулалтын дагуу буюу хүүхдийн төлөө ашиглаагүй үйлдэл мөн хамаарах бөгөөд тэтгэлэг төлөгч тэтгэлэгийг зориулалтын дагуу ашиглаагүй тухай гомдлыг Гэр бүлийн шүүхэд гарган шүүх нь тэтгэлэг зарцуулсан тайлан зэргийг гаргуулах, хөрөнгө зарцуулах эрхийг өөр этгээдэд шилжүүлэх, шаардлагатай бол хууль ёсны асран хамгаалагчийг солих зэргээр хүүхдийн сайн сайханы төлөө тодорхой шийдвэрүүдийг гаргаж болдог байна.

¹⁵¹ БНСУ-ын Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 5 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг 4-3. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=249997&efYd=20231019#0000>

¹⁵² БНСУ-ын Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 843 дугаар зүйл, 909 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#0000>

7) Эцэг, эх тогтоох, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх, эцэг, эх байх эрх, үүргээ хэрэгжүүлэхэд саад болсонтой холбоотой

1. Эцэг, эх тогтоох

Үндэслэл

Тус улсын Иргэний хуулийн 844 дүгээр зүйлд зааснаар гэрлэлтийн үед эхнэр нь жирэмсэн болсон бол хүүхдийг нөхрийн хүүхэд гэж үзнэ(*таамаглана*).¹⁵³ Гэрлэлт хүчин төгөлдөр болсноос хойш 200 хоногын дараа төрсөн хүүхдийг гэрлэлтийн үед жирэмсэн болсон гэж үзнэ.¹⁵⁴ Гэрлэлт дуусгавар болсон өдрөөс хойш 300 хоногын дотор төрсөн хүүхдийг гэрлэлтийн жирэмсэн болсон гэж үзнэ.¹⁵⁵

Дахин гэрлэсэн эмэгтэйдээс төрсөн хүүхдийг дээр дурьдсан Иргэний хуулийн 844 дүгээр зүйлд заасны дагуу эцгийг тогтоох боломжгүй бол шүүх тогтооно.¹⁵⁶ Эцэг тогтоолгох гомдлыг эхнэр, нөхөр хүүхдийг хамааруулж гаргах бөгөөд хүүхдийн эцгийг тогтоох шаардлагатай гэдгийг мэдсэн өдрөөс 2 жилийн дотор гомдол гаргах эрхтэй байна.¹⁵⁷ Хариуцагчид нас барсан бол прокурор хариуцагч болох бөгөөд нас барсныг мэдсэн өдрөөс хойш 2 жилийн дотор гомдлыг шүүхэд гаргана.¹⁵⁸

Хүүхэд нас барсан бол эхнэрийн эсрэг, эхнэр нь байхгүй бол прокурорын эсрэг гомдол гаргаж болох¹⁵⁹ бөгөөд эхнэр, нөхөр нь гэрээслэлдээ хүүхдийг өөрийн төрсөн хүүхэд эсэхийг тогтоолгох тухай заасан бол гэрээслэлийг биелүүлэгч гомдлыг шүүхэд гаргана.¹⁶⁰ Мөн нөхөр нь хүүхдийг төрөхөөс өмнө нас барсан эсхүл эхнэр, нөхөр нь тус хуулийн 847 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд нас барсан бол эхнэр, нөхрийн төрөл садангийн(цусан төрөл) хүн нас барсныг мэдсэн өдрөөс хойш 2 жилийн шүүхэд гомдол гаргаж болно.¹⁶¹

¹⁵³ БНСУ-ын Иргэний хуулийн 844 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J837:0>

¹⁵⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 844 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J837:0>

¹⁵⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 844 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J837:0>

¹⁵⁶ БНСУ-ын Иргэний хуулийн 845 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J837:0>

¹⁵⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 847 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J837:0>

¹⁵⁸ БНСУ-ын Иргэний хуулийн 847 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J837:0>

¹⁵⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 849 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J837:0>

¹⁶⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 850 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J837:0>

¹⁶¹ БНСУ-ын Иргэний хуулийн 851 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J837:0>

Дээр дурьдсан Иргэний хуулийн 844 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэрлэлт дуусгавар болсноос хойш 300 хоногын дотор төрсөн хүүхдийн эцгийг тогтоохтой холбоотой гомдлыг Гэр бүлийн шүүхэд хүүхдийн эх болон түүний өмнөх нөхөр гаргана.¹⁶² Гэр бүлийн шүүх нь цус, генетикийн шинжилгээ зэрэг шинжлэх ухааны аргыг ашиглан мөн тэдний тусдаа амьдарсан хугацаа бусад хүчин зүйл нөхцөл байдлыг харгалзан шийдвэр гаргана.¹⁶³

Гэрлэлтээс гадуур хүүхэд төрсөн хүүхдийн тухайд Гэр бүлийн шүүхэд хандан өөрийн хүүхэд мөн эсэхийг тогтоолгож болох бөгөөд шүүх нь мөн дээрхийн адил цус, генетикийн шинжилгээ зэрэг шинжлэх ухааны аргыг ашиглан мөн тэдний тусдаа амьдарсан хугацаа бусад хүчин зүйл нөхцөл байдлыг харгалзан шийдвэр гаргана.¹⁶⁴

БНСУ-ын тухайд эцэг тогтоохтой холбоотой асуудал гэр бүлийн хэрэг маргаан биш бөгөөд энэхүү асуудлыг шүүхийн бус журмаар шийдвэрлэдэг байна. Төрсөн эцэг мөн эсэхийг тогтоох нь хүүхдийг төрсний бүртгэл бүртгэх, эцгийн овгийг авах, дагах зэрэгтэй шууд хамааралтай байдаг тул шүүхээс тогтоосон мэргэжлийн байгууллагад шинжилгээ хийлгэж холбогдох шийдвэрийг гаргадаг байна.

Шүүхийн харьяалал

Хүүхдийн харьяалах нутаг дэвсгэрийн Гэр бүлийн шүүхэд харьяагдах бөгөөд хүүхэд нас барсан бол нас барахаас өмнө амьдарч байсан хаягт хамаарах нутаг дэвсгэрийн Гэр бүлийн шүүхээр шийдвэрлэнэ.¹⁶⁵

Эцэг тогтоолгох хүсэлт гаргагч¹⁶⁶

Эцэг тогтоолгох хүсэлтийг хүүхэд, хүүхдийн эх, түүний нөхөр, мөн түүний салсан нөхөр гаргаж болно. Хүүхэд хүсэлт гаргасан бол эх, түүний нөхөр, салсан нөхрийн эсрэг, эх нь хүсэлт гаргасан бол түүний нөхөр, салсан нөхрийн эсрэг гаргана. Эхийн нөхөр хүсэлт гаргасан бол эх, түүний салсан нөхрийн эсрэг, эхийн салсан нөхөр гаргасан бол эх, түүний нөхрийн эсрэг гаргана. Нөгөө тал нас барсан бол прокурорын эсрэг эцэг тогтоолгох хүсэлтийг Гэр бүлийн шүүхэд гаргана.

¹⁶² БНСУ-ын Иргэний хуулийн 854.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J1057:0>

¹⁶³ БНСУ-ын Иргэний хуулийн 854.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J1057:0>

¹⁶⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 855, 852.2 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J1057:0>

¹⁶⁵ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

¹⁶⁶ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

Шинжилгээ хийлгэх тухай захирамж

Гэр бүлийн шүүх зохигчид болон холбогдох этгээдийн хооронд цусан төрлийн холбоо байгаа, эсхүл байхгүй гэдгийг бусад нотлох баримтын хүрээнд тогтоох боломжгүй байгаа тэдний эрүүл мэнд, нэр төрд хохирол учруулахгүйгээр цусны бүлгийн шинжилгээ болон удамшлын хүчин зүйлийн шинжилгээ болон бусад холбогдох болмжит шинжилгээг хийлгэхийг даалгаж захирамж гаргаж болно.¹⁶⁷

Энэхүү захирамжийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол Гэр бүлийн шүүх, Эвлэрүүлэн зуучлалын зөвлөл, эвлэрүүлэн зуучлал хариуцсан шүүгч өөрөө болон шинжилгээг хариуцагчийн хүсэлтээр арван сая хүртэл воноор торгох арга хэмжээ авна.¹⁶⁸

2. Эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, түдгэлзүүлэх, сэргээх

Тус улсын Иргэний хуулийн 924 дүгээр зүйлд зааснаар **эцэг эх нь өөрсдийн эрхийг хэтрүүлэх, урвуулах байдлаар хүүхдийн эрх ашиг сонирхолыг илтэд зөрчсөн, эсхүл зөрчигдөх эрсдэлтэй нөхцөл байдал байна гэж үзвэл Гэр бүлийн шүүх хүүхэд, хүүхдийн төрөл садан, прокурор эсхүл орон нутгийн засаг захиргааны байгууллагын даргын гомдлоор эцэг, эх байх эрхийг **хасах, түдгэлзүүлэх**, зарим эрхийг **хязгаарлах** тухай шийдвэр гаргана.**¹⁶⁹

Түдгэлзүүлэх

Гэхдээ эцэг, эх өөрсдийн эрхийг хэтрүүлсэн, урвуулснаар эцэг, эх байх эрхийг хасна гэж ойлгож болохгүй бөгөөд энэ нь тодорхой дараалал харгалзан үзэх нөгцөлүүдийг шаарддаг байна. Шүүх хүүхдийн эрх ашиг сонирхолыг хамгаалах үүднээс эцэг, эх байх эрхийг түр зогсоох буюу түдгэлзүүлэхдээ хүүхдийн байгаа нөхцөл байдал, түүнийг тэжээн тэтгэж буй байдал болон бусад нөхцөл байдлуудыг харгалзан үзэж шийдвэр гаргах ёстой байна. Энэ тохиолдолд **түдгэлзүүлэх хугацаа нь хоёр жилээс хэтрэхгүй** байна.¹⁷⁰ Энэхүү хугацааг сунгах шаардлагатай гэж үзвэл Гэр бүлийн шүүх хүүхэд, хүүхдийн төрөл садан, прокурор эсхүл орон нутгийн засаг захиргааны байгууллагын дарга, асран хамгаалагч, асран хамгаалалтад хяналт тавигчийн гомдлоор нэг удаа хоёр хүртэл жилийн хугацаагаар сунгаж болно.¹⁷¹

¹⁶⁷ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

¹⁶⁸ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=249997&efYd=20231019#0000>

¹⁶⁹ БНСУ-ын Иргэний хуулийн 924 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁷⁰ БНСУ-ын Иргэний хуулийн 924 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁷¹ БНСУ-ын Иргэний хуулийн 924.2 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

Эцэг, эх байх эрхийг хэсэгчлэн хязгаарлах

Гэр бүлийн шүүх нь хүүхдийн байнга болон түр оршин суух газар, хүүхдийн хувийн байдалтай холбоотой бусад болон зарим шийдвэрийг түүний эцэг, эх гаргахдаа хүүхдийн ашиг сонирхолд нийцэхгүй, илтэд хохиролтой байдлаар гаргасан эсхүл эрх ашиг нь зөрчигдөх эрсдэлтэй нөхцөл байдал байна гэж үзвэл хүүхэд, хүүхдийн төрөл садан, прокурор эсхүл орон нутгийн засаг захиргааны байгууллагын даргын гомдлоор тодорхой хязгаарыг тогтоон эцэг, эхийн хүүхдийн талаар зарим эрхийг хязгаарласан шийдвэр гаргаж болно.¹⁷²

Хууль ёсны төлөөлөх, хөрөнгө эрхлэх хариуцах эрхийг хасах

Гэр бүлийн шүүх нь хүүхдийн хууль ёсны төлөөлөгч болох эцэг, эх нь хүүхдийн хөрөнгийг эрхлэн хариуцах үүргээ зүй ёсоор биелүүлээгүйн улмаас түүний хөрөнгөд хохирол учруулсан бол хүүхдийн төрөл, садан, прокурор эсхүл орон нутгийн засаг захиргааны байгууллагын даргын гомдлоор хууль ёсоор төлөөлөх эрх, эд хөрөнгө эрхлэн хариуцах эрхийг хасаж болно.¹⁷³

Эрх хасах, хязгаарлах, түдгэлзүүлэхэд тавигдах шаардлага

Шүүх эцэг, эх байх эрхийг бүрэн болон хэсэгчлэн хасах, хязгаарлах, түдгэлзүүлэх арга хэмжээг авах тухай шийдвэрийг гаргахдаа хүүхдийн эрх ашгийг хамгаалахын тулд авч хэрэгжүүлж болохуйц өөр ямар нэгэн арга хэрэгсэл байгаа эсэхийг нягтлан шалгасны эцэст дээрх арга хэмжээг эцсийн боломжит шийдвэр гэж дүгнэн зохих шийдвэрийг гаргана.¹⁷⁴ Ийнхүү эрхээ хасуулсан, хязгаарлуулсан, түдгэлзүүлсэн боловч хуульд заасан бусад эрх үүргээ хэвийн хэрэгжүүлнэ.¹⁷⁵

Сэргээх

Гэр бүлийн шүүх эцэг, эх байх эрхийг хассан, хязгаарласан, түдгэлзүүлсэн тухай шийдвэрийг гаргахад үндэслэл шалтгаан болсон нөхцөл байдал бүрэн арилсан гэж үзвэл шүүх өөрөө, хүүхэд, түүний төрөл садан, прокурор эсхүл орон

¹⁷² БНСУ-ын Иргэний хуулийн 924 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁷³ БНСУ-ын Иргэний хуулийн 925 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁷⁴ БНСУ-ын Иргэний хуулийн 925.4 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁷⁵ БНСУ-ын Иргэний хуулийн 925.3 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

нутгийн засаг захиргааны байгууллагын даргын хүсэлтээр эрхийг сэргээх тухай шийдвэр гаргана.¹⁷⁶

3. Дундын өмчийн хөрөнгийн маргааныг шийдвэрлэх

1. Гэрлэгчдийн хамтын үйл ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгө буюу дундын хөрөнгө¹⁷⁷

Гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд хөрөнгө бий болоход гэрлэгчид нь хувь нэмрээ оруулсан хөрөнгө нь хуваах хөрөнгөд тооцогдоно. Тухайн хөрөнгөд үл хөдлөх хөрөнгөөс гадна бэлэн мөнгө хадгаламжийг оруулан тооцох бөгөөд хөрөнгийн өмчлөгч эзэмшигч нь хэний нэр дээр байхаас үл хамааран хуваах хөрөнгө байна.¹⁷⁸ Өөрөөр хэлбэл тухайн хөрөнгө нь гэрлэгчдийн хэний нэр дээр бүртгэлтэй байхаас үл хамаарч бодитоор хөрөнгийг бий болгоход гэрлэгчдийн хамтын үйл ажиллагаа хувь нэмэр байсан тохиолдолд хуваах хөрөнгөд тооцогдоно. Түүнчлэн тухайн хамтын үйл ажиллагаа хувь нэмэрт эхнэрийн гэрийн ажил мөн тооцогдоно.¹⁷⁹ Мөн гэрлэгчдийн хэн нэг нь тусдаа амьдарч эхэлснээс хойш олж авсан хөрөнгө нь тусдаа амьдарч эхлэхээс өмнө гэрлэгчдийн хамтын үйл ажиллагаа хувь нэмрийн дагуу бий болж бүрэлдсэн тохиолдолд хуваах хөрөнгөд тооцогдоно.¹⁸⁰

Гэрлэгчдийн гэр бүл болохоосоо өмнө байсан хуваарьт хөрөнгө нь хуваах хөрөнгөд тооцогдохгүй боловч гэрлэгчид нь тухайн хуваарьт хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх болон үнэ цэнэ нь буурахаас хамтын үйл ажиллагааны үр дүнд сэргийлж хувь нэмрээ оруулсан бол тухайн эд хөрөнгө үнэ цэнэ өссөн хэмжээгээр хуваах хөрөнгөд тооцогдож болно.¹⁸¹

Гэрлэгчдийн хэн нэг нь гуравдагч этгээдтэй хамтран өмчилж эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эзэмшиж байгаа хувийг шууд хуваах эд хөрөнгөд тооцох боломжгүй боловч эзэмшиж байгаа хувийг үнэлэн түүнийг хуваах хөрөнгөд тооцож болох тухай шүүхийн шийдвэрт мөн дурьдсан байна.¹⁸²

Хуваах эд хөрөнгө /шүүхийн шийдвэр/

¹⁷⁶ БНСУ-ын Иргэний хуулийн 926 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#0000>

¹⁷⁷ БНСУ-ын Иргэний хуулийн 847 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=251069&efYd=20240517#J1057:0>

¹⁷⁸ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 1999.6.11, 96 므 1397.

¹⁷⁹ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대결 1993.5.11, 93 스 6.

¹⁸⁰ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 1999.6.11, 96 므 1397.

¹⁸¹ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대결 2002.8.28, 2002 스 36.

¹⁸² БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 2009.11.12, 2009 므 2840·2857.

Гэрлэгчдийн хэн нэгний өвлөж авсан эд хөрөнгө болон өвлөж авсан эд хөрөнгийг худалдан борлуулсны үр дүнд бий болсон үл хөдлөх эд хөрөнгийг эзэмшиж ашиглахад нөгөө тал нь гэрийн ажил хийх болон бусад хэлбэрээр шууд болон шууд бус байдлаар хувь нэмрээ оруулсан тохиолдолд тухайн хөрөнгө нь хуваах эд хөрөнгөнд тооцогдоно.¹⁸³

Эд хөрөнгө бий болгоход эхнэрийн хичээл зүтгэл болон хөрөнгийн оролцоо давуу байдалтай байсан боловч нөхөр нь гэр бүлийн өдөр тутмын хэрэглээний болон бусад зардлыг бий болгох зэргээр тухайн эд хөрөнгийг эзэмших ашиглах болон үнэ цэнийг нь өсгөхөд шууд болон шууд бус хэлбэрээр хувь нэмрээ оруулж байсан тохиолдолд хамтын үйл ажиллагааны хүчинд бий болгосон хөрөнгө гэж үзэн тухайн эд хөрөнгийг хуваах эд хөрөнгөнд тооцно.¹⁸⁴

Нөхөр нь гэр бүлийн өдөр тутмын ажилд хувь нэмрээ зохих хэмжээгээр орулдаггүй байсан нь хуваах эд хөрөнгийн үнэ болон аргад нөлөөлж болох боловч тухайн хөрөнгийг бий болгоход хувь нэмрээ огт оруулаагүй гэж үзэх үндэслэл болохгүй.¹⁸⁵

2. Тэтгэвэр, буцалтгүй тусламж

Өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламж

БНСУ-ын шүүх нь буцалтгүй тусламжийг гэр бүл салах үед хуваах эд хөрөнгөд оруулан тооцож иржээ. Гэвч гэрлэлтээ албан ёсоор цуцлуулах үед дээрх тусламжийг авсан байх тохиолдолд л хуваах эд хөрөнгөд тооцдог байв.¹⁸⁶ Гэрлэлтээ албан ёсоор цуцлуулах үед тэтгэвэр тогтоолгох хугацаа болон авах буцалтгүй тусламжтай холбоотой шийдвэр гарснаас бусад тохиолдолд буюу тэтгэвэрээ албан ёсоор тогтоолголгүйгээр ажил үүргээ гүйцэтгэж байгаа үед ирээдүйд авах буцалтгүй тусламжийг хуваах эд хөрөнгөд тооцож болохгүй хэмээн шүүхээс үзэж байжээ.¹⁸⁷ БНСУ-ын шүүх нь гэрлэлтээ цуцлуулсны дараа эхнэр нөхрийн хэн нэг нь тэтгэвэр тогтоолгон нэг удаагийн буцалтгүй тусламжийг авсан ба хөрөнгө хуваах нэхэмжлэл гаргах хугацаа хүчин төгөлдөр байгаа тохиолдолд гэр бүл болсон өдрөөс хойш гэрлэлтээ цуцлуулах шүүхийн эцсийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл

¹⁸³ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 1998.4.10, 96 므 1434, 대결 2009.6.9, 2008 스 111(энэ тохиолдолд гэрлэгчдийн хэн нэг нь гуравдагч этгээдээс өвлөж авсан эд хөрөнгийн хувьд ч мөн адил гэж үзсэн байна).

¹⁸⁴ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 1997.12.26, 96 므 1076, 1083.

¹⁸⁵ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대법원 1995. 10. 12. 선고 95 므 175, 95 므 182.

¹⁸⁶ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 1995.3.28, 94 므 1584.

¹⁸⁷ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대결 2002.8.28, 2002 스 36.

хугацааны хөдөлмөрийн үр дүнд олгосон нэг удаагийн буцалтгүй тусламжийн холбогдох хэсгийг хуваах эд хөрөнгөд тооцно гэж шийдвэрлэж байжээ.¹⁸⁸

Гэвч БНСУ-ын Дээд шүүхийн бүх шүүгчдийн санал нэгдсэн тогтоолоор дээрх шүүхийн шийдвэрийг өөрчилсөн байна. Энэхүү тогтоолд эхнэр нөхрийн хэн нэг нь ажил хөдөлмөр эрхлэхэд хэн нэг нь өөрийн хувь нэмрээ оруулсан нь тогтоогдвол тухайн нэг удаагийн буцалтгүй тусламж нь хуваах хөрөнгөд тооцогдох бөгөөд гэрлэлтээ цуцлуулах үед тэтгэвэрээ тогтоолгоогүй гэсэн шалтгаанаар буцалтгүй тусламжийг хуваах хөрөнгийн тооноос хасах нь шударга бус гэж үзжээ. Тиймээс гэрлэлтээ цуцлуулах үед эхнэр нөхрийн хэн нэг нь тэтгэвэрээ тогтоолгоогүй ажил үүргээ гүйцэтгэж байгаа ч гэрлэлт цуцлуулах шүүхийн процесс хүртэлх хугацаанд ажиллаж хөдөлмөрлөсний үр дүнд тухайн нэг удаагийн буцалтгүй тусламжийг авах эрх нь бий болох боломж өндөр байх тул буцалтгүй тусламжийн эдийн засгийн үр ашгийг тооцон хуваах эд хөрөнгөд тооцох нь зүйтэй хэмээн үзжээ.¹⁸⁹

Тэтгэвэр

Гэр бүлийн хамтын амьдралын туршид эхнэр нөхрийн хэн нэг нь нөгөө талынхаа ажил хөдөлмөр эрхлэхэд хувь нэмрээ оруулж байсан нь тогтоогдсон тохиолдолд тэтгэвэрийг(төрийн албан хаагчийн) эхнэр нөхрийн хамтын үйл ажиллагааны үрд дүнд бий болсон гэж үзэх бөгөөд хөрөнгө хуваах зорилгод үл харшлахаас бусад тохиолдолд тэтгэвэрийг үл хөдлөх хөрөнгийн нэгэн адил хуваах хөрөнгөд тооцно гэжээ.¹⁹⁰ Цаашлаад тэтгэвэр авагчийн сар бүр авах тэтгэвэрийн тодорхой хувийг урт хугацаанд нөгөө талд нь олгох байдлаар хөрөнгийг хуваах боломжтой гэжээ.

Мөн БНСУ-ын Үндэсний тэтгэвэрийн тухай хуулийн 64 дугаар зүйлд “Эхнэр нөхрийн хамтран амьдарсан хугацаа таваас дээш жил болсон эхнэр, нөхөр гэрлэлтээ цуцлуулсан, эхнэр, нөхөр байсан этгээд нь өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, 60 насанд хүрсэн зэрэг шаардлагыг хангасан тохиолдолд амьд байх хугацаандаа эхнэр, нөхөр байсан этгээдийн өндөр насны тэтгэвэрийн тодорхой хувийг хуваан авч болно” гэж заажээ.

4. Хүүхдийн хуваарьт хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах

Хүүхдийн хөрөнгийн эрхийн талаар БНСУ-ын Иргэний хуулийн 916-927 дугаар зүйлд¹⁹¹ зохицуулсан байна. Хүүхэд өөрийн нэрээр олж авсан хөрөнгө нь хүүхдийн хуваарьт хөрөнгө байх бөгөөд түүний хууль ёсны төлөөлөгч, асран тэтгэгч нь тухайн

¹⁸⁸ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대결 2000.5.2, 2000 스 13.

¹⁸⁹ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판(정원)2014.7.16, 2013 므 2250/핵심판례 368 면/.

¹⁹⁰ БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판(정원)2014.7.16, 2012 므 2288.

¹⁹¹ БНСУ-ын Иргэний хууль. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#J916:0>.

хөрөнгийг эрхлэн хариуцна.¹⁹² Мөн тухайн хөрөнгөтэй холбоотой хууль зүйн үйлдэлд хүүхдийг төлөөлнө. Гуравдагч этгээд хүүхдэд хөрөнгө өгч асран тэтгэгчийг тухайн хөрөнгийг эрхлэн хариуцаж хамгаалахын эсрэг саналтай байвал эрхлэн хариуцах эрхгүй бөгөөд өөрөө эсхүл шүүхээс хөрөнгийг эрхлэн хариуцагчийг томилно. Хууль ёсны төлөөлөгч хүүхдийн хөрөнгийн жагсаалтыг зарцуулсан тооцоо зэргийг хөтлөх бөгөөд өөр зорилгоор зарцуулсан бол зарцуулсан өдрөөс хүү тооцон учирсан хохиролыг нөхөн төлнө.¹⁹³

Өөрөөр хэлбэл хүүхдийн хуваарьт хөрөнгийг эрхлэх хариуцах эрх нь түүний хууль ёсны төлөөлөгч байх бөгөөд тухайн хөрөнгийг эрхлэн хариуцах эрх дуусгавар болоход тухайн хөрөнгийн талаар тайлан гаргаж өгөх үүрэгтэй байдаг байна. Тухайн хөрөнгийн талаарх тайлангийн талаар Иргэнийн хуулийн 923 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан байх бөгөөд тайлан гэдэг нь “хүүхдийн хөрөнгийг эрхлэн хариуцаж байх хугацаанд хөрөнгийн үнэ цэнэ, хэмжээ нэмэгдсэн болон хасагдсан эсэх үлдсэн хөрөнгийн хэмжээ зэргийг тодорхой бичиж тайлагнах”-ыг ойлгодог байна. Түүнчлэн хөрөнгө эрхлэн хариуцах хугацаа дуусмагц эцэг, эх буюу хууль ёсны төлөөлөгч нь Иргэний хуулийн 683, 684 дүгээр зүйлд¹⁹⁴ заасан хөрөнгө итгэмжлэн хариуцаж буй этгээд хөрөнгийг итгэмжлэн хариуцах хугацаа дуусмагц буцаан өгнө гэсний дагуу хуваарьт хөрөнгийг хүүхдэд болон түүний хууль ёсны төлөөлөгчид шилжүүлэн өгөх үүрэгтэй байна.

2. ЯПОН УЛС

1) Гэрлэлт цуцлалт, гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцох, гэрлэлт цуцлахтай холбоотой гэм хорын нэхэмжлэл, гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох

(1) Гэрлэлт цуцлалт

Гэрлэлтийг дараах аргаар цуцалж болно.

- c. Харилцан тохиролцох журмаар(захиргааны)
- d. Шүүхийн журмаар

a. Харилцан тохиролцох журмаар гэрлэлт цуцлах(захиргааны)

¹⁹² БНСУ-ын Иргэний хуулийн 916 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#J1057:0>

¹⁹³ БНСУ-ын Иргэний хууль 923 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#J1057:0>

¹⁹⁴ БНСУ-ын Иргэний хууль 683,684 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=251069&efYd=20240517#J1057:0>

Тус улсын Иргэний хуулийн 763 дугаар зүйлд зааснаар харилцан тохиролцож буюу захиргааны журмаар гэрлэлт цуцлуулдаг байна. Гэрлэлт цуцлах ажиллагаа Гэр бүлийн бүртгэлийн тухай хуульд¹⁹⁵ заасны дагуу явуулна.

- а) Гэрлэлт цуцлах тухай хүсэлтийг гэрлэгчид хамдаа гаргах¹⁹⁶
- б) Насанд хүрээгүй хүүхдийн хууль ёсны асран хамгаалагчийн талаар харилцан тохиролцсон тухайгаа хүсэлтэд дурьдана.¹⁹⁷
- с) Талууд харилцан тохиролцоогүй бол гэрлэлт цуцлах хүсэлтийг хүлээн авахгүй.¹⁹⁸

б. Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах

Үндэслэл

Япон улсын иргэний хуулийн 770 дугаар зүйлд шүүхийн журмаар гэрлэлт цуцлуулах үндэслэлийг зохицуулсан байна.¹⁹⁹

770.1 дэх хэсэг

1. Гэрлэгсэдийн хэн нэг нь зүй бус үйлдэл хийсэн бол
2. Гэрлэгсэд нь хэн нэгийгээ санаатайгаар үл тоомсорлон орхисон бол
3. Гэрлэгсэдийн хэн нэг нь 3-аас дээш жилийн хугацаагаар ор сураггүй болсон бол
4. Гэрлэгсэдийн хэн нэг нь сэтгэцийн хүнд өвчин тусаж эдгэрэх найдваргүй бол
5. Гэр бүлийн харилцааг үргэлжлүүлэх боломжгүй бусад хүндэтгэн үзэх шалтгаан байгаа бол

770.2 дахь хэсэг

Шүүх энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-4 хүртэл заасан үндэслэл байх боловч бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж гэрлэлтийн харилцааг үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзвэл гэрлэлт цуцлалтыг хүлээн зөвшөөрөхгүй байж болно.

Дээрхээс харахад Япон улсын тухайд гэрлэлт цуцлах үндэслийг Иргэний хуулийн 770 дугаар зүйлийн 1-4 дэх хэсэгт шууд заасан үндэслэл, 5 дахь хэсэгт шууд бус үндэслэлийг зохицуулсан байна. Мөн 1-4 дэх хэсэгт заасан үндэслэл байх боловч

¹⁹⁵ <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4409>, <https://laws.e-gov.go.jp/law/322AC0000000224/>

¹⁹⁶ Япон улсын Гэр бүлийн бүртгэлийн тухай хуулийн 76 дугаар зүйл. <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4409>, <https://laws.e-gov.go.jp/law/322AC0000000224/>

¹⁹⁷ Япон улсын Гэр бүлийн бүртгэлийн тухай хуулийн 76 дугаар зүйл. <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4409>, <https://laws.e-gov.go.jp/law/322AC0000000224/>

¹⁹⁸ Япон улсын Гэр бүлийн бүртгэлийн тухай хуулийн 77 дугаар зүйл. <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4409>, <https://laws.e-gov.go.jp/law/322AC0000000224/>

¹⁹⁹ Япон улсын Иргэний хууль. <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>.

шүүх шаардлагатай гэж үзвэл гэрлэлт цуцлалтыг хүлээн авахгүй байж болохоор зохицуулсан нь шүүхийн гэр бүл цуцлалттай холбоотой шийдвэр гаргах шууд эрхийг зохицуулсан гэж ойлгож болох юм.

1. Гэрлэгсэдийн хэн нэг нь зүй бус үйлдэл хийсэн бол

Гэр бүл цуцлалтын үндэсэл болсон зүй бус үйлдэл гэдэг нь гэрлэгсэдийн хэн аль нь гэрлэлтийн үр дүнд бий болсон гэр бүлийн өмнө хүлээсэн үүргээ үл биелүүлж бусадтай зүй бус харилцаанд буюу бэлгийн харилцаанд орсон үйлдлийг ойлгодог байна. Энэхүү үйлдэлд нөхөр нь бусадтай бүлэглэн хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн, эхнэр эсхүл нөхөр нь биеэ үнэлэгчтэй зүй бус харилцаанд орсон үйлдэл зэргийг ойлгож болох бөгөөд бэлгийн харилцаанд орохоос гадна удаан хугацаагаар ойр дотно харилцаа үүсгэсэн тохиолдлыг мөн гэрлэлтээс бий болсон үүргээ бийлүүлээгүй гэж үздэг байна.²⁰⁰

2. Гэрлэгсэдийн нь хэн нэгийгээ санаатайгаар үл тоомсорлон орхисон бол

Эхнэр эсхүл нөхөр нь хэн нэгнийгээ санаатайгаар үл тоомсорлон орхих гэдэг цаашид гэр бүлийн хамтын амьдралаа үргэжлүүлэх хүсэл зориггүй гэдгээ илэрхийлж байна гэж ойлгодог байна. Гэрлэлтээс бий болсон хамтын амьдрал буюу бие биеэ тэжээн тэтгэх, харилцан туслах²⁰¹, хамтын амьдралд шаардагдах зардалтай²⁰² холбоотой үүргээ биелүүлэхгүй байхыг ойлгодог байна.

Гэрлэгсэдийн хэн нэг нөгөөгөө орхин гэрээсээ явахаас гадна гэрээсээ хөөх эсхүл чөлөөтэй зорчих эрхийг нь хязгаарлах, түүнээс болж гэрээсээ явсан зэрэг шалтгаанууд нь энэхүү үндэслэлд хамаарадаг байна. Эдгээр шалтгаануудын аль нэг нь байгаа тохиолдолд гэр бүл цуцлалтын үндэслэл болно. Санаатайгаар үл тоомсорлох гэдэг нь ийнхүү гэрлэлтээс бий болсон үүргээ биелүүлэхгүй байх нь цаашид гэрлэлт цуцлагдах боломжтой мэдсээр байж энэхүү үйлдлийг хийж байгааш ойлгох төдийгүй энэ ёс зүйн хувьд ч мөн нийгмийн хэмжээг зөрчиж байгаа үйлдэл байх тул гэр бүл цуцлах буруутай үндэслэл байх нь зүй ёсны гэж үздэг байна.²⁰³

3. Гэрлэгсэдийн хэн нэг нь 3-аас дээш жилийн хугацаагаар ор сураггүй болсон бол

Үүнд осолд орох, амиа хорлох зэргийг хамааруулж болох боловч хаана байгааг нь тогтоох боломжгүй, холбоо барих боломжгүй байхыг ойлгох бөгөөд хамгийн сүүлд

²⁰⁰ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 528 면.

²⁰¹ Япон улсын Иргэний хуулийн 752 дугаар зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>.

²⁰² Япон улсын Иргэний хуулийн 760 дугаар зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>.

²⁰³ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 528 면.

амьд байсан нь тогтоогдсоноос хойш хаана байгааг нь тогтоох боломжгүй байхыг ойлгоно. Үүнд дэлхийн 2 дугаар дайны үед олзлогдсон зэрэг шалтгаанаар эргэн эх орондоо ирж чадаагүй зэрэг шалтгаанаар гэрлэлт цуцлах тухай маргаанд ор сургаггүй болсон буюу амьд байгаа эсэх нь тогтоогдохгүй байгаа үндэслээр гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргаж байсан байна. Энэ тохиолдолд эвлэрүүлэн зуучлал явуулсан байхыг шаарддаггүй байна.²⁰⁴

4. Гэрлэгсэдийн хэн нэг нь сэтгэцийн хүнд өвчин тусаж эдгэрэх найдваргүй бол

Гэрлэгсэд нь оюун санаа бол болон бие махбодийн хувьд ямагт хамаарал бүхий байдаг тул оюуны санааны хувьд харилцан ойлголцох боломжгүй болсон бол цаашид гэрлэгсэдийн хамтын амьдрал хэвийн үргэлжлэх боломжгүй гэж үздэг байна. Сэтгэцийн хүнд өвчин тусаж Иргэний хуульд заасан хамтын амьдрал, харилцаа ойлголцол, бие биедээ туслах үүрэг²⁰⁵ зэргээ ухамсартайгаар хэрэгжүүлэх боломжгүйгээс шалтгаалан энэхүү үүргээ зөрчихөд хүргэхүйц хүнд өвчтэй байхыг ойлгодог байна.²⁰⁶

Гэхдээ дээрх үндэслэлээр гэрлэлтийг цуцалснаас хойш сэтгэцийн өвчтэй хүнийг асран хамгаалах, тэжээн тэтгэхтэй холботой асуудал тулгардаг байна. Энэ утгаараа тус улсын шүүхээс дээрх зохицуулалтыг дараах байдлаар тайлбарлан дүгнэсэн байна.²⁰⁷

“Иргэний хуулийн 770 дугаар зүйлд зааснаар гэрлэгсэдийн хэн нэг нь эдгэшгүй сэтгэцийн өвчин туссан үндэслэлээр гэрлэлтийг шүүхийн журмаар цуцалж болох боловч энэ зүйлийн 2 дахь хэсэгт энэхүү үндэслэл байх боловч шүүх бусад нөхцөл байдлыг дүгнэж үзээд гэрлэлтийг цаашид үргэлжлүүлэх зайлшгүй шалтгаан байна гэж үзвэл гэрлэлт цуцлуулах тухай гомдлыг хүлээн авахгүй байж болно гэж зохицуулсан байх тул гэрлэгсэдийн хэн нэг нь сэтгэцийн өвчин туссан гэх шалтгаанаар шүүхийн журмаар гэрлэлтийг цуцлах нь буруу бөгөөд өвчин эдгэрэх, эрүүл мэнд сайжрах зэргийг харгалзан үзэж хойшид өвчтөнг асрах, тэжээн тэтгэхтэй холбоотой тодорхой нөхцөл байдал бий болгох зэрэг зайлшгүй арга хэмжээнүүдийг авах шаардлага тулгарах тул шууд гэрлэлтийг цуцлах боломжтой гэж ойлгож болохгүй”

Дээрх Дээд шүүхийн шийдвэр өдийг хүртэл шүүхийн практикт суурь жишиг зарчим болсон хэвээр байгаа боловч амжиргааны зардал өгөх болон хөрөнгө хуваах замаар боломжит эдийн засгийн дэмжлэг үзүүлэх тухай даалгаж гэрлэлтийг цуцлах,

²⁰⁴ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 530 면.

²⁰⁵ Япон улсын Иргэний хуулийн 752 дугаар зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>.

²⁰⁶ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 530 면.

²⁰⁷ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 532 면.

өвчтөнд туслах, түүнийг сувилах, тэжээн тэтгэх тухай үүрэг хүлээлгэж гэрлэлтийг цуцлах, мөн улсаас халамж тогтоон холбогдох зардалыг хариуцаж байгаа болон төрийн өмчит сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа зэрэг үндэслэлээр гэрлэлтийг цуцалсан тохиолдлууд байдаг байна.²⁰⁸

5. Гэр бүлийн харилцааг үргэлжлүүлэх боломжгүй бусад хүндэтгэн үзэх шалтгаан байгаа бол

Энэ хэсэгт заасан гэрлэлт цуцлах бол гэрлэгсэдийн хамтын амьдралын хугацаанд гаргаж байсан үйлдэл, хандлага, нас, зан араншин, ажил мэргэжил, эрүүл мэнд, хөрөнгө орлого, хүүхэдтэй эсэх, гэр бүлийн хүчирхийлэл бий эсэх зэрэг хамтын амьдралд нөлөөлөх бүхий л хүчин зүйлийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж харгалзан үзэх шаардлагатай. Дээрхийг шүүхээс дараах байдлаар шийдвэрлэсэн байна.²⁰⁹

Хүчирхийлэл

Тамхины үнс асгах зориулалтаар ашиглаж байсан цайны аягаар эхнэрийнхээ нүүр лүү цохиж эрүүл мэндэд хохирол учруулсан, нүцгэн биеийг нь зөвхөн алчуураар халхалж шөнийн турш тагтан дээр зогсоох болон хүүхдийн хоёр давхар жижиг орон дээр унтахыг албадсан, хослол болон зангиаг нь хайчилсан, унтаж байхад нь цаасны хутгаар гар, нүүрэнд нь гэмтэл учруулсан, мөн ус, шөл, сүүг асгах зэрэг хүчирхийллийн үйлдэл гаргасан, байнга хүчирхийлдэг тул энэхүү үйлдэл нь давтагдах байх хэмээн байнгын айдаст автуулах зэрэг үйлдлийг энэхүү хэсэгт хамааруулж үздэг байна.

Ноцтойгоор доромжлох

Эхнэр нь нөхрийгөө өөртэй нь гэрлэснээс хойш байнга дарамтлуулж байна, гэрлэлтээс болж хохирсон, мөн нөхөр нь өөрийн төрсөн эхтэйгээ хэтэрхий ойрын харилцаатай байдаг гэх зэргээр зүй бус харьцдаг үйлдэл, мөн эхнэр нь хүүхэдтэйгээ нийлэн хадам эхийгээ “хөгшин минь хурдан далд ороорой” гэх мэтээр чанга дундуур орилж доромжилдог үйлдэл мөн эмч болох нөхрийгөө зүй бус үйлдэл гаргадаг үнэнч бус хэмээн гүтгэж гуравдагч этгээдэд захидал бичсэн зэрэг үйлдлийг энэхүү хэсэгт хамааруулж үздэг байна.

Ажил эрхлэхгүй байх, хэт их зардал гаргах, өр тавих

Эхнэр нь ажил хийлгүй зөвхөн нөхрийн орлогоос хараат байдлаар амьдрахаас гадна мурийтай тоглодог үйлдэл, төрийн албан хаагч болох нөхрийн өндөр биш тогтмол орлоготой байдлыг үл харгалзан гэр бүлийн орлогоос хэт давсан

²⁰⁸ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 532 면.

²⁰⁹ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 535-541 면.

зардал гаргаад зогсохгүй хадам эцгийг нэрээр зээлээр эд зүйл худалдан авсан зэрэг үйлдлийг энэхүү хэсэгт хамааруулж үздэг байна.

Гэмт хэрэг үйлдэх

Нөхөр нь олон улсыг хамарсан их хэмжээний хохирол учруулсан залилах гэмт хэрэг үйлдсэн, мөн нөхөр нь гэрлэхээс өмнө болон хойно нийт дөрвөн удааа залилан мэхлэн гэмт хэрэг үйлдсэн бөгөөд хорин ял эдэлж байгаа зэрэг үйлдлийг энэхүү хэсэгт хамааруулж үздэг байна.

Гэрлэгсэд хэн нэгнийхээ эсрэг шүүхэд гомдол гаргах

Нөхөр нь өвчний улмаас ухаан алдсан нөхрөөсөө гэрлэлтээ цуцлуулах тухай нэхэмжлэл гаргасны хариуд гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцуулах тухай гомдол гарган гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцуулаад зогсохгүй гэм хорыг хохирол төлүүлэхээр шүүхээс шийдвэрлүүлсэн боловч эхнэрийнхээ эсрэг эрүүгийн журмаар гомдол гаргасан боловч эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн шийдвэрийг мөн үл зөвшөөрч прокурорын хянан шалгах хороонд давж заалдах гомдол гаргах зэргээр хэрээс хэтэрсэн үйлдлүүд гаргасан тохиолдлыг энэ хэсэгт хамааруулж үздэг байна.

Гэр бүлийн гишүүдийн үл ойлголцол

Хадам эх нь бэр хандан хоол идэхдээ амаа хөдөлгөж байгаа нь таалагдахгүй байна, хадам эхээсээ түрүүлж хоол идэж болохгүй, чи надад дургүй, гэрээс яв, чамд таалагдах зүйл нэг ч алга байна гэх зэргээр үг хэлээр байнга доромжилж байгаа нөхөр нь мэдсээр байж эхнэр болон эхийгээ эвлэрүүлэх талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй тохиолдлыг энэ хэсэгт хамааруулж ойлгодог байна.

Шашин шүтэх эрхийн зөрчил

Эхнэр нь өөрийн шүтдэг шашины үйл ажиллагаанд хэт их ач холбогдол өгснөөс гэр бүлийн харилцан ойлголцол, хамтын амьдрал, хүүхдийг тэжээн тэтгэх, асран хамгаалах үүргээ умартсанаас үүдэлтэйгээр бие биедээ үл итгэх байдал бий болж улмаар жигшихэд хүргэж гэр бүлий амьдрал цаашид хэвийн үргэжлэх боломжгүй болсон тохолдол

Бэлгийн амьдралын үл ойлголцол

Нөхрийн бэлгийн харилцааны гаж байдал, ижил хүйстнээ сонирхох байдал, нөхрийн насанд хүрэгчдийн сэтгүүл зэрэгт хэт автсанаас болж бэлгийн харилцаанаас татгалзах байдал, мөн эхнэрийн бэлгийн харилцаанд орохоос татгалзах үйлдэг зэргийг хамруулж ойлгодог байна.

Өвчин, хөгжлийн бэрхшээл

Дээр дурьдсан сэтгэцийн өвчний улмаас гэр бүл цуцлахтай холбоотой хэсэг энд хамаарахгүй бөгөөд архи, мансууруулах бодисонд донтох зэргийг хамааруулж

ойлгоно. Мөн нөхөр нь ажил хөдөлмөр эрхэлдэггүйгээс гадна хөгжлийн бэршээлээс болж бэлгийн амьдралын чадваргүй болсон зэрэг шалтгааныг хамааруулж ойлгодог байна.

Зан байдлын зөрчилдөөн

Энэ тохиолдол нь гэрлэгсэд зан байдлын хувьд тал талаасаа хичээсэн боловч таарч тохирох ямарч боломжгүй болсон байхыг ойлгоно. Гэрлэгсэд зан байдлын хувьд төгс зохицох боломжгүй боловч гэрлэлтийг цааш үргэжлүүлэх эсэхийг шийдэхийн тул тэдний дунд ямарч аргаар шийдэх боломжгүй тийм үл ойлголцол байхыг шаарддаг байна.

Нөхөр нь оюунлаг байдлыг эрхэмлэж өдөр тутмын амьдралын хэв маягаа бий болгодог бол эхнэрт энэхүү байдал тааламжтай бус санагддаг тул түүний хүссэн оюулаг байхад шаардлагатай мэдлэг мэдээллийг олж аьасах суралцах хүсэлтийг хүлээж авдаггүй гэх тохиолдолд, 3 жил хамт, 5 жил тусдаа амьдарсан гэрлэгсэдийн нэг нь цэвэрч, нямбай байдалд дуртай бол нөгөө нь түүний эсрэг зан байдалгаас болж хамтын амьдралыг цаашид үргэжлүүлэх боломжгүй болсон зэрэг тохиолдлыг ойлгодог байна.

Эвлэрсэн боловч эвлэрэлийг баталгаажуулах ажиллагаанд саад учруулах

Эхнэр нь гэрлэлт цуцлуулах ажиллагааны явцад нөхрөөсөө гэрлэлт цуцлуулсны тэтгэмж авахаар тохиролцож харилцан тохиролцох журмаар буюу захиргааны журмаар гэрлэлтээ цуцлуулахаар болж холбогдох тэтгэмжээ авсан боловч гэрлэлт цуцлах ажиллагаанд саад урчуулж байгаа тохиолдлыг ойлгодог байна.

Буруутай гэрлэгч гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргах эрхгүй

Япон улсын Иргэний хуульд шууд зохицуулсан агуулга бүхий заалт байхгүй боловч тус улсын Дээд шүүхээс дэлхийн хоёрдугаар дайнаас хойш буруутай гэрлэгчийн гаргасан гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг хүлээн авахгүй байх тухай жишиг тогтоосон байна. Өөрөөр хэлбэл гэрлэгсэдийн хэн нэгний буруутай үйлдлээс болж гэрлэлт цуцлахад хүргэсэн бол тухайн буруутай этгээд гэрлэлтээ цуцлуулахаар нэхэмжлэл гаргах эрхгүй байх тухай ойлголт юм. Энэ тухай шүүхийн шийдвэрээс харахад “нөхөр нь эхнэрээсээ хууль ёсны гэрлэлтээ цуцлуулаагүй боловч түүнээс тусдаа амьдран өөр хүнээс хүүхэдтэй болсон бөгөөд ингэж хамт амьдарч байх явцдаа эхнэрээсээ гэрлэлтээ цуцлуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна”. Энэ талаар шүүх дүгнэхдээ ийм нэхэмжлэлийг шүүх хүлээн авч шийдвэрлэх юм бол эхнэр болох хүний хувьд асар их доромжлол авч байна гэж үзэж болох тул хууль зүйн хувьд ийм агуулга бүхий нэхэмжлэлийг шүүх хүлээн авч шийдвэрлэх нь ёс зүйд нийцэхгүй гэж үзнэ. Хууль нь ёс зүйд нийцэж ёс зүйгүй

үйлдэлтэй эвлэрэхгүй байх ёстой бөгөөд хуулийг энэ агуулгад нийцүүлэн тайлбарлах ёстой гэжээ.²¹⁰

Буруутай гэрлэгч гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргах эрхгүй байх боловч гэрлэлтийн харилцаа нэгэнт дуусгавар болсон гэж үзэхээр байвал нэхэмжлэл гаргах эрхтэй

Шүүх дээрхийн нэгэн адил дүгнэж байгаа боловч гэрлэгсэдийн гэр бүлийн хамтын амьдрал бодит байдал дээрээ гэрлэлтийн харилцаа байгаа гэж үзэх боломжгүй болсон, олон жилийн турш тусдаа амьдарсан, өөр хүнтэй гэр бүлийн харилцаа үүсгэн хүүхэдтэй болсон төдийгүй удаан хугацаагаар хамтран амьдарсан зэргээс харахад гэрлэгсэдийн гэрлэлтийн харилцааг сэргээх үргэлжлүүлэх боломжгүй бол нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэх ёстой гэж үздэг байна. Гэрлэгсэд тусдаа амьдарснаас хойш буюу хамтын амьдрал нэгэнт үгүй болсноос хойш өөр хүнтэй хамт амьдран хүүхэдтэй болсон бол нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэх нь зөв гэж үзжээ. Мөн гэрлэгсэд тусдаа амьдраад 36 жил өнгөрсөн үүнээс болж гэрлэлтийн хамтын амьдрал нэгэнт үгүй болсон энэ хугацаанд нөхрийн буруутай байдал арилж байгаа, гэрлэлт цуцлалтаас болж хүүхдийг тэжээн тэтгэх болон эхнэрийн эдийн засгийн байдал муудах зэрэг сөрөг нөлөө байхгүй зэрэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэсэн тохиолдолд байдаг байна.²¹¹

Шүүхийн харьяалал

Гэр бүлийн шүүх нь гэрлэлтийг хүчингүй болгох, гэрлэлт цуцлахтай холбоотой маргаанд гэрлэгсэд насанд хүрээгүй хүүхэдтэй байх тохиолдолд Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлд заасны дагуу хүүхдийн оршин суугаа газрыг харгалзан үзнэ. Тус хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Гэр бүлийн шүүх нь гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийн шүүх харьяалал өөр байх боловч Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 257 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гаргасан хүсэлтийн дагуу эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж байгаа болон түүний явц, талуудын хүсэлт, бусад нөхцөл байдлыг харгалзан үзээд шаардлагатай гэж үзвэл шүүх өөрөө болон талуудын хүсэлтээр маргааныг шийдвэрлэж болно.²¹²

Гэр бүлийн шүүх нь өөрийн харьяалалд хамаарах маргаан мөн боловч талуудын болон гэрчүүдийн оршин суугаа газрын байршил болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашрахаас сэргийлэх, талуудын

²¹⁰ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 542 면.

²¹¹ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 543 면.

²¹² Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хуулийн 31, 6 дугаар зүйл. <https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>, <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

оролцооны тэгш байдлыг хангах зэрэг зорилгоор шаардлагатай гэж үзвэл талуудын хүсэлтээр эсвэл өөрөө хэргийн зарим хэсгийг болон бүхэлд нь өөр шүүхэд шилжүүлж болно.²¹³

б) Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 257.1 хэсэгт зааснаар заавал эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулна.²¹⁴

Шүүхийн харьяалал

Шүүхийн харьяаллын тухайд тус хуулийн 245.1 дэх хэсэгт зааснаар хариуцагчийн оршин суугаа хаягийн харьяаллын эсхүл талуудын тохиролцсон Гэр бүлийн шүүхэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулна.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

Гэр бүлийн шүүхийн эвлэрүүлэн зуучлах зөвлөл эвлэрүүлэн зуучлалыг явуулах боловч шүүхээс зайлшгүй шаардлагатай гэж үзвэл шүүх явуулж болно.²¹⁵ Эвлэрүүлэн зуучлах зөвлөл нь нэг шүүгч, эвлэрүүлэн зуучлагч хоёроос дээш гишүүнээс бүрдэнэ.²¹⁶ Зөвлөлийг Гэр бүлийн шүүхээс маргаан тус бүрээр байгуулна.²¹⁷ Зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд гишүүдийг томилох чөлөөлөх асуудлыг Дээд шүүхийн журмаар зохицуулна.²¹⁸ Зөвлөлийн гишүүнийг

²¹³ Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хуулийн 7 дугаар зүйл. <https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>, <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

²¹⁴ <https://laws.e-gov.go.jp/law/423AC0000000052/>,
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4512>

²¹⁵ Япон улсын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 247 дугаар зүйл.
<https://laws.e-gov.go.jp/law/423AC0000000052/>,
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4512>.

²¹⁶ Япон улсын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 248 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/423AC0000000052/>,
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4512>.

²¹⁷ Япон улсын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 248 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/423AC0000000052/>,
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4512>.

²¹⁸ Япон улсын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 249 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/423AC0000000052/>,
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4512>.

өмгөөлөгчөөр 5-аас дээш жил ажилласан хүнийг Дээд шүүх хоёр жилийн хугацаагаар²¹⁹ томилно.²²⁰

(2) Гэрлэлт цуцлахтай холбоотой гэм хорын нэхэмжлэл

Нэхэмжлэл гаргах

Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар гэрлэлтийн харилцаанаас үүссэн гэм хорын нэхэмжлэлийг харьяалах Гэр бүлийн шүүхэд дангаар гаргаж болно.²²¹

Гэрлэгсэдийн хэн алины зүй бус үйлдэл, хүчирхийлэл зэрэг буруутай үйлдлийн улмаас гэрлэлт цуцлуулах энэхүү буруутай үйлдлээс бий болсон эдийн бус гэм хорыг(сэтгэл санааны хохирол) арилгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Зүй бус үйлдэл гэрлэлт цуцлуулах үндсэн шалтгаан болсон бол гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлээс тусад нь энэхүү хууль бус үйлдлийн улмаас бий болсон эдийн бус гэм хорыг нэхэмжлэх боломжтой байдаг байна.²²²

Хууль бус үйлдлийн улмаас бий болсон гэм хорын нэхэмжлэл нь иргэний хэрэг маргаанд хамаарах бөгөөд гэрлэлт цуцлахтай холбоотойгоор энэхүү нэхэмжлэлийг гаргах бол тус улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гаргаж болох бөгөөд зөвхөн гэм хорын нэхэмжлэл гаргах бол ердийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар гаргадаг байна.

Хугацаа

Гэм хорыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг өөрөө болон хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан гэм учирсныг мэдсэн өдрөөс болон зүй бус үйлдлийг мэдсэн өдрөөс хойш гурван жилийн дотор гаргах хөөн хэлэлцэх хугацаатай байх

²¹⁹ Япон улсын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 250 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/423AC0000000052/>,
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4512>.

²²⁰ Япон улсын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуулийн 250 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/423AC0000000052/>,
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4512>.

²²¹ Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хууль. <https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>, <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

²²² 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 548 면.

хууль бус үйлдлээс хойш хорин жил өнгөрсөн бол хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болно.²²³

Гэм хор ба хөрөнгө хуваах

Гэрлэлт цуцлуулснаар хуваах хөрөнгийн тухайд:

1. Гэрлэгсэдийн гэрлэснээс хойш бий болсон хөрөнгө
2. Гэрлэлт цуцлуулснаас хойш тэжээн тэтгэх үүрэг
3. Гэрлэлт цуцлуулснаас бий болсон гэм хор

Дээрхийг харгалзан хөрөнгө хуваах ёстой гэж үздэг боловч зөвхөн 1,2 дахь хэсэгт заасныг харгалзан хөрөнгө хуваах ёстой гэж үзэх тохиолдолд байдаг байна. Гэхдээ тус улсын шүүхээс дараах байдлаар шийдвэрлэж байна.²²⁴

Гэрлэлт цуцлуулахад хүргэсэн буруутай гэрлэгчийн үйлдлээс болж нөгөө гэрлэгчид учирсан эдийн бус гэм хорыг (сэтгэл санааны хохирол) хөрөнгө хуваахтай холбоотой шийдвэрт хамруулан хуваах хөрөнгийн хэмжээ болон аргыг тогтооно гэж

Эдийн бус гэм хор(сэтгэл санааны хохирол) нь буруутай гэрлэгчийн хууль бус үйлдлийн улмаас нөгөө гэрлэгчид сэтгэл санааны гэм хор учруулсны хариуд төлж байгаа төлбөр тул гэр бүлийн хөрөнгө хуваах асуудалтай агуулгын хувьд хамааралтай гэж үзэх нь дутагдалтай тул хөрөнгө хуваах тухай шийдвэр гарснаас хойш тусад нь гэм хорын нэхэмжлэл гаргаж болно гэж

Хөрөнгө хуваах тухай шийдвэр гаргахдаа эдийн бус гэм хорыг (сэтгэл санааны хохирол) хамруулан шийдвэрлэсэн бол гэм хорыг харгалзан хөрөнгө хуваах хэмжээг тогтоох шаардлага тавигдах бөгөөд энэхүү тогтоосон хэмжээгээр гэм хорыг арилсан гэж үзвэл гэм хорын нэхэмжлэлийг тусад гаргах боломжгүй байх боловч хөрөнгө хуваахад гэм хорыг харгалзаагүй эсхүл харгазсан боловч гэм хор төлүүлэхээр шийдвэрлэсэн хэмжээ нь хангалтгүй гэж үзвэл гэм хорын нэхэмжлэлийг тусад гаргах боломжтой гэж

Гэм хорын хэмжээг тогтоох

Гэрлэлт цуцлуулснаас үүдэн бий болсон гэм хорын хэмжээг тогтоохдоо гэр бүл цуцлуулахад хүргэсэн буруутай гэрлэгчийн үйлдэл тус бүрийг харгалзан үзэх шаардлагатай бөгөөд энэхүү хууль бус үйлдлийн улмаас нөгөө гэрлэгчийн сэтгэл санаанд учирсан гэм хор одоо болон ирээдүйд нөлөөлөх байдлыг харгалзах

²²³ Япон улсын Иргэний хуулийн 724 дүгээр зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4314>.

²²⁴ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 548-549 면.

хэрэгтэй байдаг байна. Сэтгэл санаанд бий болсон шаналал зэрэг нь хууль үйлдлийн улмаас бий болсон гэм хор мөн тул сэтгэл санааны хохиролын хэмжээг тогтоох энэхүү зовлон шаналлыг харгалзан үзэх шаардлагатай байдаг байна.²²⁵

Тус улсын шүүхээс гэм хорын хэмжээг тогтоохдоо талуудын буруутай байдал, нас, ннасанд хүрээгүй хүүхэдтэй эсэх, эдийн засгийн байдал, хөрөнгө хуваасны дараах эдийн засгийн байдал, гэр бүл цуцлуулахад хүргэсэн шалтгаан нөхцөл зэргийг харгалзан үздэг байна. Гэхдээ эдгээр нөхцөл байдлууд хэр хэмжээгээр нөлөөлдөг эсэхийг шууд дүгнэх боломжгүй боловч дараах байдлаар тогтоож байна.²²⁶

1. Гэм буруу, эдийн ба эдийн бус гэм хор их байх тусам их хэмжээгээр
2. Гэрлэлтийн харилцаа урт байх болон нас өндөр байх тусам их хэмжээгээр
3. Насанд хүрээгүй хүүхэдтэй байх тохолдол нь хүүхэдгүй байхаас их хэмжээгээр
4. Гэм буруутай гэрлэгч эрх мэдэлтэй, нийгэмд эзлэх байр суурь өндөр байх тусам их хэмжээгээр
5. Гэм буруугүй гэрлэгчийн эрх мэдэл бага байх тусам их хэмжээгээр
6. Хөрөнгө хувааснаар эдийн засгийн байдал нь сайжирхаар байвал бага хэмжээгээр

(3) Гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох

Үндэслэл

Тус улсын Иргэний хуулийн 742 дугаар зүйлд зааснаар дараах тохиолдолд гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцно.²²⁷

1. Гэрлэгсэд хүсэл зоригоо илэрхийлэх үед андуурсан эсхүл бусад шалтгааны улмаас хүсэл зоригоос гадуур гэрлэсэн бол
2. Гэрлэлтээ бүртгүүлээгүй бол(Иргэний хуулийн 739 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэрлэлтээ бүртгүүлэхээр хүсэлтээ гаргасан бол хамаарахгүй)

Хүчин төгөлдөр бусад тооцох шүүхийн ажиллагаа

Тус улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны маргааны тухай хуулийн 2 дугаар зүйл болон 4 дүгээр зүйлд зааснаар “Гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох маргааныг Гэр бүлийн шүүх шийдвэрлэнэ”.²²⁸

²²⁵ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 549 면.

²²⁶ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 550 면.

²²⁷ Япон улсын Иргэний хуулийн 742 дугаар зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²²⁸ Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны маргааны тухай хууль.

Гэрлэлт, гэр бүлийн харилцааны маргааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэрлэгчдийн хэн нэг нь гэрлэлтийг хүчингүйд тооцуулахаар гомдол гаргасан бол нөгөө гэрлэгч энэхүү маргааны хариуцагч байна.²²⁹

Мөн тус хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар дээрх гомдлыг гэрлэгчдээс өөр этгээд гаргасан бол гэрлэгчид хариуцагч байх бөгөөд гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан бол нөгөө гэрлэгч хариуцагч байна.²³⁰

Дээр дурьдсан хариуцагч болох этгээдүүд бүгд нас барсан бол прокурор хариуцагч байна.²³¹ Проркурор хариуцагчаар оролцож буй шүүх хурлын шийдвэрээс шалтгаалан өв залгамжлах эрх бүхий гуравдагч этгээдийг шүүх хуралдаанд оролцуулах шаардлагатай гэж үзвэл шүүхээс түүнийг оролцуулах бөгөөд энэ тухайн хэрэгт хамаарал бүхий этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхийг нь хангаж байгаа хэрэг юм.²³²

Шүүх дээрх шийдвэрийг гаргасан тохиолдолд хэргийн оролцогчид болон тухайн хэрэгт хамаарал бүхий этгээдийн саналыг сонсоно.²³³

Нэхэмжлэлийн шаардлага өөрчлөх, сөрөг нэхэмжлэл гаргах

²³⁴ Анхан болон давж заалдах шатны шүүх хуралдааны мэтгэлзээний явцад нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх, хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргаж болно.

2) Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тооцох болон тус шийдвэрийг хүчингүйд тооцох

<https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>,

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

²²⁹ Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны маргааны тухай хууль.

<https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>,

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

²³⁰ Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны маргааны тухай хууль.

<https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>,

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

²³¹ Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцаа маргааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь

хэсэг. <https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>,

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

²³² Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны маргааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх

хэсэг. <https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>,

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

²³³ Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны маргааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь

хэсэг. <https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>,

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

²³⁴ Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны маргааны тухай хуулийн 18 дугаар зүйл.

<https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>,

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

Үндэслэл

Иргэний хуулийн 838 дугаар зүйлд зааснаас насанд хүрээгүй хүүхдэд эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч байхгүй болон хүүхдийн хөрөнгийг эрхлэн удирдах этгээд байхгүй тохиолдолд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтооно.²³⁵

Насанд хүрээгүй хүүхдийн эцэг, эх байх эрхийг болон хууль ёсны асран хамгаалагчийн эрхийг хамгийн сүүлд хэрэгжүүлж байсан хүн гэрээслэлээр асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоож болно. Энд насанд хүрээгүй хүүхдийн хөрөнгийг эрхлэн удирдах эрхгүй байсан этгээд хамаарахгүй.²³⁶

Эцэг, эх байх эрхтэй боловч насанд хүрээгүй хүүхдийн хөрөнгийг эрхлэн удирдах эрхгүй бол эрхтэй эцэг эсхүл эх нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоож болно.²³⁷

Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох

Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг түүний төрөл, садан эсхүл бусад хамаарал бүхий хүмүүсийн хүсэлтээр Гэр бүлийн шүүх тогтооно.²³⁸

Насанд хүрээгүй хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон боловч түүний төрөл, садан эсхүл бусад хамаарал бүхий хүмүүсийн хүсэлтээр Гэр бүлийн шүүх шаардлагатай гэж үзвэл нэмж асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоож болно.²³⁹

Гэр бүлийн шүүх насанд хүрээгүй хүүхдэд асран хамгаалагч тогтоохдоо түүний нас, бие махбодийн болон сэтгэцийн байдал, өдөр тутмын амьдралын нөхцөл байдал, санхүүгийн байдал, мэргэжил, хувийн байдал, мөн асран хамгаалуулагч, хамгаалагч нарын хооронд аливаа ашиг сонирхол байгаа эсэх, асран хамгаалагчийн санал бусад бүхий л нөхцөл байдлыг харгалзан үзнэ.²⁴⁰

²³⁵ Япон улсын Иргэний хуулийн 838 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²³⁶ Япон улсын Иргэний хуулийн 839 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²³⁷ Япон улсын Иргэний хуулийн 839 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²³⁸ Япон улсын Иргэний хуулийн 840 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²³⁹ Япон улсын Иргэний хуулийн 840 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²⁴⁰ Япон улсын Иргэний хуулийн 840 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

Хүүхдийн эцэг, эх нь эцэг, эх байх эрх болон хүүхдийн хөрөнгийг эрхлэн удирдах эрхээсээ татгалзсан эсхүл хасуулсан тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон бол хүүхдийн эцэг, эх нэн яаралтай Гэр бүлийн шүүхэд асран хамгаалагч тогтоолгох тухай хүсэлт гаргана.²⁴¹

3) Эцэг, эх тогтоох, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх, эцэг, эх байх эрх, үүргээ хэрэгжүүлэхэд саад болсонтой холбоотой

Эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах

Япон улсын Иргэний хуулийн 834 дүгээр зүйлд зааснаар хүүхдийг эцэг, эх нь хүчирхийлэх, санаатайгаар аюултай байдалд орхих эсхүл эцэг, эх байх эрхээ хэрэгжүүлэхэд ноцтой саад учрахуйц нөхцөл байдал нь хүүхдийн эрх ашгийг ноцтой хохироосон бол Гэр бүлийн шүүх хүүхдийн өөрийн болон түүний төрөл садан, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, прокурорын хүсэлтээр **эцэг, эх байх эрхийг хасах тухай шийдвэр гаргана**. Гэвч эцэг, эх байх эрхийг хасахад хүргэсэн шалтгаан нөхцөл хоёр жилийн дотор арилахаар байвал эрх хасахгүй байж болно.²⁴²

Мөн Гэр бүлийн шүүх эцэг, эх байх үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй эсхүл зохисгүй үйлдлийн улмаас хүүхдийн эрх ашиг сонирхолд харшилж байна гэж үзвэл хүүхдийн өөрийн болон түүний төрөл садан, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, прокурорын хүсэлтээр **эцэг, эх байх эрхийг хязгаарлах тухай шийдвэр** гаргаж болно.²⁴³

Гэр бүлийн шүүх дээрх шийдвэрийг гаргахдаа эцэг, эх байх эрхийг хязгаарлах хугацаа, хүүхдийн бие бялдар болон сэтгэл санааны байдал, хүүхдийн өдөр тутмын ахуй амьдралын нөхцөл байдал болон бусад бүхий л хүчин зүйлийг харгалзан үзэж эрх хязгаарлах хугацааг 2 жилээс хэтрэхгүй байхаар тогтооно.²⁴⁴

Эцэг, эх байх сэргээх

²⁴¹ Япон улсын Иргэний хуулийн 841 дүгээр зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²⁴² Япон улсын Иргэний хуулийн 834 дүгээр зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²⁴³ Япон улсын Иргэний хуулийн 834.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²⁴⁴ Япон улсын Иргэний хуулийн 834.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

Тус улсын Иргэний хуулийн 834 дүгээр зүйлд заасан эцэг, эх байх эрх хасах, 834.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх хязгаарлах шийдвэрийг эрх хасуулсан, хязгаарлуулсан этгээд эсхүл тэдний төрөл, садны хүний хүсэлтээр эрх хасах, хязгаарлах болсон шалтгаан нөхцөл арилсан гэж үзвэл сэргээх шийдвэр гаргана.²⁴⁵

Эцэг, эх байх эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах

Эцэг, эх нь зайлшгүй шалтгаан байгаа бол Гэр бүлийн шүүхийн зөвшөөрлөөр Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эцэг, эх байх эрхээсээ татгалзаж болно.²⁴⁶ Мөн эцэг, эх байх эрхээсээ татгалзсан шалтгаан нөхцөл арилсан бол Гэр бүлийн шүүхийн зөвшөөрлөөр эцэг, эх байх эрхээ сэргээлгэж болно.²⁴⁷

4) Дундын өмчийн хөрөнгийн маргааныг шийдвэрлэх эрх зүй зохицуулалт

Тус улсын Иргэний хуулийн 768 дугаар зүйлд²⁴⁸ гэр бүл цуцлалтаас үүсэх хөрөнгө хуваах ажиллагааны талаар дараах байдлаар зохицуулсан байна.

1. Гэрлэгсэд харилцан тохиролцож гэрлэлтээ цуцлуулахад хөрөнгө хуваах тухай нэхэмжлэл гаргаж болно.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хөрөнгө хуваах талаар тохиролцож чадаагүй эсхүл тохиролцох боломжгүй бол талууд Гэр бүлийн шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж болно. Гэрлэлт цуцлуулснаас хойш 2 жил өнгөрсөн бол нэхэмжлэл гаргах боломжгүй.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэл гаргасан бол Гэр бүлийн шүүх нь талуудын хамтын хувь нэмрийн үр дүнд бий болсон хөрөнгийн хэмжээ, үнэ болон бусад нөхцөл байдлыг харгалзан хөрөнгө хуваах эсэх болон хуваах хэмжээ, аргыг тогтооно.

Хөрөнгө хуваахад баримтлах хууль зүйн үндэслэл

²⁴⁵ Япон улсын Иргэний хуулийн 836 дугаар зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²⁴⁶ Япон улсын Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²⁴⁷ Япон улсын Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²⁴⁸ Япон улсын Иргэний хуулийн 768 дугаар зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4314>.

Тус улсын хувьд гэр бүлийн дундын хөрөнгийг хуваахад хууль зүйн мөн чанарын хувьд дараах үндсэн гурван үндэслэлийг хамруулж ойлгодог байна.

1. Гэрлэгсэдийн бий болгосон дундын хөрөнгө
2. Гэрлэлт цуцалсны дараа тэжээн тэтгэх
3. Гэм хор

1. Гэрлэгсэдийн бий болгосон дундын хөрөнгө

Гэрлэгсэд гэрлэснээс хойш бий болгосон хөрөнгө нь талуудын шууд болон шууд бус оролцооноос үл хамаарч хуваах хөрөнгөд тооцогдог нь зүйн хэрэг байдаг байна. Хөрөнгийг хуваах хэмжээ арга зэргийг тус улсын иргэний хуулийн 768 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Гэр бүлийн шүүх нь талуудын хамтын хувь оролцооны үндсэн дээр бий болсон хөрөнгийн үнэ болон хэмжээ бусад нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэж талуудад оногдох хувь хэмжээ болон түүнийг тооцох аргыг тогтоож хөрөнгийг хуваадаг” байна.²⁴⁹

2. Гэрлэлт цуцалсны дараа тэжээн тэтгэх

Талууд гэрлэлтээ цуцлуулснаар хууль ёсны гэрлэлтийн харилцаа дуусгавар болж Иргэний хуульд заасан бие биеэ харилцан дэмжих үүрэг мөн дуусгавар болдог.²⁵⁰ Гэвч хамтын амьдралын явцад гэрийн ажилд цаг зарцуулснаар өөрийн хуваарь хөрөнгийг бий болгож чадаагүй төдийгүй бие даан ажил хөдөлмөр эрхлэх боомжгүй байх болон ингэхэд тодорхой хугацаа шаардагдах зэргээр гэрлэлт цуцлуулснаас хойш бие амжиргаагаа залгуулах боломжгүй нөхцөл байдал байж болох тул энэхүү тодорхой хугацаанд түүнийг тэжээн тэтгэх үүрэг бий болно. Энэхүү үүрэг нь хууль зүйн хувьд дараах үндэслэлээр бий болно гэж үздэг байна.

- 1) Гэрлэлтийг насан туршийн хамтын амьдрал гэж үзэх бөгөөд гэрлэлт цуцлагдсанаар эдийн засгийн чадавхтай тал нь ийм боломжгүй байгаа талыгаа тэжээн тэтгэх нь хууль зүйн хувьд болон хүн ёсны хувьд зүйн хэрэг гэж үзэх
- 2) Гэрлэлтээс бий болсон хамтын амдралыг дуусгавар болгон гэрлэлт цуцалсны дараа бие даан амьдрах боломжтой болох хүртэл тодорхой хугацаанд тэжээн тэтгэх нь гэрлэлт цуцлалтаас бий болох үүрэг гэж үзэх
- 3) Гэрлэлт цуцлуулсны дараа хэн нэг нь бие даан амьжиргаагаа залгуулах боломжгүй байх нь хамтын амьдралын явцад гэрийн ажлыг дангаар хийх зэргээр өөрийн хөдөлмөрлөх эрхээ хязгаарлах төдийгүй түүнээс бий болох хуваарьт хөрөнгийг бий болгож чадаагүйгээс нөгөө гэрлэгчтэй харьцуулахад

²⁴⁹ Япон улсын Иргэний хуулийн 768 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4314>.

²⁵⁰ Гэрлэгсэд өөрсдийн хөрөнгө орлого бусад хүчин зүйлийг харгалзан үзэж хамтын амьдралд шаардлагагтай зардлыг хамтран хариуцна. Япон улсын Иргэний хуулийн 760 дугаар зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4314>.

ажил хөдөлмөр эрхэлж хөрөнгө бий болгох чадвар зэрэг нь дутуу байх боломжтой тул энэхүү зөрүүг арилгах шаардлагатай гэж үздэг байна.

3. Гэм хор

Тус улсын Иргэний эрх зүйд гэм хор нэхэмжлэх ойлголт нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэх зохицуулттай байдаг бол гэр бүл цуцлуулах маргааны хүрээнд гэрлэлтийг цуцлуулах болсон шалтгааны улмаас эдийн бус гэм бий болсон гэж үзвэл Гэр бүлийн шүүхэд гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг хамтаар гомдол гарган шийдвэрлүүлэх боломжтой байдаг байна.²⁵¹ Мөн гэрлэлт цуцлалтаас үүсэх **гэм хор нэхэмжлэх асуудал нь эвлэрүүлэн зуучлалын хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой** байдаг бөгөөд шүүхээр шийдвэрлүүлэх тохиолдолд Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Гэр бүлийн шүүхэд хандан шийдвэрлүүлэх боломжтой байна.²⁵²

Дундын хөрөнгийг хуваах

Тус улсын Иргэний хуулийн 762 дугаар зүйл 1 дэх хэсэгт зааснаар гэрлэгсэд гэрлэхээс өмнө олж авсан болон гэрлэлтийн явцад өөрийн нэрээр олж авсан хөрөнгө нь тэдний хуваарьт хөрөнгө байна.²⁵³ Гэвч энэхүү хуваарьт хөрөнгөд гэрлэгчдийн хэн аль нь хувь нэмрээ оруулсан бол хуваах хөрөнгөд тооцдог байна. Мөн гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгө нь хэн нэгний өмчлөл болон нэр дээр байгаагаас үл хамаарч тэдний дундын хөрөнгөд тооцогдох бөгөөд хуваах хөрөнгө болно.²⁵⁴

1. Газар, түүн дээрх үл хөдлөх хөрөнгө

1) Газрын эрх, үл хөдлөх хөрөнгө

Үл хөдлөх хөрөнгийг хуваахдаа тухайн хөрөнгийн өмчлөгчөөр бүртгүүлээгүй талд түүнд тохирох мөнгөн хөрөнгийг шилжүүлж болно. Мөн тухайн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотойгоор бусдаар гүйцэтгүүлэх үүрэг буюу түрээсийн төлбөр, газар ашигласны төлбөр авдаг болон тухайн газар дээр байгаа үл хөрөнгийг хуваах бол түүнд хамаарах бүхий л үнэ цэнийг тооцно.

2) Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ

²⁵¹ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 555 면.

²⁵² Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хууль. <https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000109/>, <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4178>.

²⁵³ Япон улсын Иргэний хууль. <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4314>.

²⁵⁴ 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도, 556 면.

Үл хөдлөх хөрөнгийг үнэдэхдээ практикт ихэвчлэн үл хөдлөх хөрөнгө зуучлагчийн үнэлгээг ашигладаг бөгөөд үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний шинжээч томилох нь ховор байдаг байна.

3) Гэрлэгчдийн хөрөнгө холилдсон тохиолдолд

Гэрлэгчид гэрлэснээс хойш хөрөнгө худалдан авахдаа өөрийн хуваарьт хөрөнгөнөөс зарцуулан гэр бүлийн дундын хөрөнгөтэй холилдсон бол тухайн худалдан авсан хөрөнгийн дундын хөрөнгөд хамаарах хэсгийг салган үнэлж хуваана.

4) Хөрөнгийн үнэлгээ нэмэгдсэн тохиолдолд

Гэрлэлтийн хугацаанд цалингийн орлогоор худалдан авсан үл хөдлөх хөрөнгийн үнэ цэн нэмэгдсэн бол тухайн нэмэгдсэн хэсэг мөн хуваах хөрөнгөд тооцогдоно.

5) Дундын өмчлөлийн үл хөдлөх хөрөнгө хуваах

Дундын өмчлөлийн үл хөдлөх хөрөнгийг хуваахдаа тухайн хөрөнгөд оруулсан талуудын хувь нэмрийг тогтоож хэн нэг нь өөрийн хувийг нөгөө талдаа шилжүүлж оронд нь түүнтэй тэнцэх хэмжээний бэлэн мөнгийг шилжүүлж авах аргаар хуваадаг байна.

6) Зээлийн үлдэгдэлтэй байх тохиолдолд

а) Үл хөдлөх хөрөнгийг үнэлэх арга

Зээлээр худалдан авсан үл хөдлөх хөрөнгийн зээлийг төлж дуусаагүй тохиолдолд тухайн хөрөнгийг хуваахдаа үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнээс зээлийн үлдэгдэл үнийг хассан үнээр тухайн үл хөдлөх хөрөнгийн одоогийн үнэлгээг тогтоож түүнд оруулсан талуудын хувь нэмрийг тогтоосноор оногдох хувийг тогтооно. Түүнчлэн хамтын амьдралын явцад зээлээр худалдан авсан орон сууцны зээлэнд төлсөн төлбөрийг гэрлэгсэд адил хэмжээгээр төлсөнд тооцдог байна. Мөн зээлээр худалдан авсан үл хөдлөх хөрөнгийн зээлийг эргэн төлөх эдийн засгийн чадварыг харгалзан үзээд тухайн хөрөнгийг нөхрийн өмчлөлд шилжүүлэн эхнэрт мөнгөн хэлбэрээр хувийг шилжүүлэх аргаар хөрөнгө хуваах нь элбэг байдаг байна.

с) Зээлийн үлдэгдэл үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнээс хэтэрсэн тохиолдолд

Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэлгээ буурснаас болж гэрлэлтийн явцад худалдан авсан үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ нь зээлийн үлдэгдэлийг төлөхөд хүрэлцэх болох тохиолдол гардаг байна. Харилцан тохиролцож захиргааны журмаар гэрлэлт цуцлуулахад гэрлэгсэд аль аль ажил хийж байх тохиолдолд эхнэр

нь тухай өрийн зарим хэсгийг хариуцахаар тохиролцсон тохиолдолд байдаг боловч нөхрийн нэрээр авсан зээлийн өрийн зарим хэсгийг ажилгүй гэрийн эзэгтэйд төлүүлэхээр шийдвэрлэсэн шүүхийн практик байхгүй байна. Тус улсын давж заалдах шатны шүүхээс зээлийн үлдэгдэл зах зээлийн үнээс давсан бол үл хөдлөх хөрөнгийн үнийг тэг(0) гэж тооцох ёстой бөгөөд үүнийг дагаад тухайн үл хөдлөх хөрөнгийг үл орших хөрөнгөд тооцох тул хуваах хөрөнгө байхгүй гэж ойлгох тул өмнө төлсөн зээлийн төлбөрийг хуваах хөрөнгөд хамааруулж болохгүй гэж шийдвэрлэж байжээ.

7) Хүүхдийн хуваарьт хөрөнгийг зориулалтын бусаар ашиглахтай холбоотой

Тус улсын Иргэний хуулийн 824 дүгээр зүйлд зааснаар эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч нь хүүхдийн хөрөнгийг эрхлэн удирдах эрхтэй байх боловч хүүхдэд өөрт зориулан бий болгосон хуваарьт хөрөнгийн тухайд энэхүү хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хязгаарлана.²⁵⁵

830 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүүхдийн дээрх хуваарьт хөрөнгөд хүүхдэд өвлүүлсэн болон бэлэглэсэн хөрөнгө, өөрийн хүчээр олж авсан хөрөнгө хамаарна.²⁵⁶

830 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүүхдийн хөрөнгийг эрхлэн удирдах эрх түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчид байхгүй эсхүл тухайн хөрөнгийг шилжүүлсэн гуравдагч этгээд хөрөнгө эрхлэн удирдагчийг тогтоогоогүй бол хүүхдийн өөрийн болон төрөл, садан эсхүл прокурорын хүсэлтээр Гэр бүлийн шүүх хөрөнгө хариуцах этгээдийг тогтооно.²⁵⁷

Гуравдагч этгээд хөрөнгө эрхлэн хариуцагчийг тогтоосон боловч энэхүү эрх дуусгавар болсон эсхүл түүнийг солих шаардлага бий болсон боловч гуравдагч этгээд хариуцагчийг дахин тогтоогоогүй бол мөн хүүхдийн өөрийн болон төрөл, садан эсхүл прокурорын хүсэлтээр Гэр бүлийн шүүх хөрөнгө хариуцах этгээдийг тогтооно.²⁵⁸

²⁵⁵ Япон улсын Иргэний хуулийн 824 дүгээр зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²⁵⁶ Япон улсын Иргэний хуулийн 830 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²⁵⁷ Япон улсын Иргэний хуулийн 830 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

²⁵⁸ Япон улсын Иргэний хуулийн 830 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC0000000089/>.

Хүүхдийн хөрөнгийг эрхлэн удирдах эрх бүхий этгээд болон хүүхдийн хооронд гарсан маргаантай холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа нь хөрөнгө эрхлэн удирдах эрх дуусгавар болсноос хойш таван жил байна.²⁵⁹

Хүүхэд насанд хүрэхээс өмнө түүний хөрөнгийг эрхлэн удирдах эрх дуусгавар болж хүүхдэд хууль ёсны асран хамгаалагч байхгүй бол дээр заасан хугацааг хүүхэд насанд хүрсэн болон хууль ёсны асран хамгаалагчтай болсон үеэс тоолно.²⁶⁰

Эцэг, эх нь хүүхдийн хөрөнгийг эрхлэн удирдах эрхээ хэрэгжүүлэхдээ түүний хууль ёсны эрхэд хохирол учруулахуйц байх эсхүл энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал байвал хүүхэд өөрөө эсхүл түүний төрөл садан, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, мөн прокурорын хүсэлтээр Гэр бүлийн шүүх эцэг, эхийн хүүхдийн хөрөнгийг эрхлэн удирдах эрхийг хүчингүй болгож шийдвэрлэнэ.²⁶¹

Тус улсын Иргэний хуулийн 835 дугаар зүйлд заасан эцэг, эхийн хүүхдийн хөрөнгийг эрхлэн удирдах эрхийг хүчингүй болгосон шийдвэрийг эрх хасуулсан, этгээд эсхүл тэдний төрөл, садны хүний хүсэлтээр эрх хасах болсон шалтгаан нөхцөл арилсан гэж үзвэл Гэр бүлийн шүүх сэргээх шийдвэр гаргана.²⁶²

Эцэг, эх нь зайлшгүй шалтгаан байгаа бол Гэр бүлийн шүүхийн зөвшөөрлөөр Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүүхдийн хөрөнгийг эрхлэн удирдах эрхээсээ татгалзаж болно.²⁶³ Мөн хүүхдийн хөрөнгийг эрхлэн хариуцах эрхээсээ татгалзсан шалтгаан нөхцөл арилсан бол Гэр бүлийн шүүхийн зөвшөөрлөөр эрхээ сэргээлгэж болно.²⁶⁴

3. ХБНГУ

Гэр бүлийн хэрэг маргаан

²⁵⁹ Япон улсын Иргэний хуулийн 832 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC00000000089/>.

²⁶⁰ Япон улсын Иргэний хуулийн 832 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC00000000089/>.

²⁶¹ Япон улсын Иргэний хуулийн 835 дугаар зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC00000000089/>.

²⁶² Япон улсын Иргэний хуулийн 836 дугаар зүйл.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC00000000089/>.

²⁶³ Япон улсын Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC00000000089/>.

²⁶⁴ Япон улсын Иргэний хуулийн 837 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/4275>,
<https://laws.e-gov.go.jp/law/129AC00000000089/>.

Тус улсын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хуульд гэр бүлийн хэрэг маргаан болон бусад гэж ангилан зохицуулсан байна. Тус хуулийн 111 дүгээр зүйлд заасан дараах хэрэг маргаанд дор дурьдсаныг ойлгоно.

1. Гэрлэлт
2. Эцэг тогтоох
3. Цусан төрөл
4. Үрчлэлт
5. Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх
6. Тэтгэвэр
7. Тэжээн тэтгэх
8. Гэр бүлийн хөрөнгө
9. Бусад
10. Хамтран амьдрагч

Гэрлэлттэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

121 дүгээр зүйлд зааснаар гэрлэлттэй холбоотой маргаан дор дурьдсан маргааныг ойлгоно.

1. Гэрлэлт цуцлалт
2. Гэрлэлтийг хүчингүй болгох
3. Талуудын гэр бүлийн харилцааг тогтоох

Шүүхийн харьяалал

122 дугаар зүйлд зааснаар дор дурьдсан дарааллаар харьяаллыг тогтооно.

1. Насанд хүрээгүй хүүхдүүдтэй хамт оршин сууж байгаа газрын харьяа шүүх
2. Гэрлэгсэдийн хэн нэг нь насанд хүрээгүй хүүхэдтэй хамт амьдарч байгаа бол тухайн гэрлэгчийн оршин сууж байгаа газрын харьяа шүүх
3. Гэрлэгсэдийн хамгийн сүүлд хамт оршин байсан газрын харьяа шүүх
4. Хариуцагчийн байнга оршин суугаа газрын харьяа шүүх
5. Нэхэмжлэгчийн байнга оршин суугаа газрын харьяа шүүх
6. 98 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэрлэх үед 16 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй гэрлэгчийн байнга оршин суугаа газрын харьяа шүүх
7. Берлин хотын Шёнебергийн шүүх (Schöneberg in Berlin)

Хэрэг хянан шалгах ажиллагаанд оролцогчийн эрх зүйн чадамж(125 дугаар зүйл)

Эрх зүйн чадамж хязгаарлагдмал гэрлэгсэд гэрлэлттэй холбоотой хэрэг маргааны ажиллагаанд оролцох эрхтэй байна. Эрх зүйн чадамжгүй гэрлэгсэдийг

хууль ёсны төлөөлөгч төлөөлөх бөгөөд гэрлэлт цуцлалт, гэрлэлтийг хүчингүй болгох нэхэмжлэл гаргахад Гэр бүлийн шүүхийн зөвшөөрлийг авсан байна.

Гэрлэлт болон гэрлэлттэй холбоотой бусад ажиллагаа(125 дугаар зүйл)

Гэрлэлттэй холбоотой хэд хэдэн маргааныг нэгтгэн шийдвэрлэж болно. Гэхдээ гэрлэлттэй холбоотой маргааныг бусад маргаантай нэгтгэн шийдвэрлэж болохгүй бөгөөд энэ нь 137 дугаар зүйлд хамаарахгүй байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрлэлт цуцлалт болон хүчингүй болгох тухай гомдол гаргасан бол гэрлэлт хүчингүй болгох тухай шийдвэр гаргана.

Шүүхийн зарим хянан шалгах ажиллагаа(125 дугаар зүйл)

Шүүх хшийдвэр гаргах үндэслэл болох нөхцөл байдлыг тогтоох зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зарим шаардлагатай шалгах ажиллагааг явуулах ёстой. Гэрлэлт цуцлалт, гэрлэлт хүчингүй болгохтой холбоотой маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох этгээд мэдүүлээгүй баримтууд нь гэрлэлтийн харилцааг хадгалахад хүчин төгөлдөр бус байна. Харин хүсэлт гаргагч энэ талаар эсэргүүцээгүй бол харгалзан үзэх боломжтой байна. Гэрлэлт цуцлуулах тухай маргааныг шийдвэрлэх явцад шүүх нь гэрлэлт цуцлуулахыг зөвшөөрөхгүй байга гэрлэгчийн Иргэний хуулийн 1568 дугаар зүйл заасан бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж болно.

Талууд шүүх хуралдаанд оролцох(125 дугаар зүйл)

Шүүх нь гэрлэгсэдийн шүүх хуралдаанд заавал оролцуулж тэдний санал бодлыг заавал сонсоно. Ингэхдээ эхнэр эсхүл нөхрийг хамгаалах болон бусад шалтгаанаар шаардлагатай гэж үзвэл аль нэг талыг оролцуулахгүй байж болно. Гэрлэгсэд насанд хүрээгүй хүүхэдтэй байх тохиолдолд талуудын санал бодлыг сонсох бөгөөд зөвлөгөө авах боломжоор хангана. Гэрлэгсэдийн хэн аль нь шүүх хуралдаанд оролцох боломжгүй байх эсхүл шүүхээс хэт хол байгаа шалтгаанаар шүүх хуралдаанд өөрийн биеэр оролцох боломжгүй бол ойр шүүхийн шүүгч түүнээс мэдүүлэг авах ажиллагааг зохион байгуулна.

Гэрлэлтийг хүчингүй болгож шийдвэрлэсэн маргааны зардал(132 дугаар зүйл)

Гэрлэлтийг хүчингүй болгож шийдвэрлэсэн бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг талууд тэнцүү гаргана. Гэхдээ гэрлэгсэдийн хэн аль нь гэрлэлт хүчингүй болохыг мэдэж байсан эсхүл гэрлэхдээ хүсэл зоригоос гадуур хууран мэхлэх, албадах зэрэг хууль бус аргаар гэрлэсэн бол шүүх зардлыг талуудад

ялгамжтай төлүүлэхээр шийдвэрлэж болно. Насанд хүрээгүй хүүхдэд зардлыг хариуцуулахыг хориглоно.

Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийн агуулга(133 дугаар зүйл)

Нэхэмжлэлд дараах агуулгыг тусгасан байна.

1. Насанд хүрээгүй хүүхдийн нэр, төрсөн он сар өдөр, оршин суургаа газрын хаяг
2. Гэрлэгсэд насанд хүрээгүй хүүхдийн хууль ёсны асран хамаалагч, хүүхэдтэй уулзах болон тэжээн тэтгэх асуудал, гэр бүлийн орон сууц, бусад эд хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бусад асуудлыг тохирсон эсэх
3. Гэрлэгсэд гэр бүлийн бусад асуудлаар маргаан хянан хэлэлцүүлж байгаа эсэх
4. Гэрлэлтийн гэрчилгээ насанд хүрээгүй хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбарыг хавсаргах

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх(136 дугаар зүйл)

Шүүх гэрлэгсэд цаашид гэрлэлтийн харилцааг үргэлжлүүлэх боломжтой гэж үзвэл энэ талаар шийдвэр гаргаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Гэрлэгсэд 1 жилээс дээш хугацаагаар тусдаа амьдарсан бөгөөд талууд татгалзвал шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно. Мөн талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай хүсэлт гаргасан тохиолдолд шүүх ажиллагааг түдгэлзүүлэлгүйгээр гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргахыг хориглоно. Түдгэлзүүлэх шийдвэрийг нэг удаа дахин гаргаж болох бөгөөд хугацаа нь 1 жилээс хэтэрч болохгүй төдийгүй 3 жилээс дээш хугайцаагаар тусдаа амьдарсан тохиолдолд хугацаа нь 6 хүртэл сарын хугацаатай байна.

Гэрлэлт цуцлалт болон бусад маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг хамт явуулах(133 дугаар зүйл)

Гэрлэлт цуцлуулах тухай болон гэр бүлийн бусад маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг хамт явуулна. Гэр бүлийн бусад маргаанд тэтгэвэр хуваах, насанд хүрээгүй хүүхдийн тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой асуудал, мөн хуульд заасан тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой маргаан, гэр бүлийн хөрөнгийн маргаан, гэр бүлийн оршин суух газрын талаарх маргаан зэргийг ойлгоно.

Зарим хянан шийдвэрлэх ажиллагааг тусад нь явуулах(140 дугаар зүйл)

Тэжээн тэтгэх эсхүл гэр бүлийн хөрөнгийн талаарх маргаанд гэрлэгсэдээс гадна гуравдагч этгээд оролцох тохиолдолд тэжээн тэтгэхтэй холбоотой

маргааныш тусад нь шийдвэрлэнэ. Мөн шүүх зарим хамт шийдвэрлэхээр хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа маргааныг тусад нь шийдвэрлэж болно. Тэтгэлэг хуваах эсхүл гэр бүлийн хөрөнгийн талаарх маргаан гэрлэлтийг цуцлах тухай шийдвэр гарахаас өмнө шүүх хуралдаан явуулах боломжгүй бол, бусад шүүхэд хянагдаж буй маргааны улмаас тэтгэвэр хуваахтай холбоотой маргааныш түдгэлзүүлсэн бол, эцэг тогтоолгох тухай маргааныг шүүх хүүхдийн эрх ашгийг харгалзан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн зэрэг тохиолдолдыг ойлгоно.

Эцэг тогтоох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам(151 дүгээр зүйл)

Эцэг тогтоохтой холбоотой маргааныг Гэр бүлийн шүүхэд явуулах бөгөөд дор дурьдсан маргааныг шийдвэрлэх ажиллагааг ойлгоно.

1. Эцэг тогтоох
2. Хүүхэдтэй уулзах болон хувийн мэдээллийг гаргуулах тухай
3. Хүүхдийг хүлээн авах
4. Асран хамгаалах
5. Насанд хүрээгүй хүүхэд эсхүл ургийг хамгаалах шүүхээс төлөөлөгч томилох
6. Сэтгэцийн өвчний улмаас эрхийг хязгаарлах, албадан эмнэлэгийн албадлагын арга хэмжээ тухай шийдвэр гаргах
7. Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуульд заасан ажиллагаа

Зарим хянан шийдвэрлэх ажиллагааг тэргүүн ээлжинд явуулах зарчим(151 дүгээр зүйл)

Хүүхдийн оршин газар, хүүхэдтэй уулзах, шилжүүлэх авах болон эцэг тогтоох зэрэг хүүхдийн эрх ашиг сонирхолд шууд нөлөөлөхүйц ажиллагааг тэргүүн ээлжинд яаралтай шийдвэрлэнэ. Энэхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлснээс хойш 1 сарын дотор шийдвэрлэх бөгөөд хурал явуулах өдрийг талуудтай зөвшилцөж болно. Шүүх хурал явуулах өдрийг өөрчлөх зайлшгүй шалтгаан байвал өөрчлөх боломжтой бөгөөд өөрчлөх тухай хүсэлт гаргасан бол шалтгаанаа заавал тайлбарлана.

Үрчлэлт(186 дугаар зүйл)

Үрчлэлттэй холбоотой дараах маргааныг хянан шийдвэрлэнэ.

1. Үрчлэлт

2. Үрчлэлтийг итгэмжлэлээр төлөөлөх
3. Үрчлэлтийг хүчингүй болгох

Шүүхийн харьяалал(187 дугаар зүйл)

Дээр дурьдсан 1-3 дахь хэсэгт заасан хянан шийдвэрлэх ажиллагааг тус хуулийн 187 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар үрлэгч эцэг, эх болох хүний эсхүл тэдний хэн алины байнга оршин сууж байгаа газрын харьяа шүүхэд шийдвэрлэнэ. 187 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ХБНГУ-ын харьяалах шүүх байхгүй бол хүүхдийн байнга оршин суугаа газрын харьяалах шүүхэд шийдвэрлэнэ.

Үрчлэгч болох эцэг, эхийн байнга оршин суугаа газар гадаадад бол, үрчлэлтийн тухай хүсэлт гаргахаас өмнө сүүийн 2 жилийн дотор үрчлэгдэгчийн байнгын оршин суугаа газар гадаадад байсан бол, ХБНГУ-ын Гадаад үрчлэлтийн тухай тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 2 дахь заасныг дагаж мөрдөнө.

Дээр дурьдсан шүүхийн харьяалал байхгүй бол Берлин хотын Шёнебергийн шүүхэд (Schöneberg in Berlin) харьяалан шийдвэрлэх бөгөөд тус шүүхээс зайлшгүй шалтгаан байна гэж үзвэл өөр шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлж болно.

Оролцогч(188 дугаар зүйл)

Доор дурьдсан хүнийг ойлгоно.

Энэ хуулийн 186 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үрчлэлтийг шийдвэрлэх ажиллагаанд дор дурьдсан хүнийг оролцогч гэж ойлгоно.

- үрчлэгч болон үрчлэгдэгч
- үрчлэгдэгч насанд хүрээгүй бөгөөд Иргэний хуулийн 1747 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, 4 дэх хэсэгт хамаарахгүй Иргэний хуулийн 1772 дугаар зүйлд хамаарах тохиолдолд үрчлэгдэгчийн эцэг, эх
- Иргэний хуулийн 1749 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хамаарахгүй тохиолдолд үрчлэгчийн эхнэр, нөхөр эсхүл хамтран амьдрагч болон үрчлэгдэгчийн эхнэр, нөхөр эсхүл хамтран амьдрагч

Энэ хуулийн 186 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үрчлэлтийг итгэмжлэлээр төлөөлж шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлээр оролцож буй хүнийг оролцогч гэж ойлгоно.

Энэ хуулийн 186 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үрчлэлтийг итгэмжлэлээр төлөөлж шийдвэрлэх ажиллагаанд дор дурьдсан хүнийг оролцогч гэж ойлгоно.

- үрчлэгч болон үрчлэгдэгч
- насанд хүрээгүй үрчлэгдэгчийн төрсөн эцэг, эх

Мэргэжилтний дүгнэлт(189 дүгээр зүйл)

Насанд хүрээгүй хүүхдийг үрчлүүлж байгаа тохиолдолд шүүх хүүхдийг үрчлүүлэхэд үрчлэгчийн гэр бүлийн нөхцөл байдал зохистой эсэх талаар мэргэжилтний дүгнэлтийг гаргуулна. Мэргэжилтний дүгнэлтийг Үрчлэлтийг зуучлах тухай хуулийн 9а дугаар зүйлийн 2-д заасан үрчлэлт зуучлах эрх бүхий байгууллагаас гаргуулж авна. Энэ байгууллага оролцоогүй тохиолдолд Хүүхэд, залуучуудын газрын мэргэжилтний дүгнэлтийг хүлээн авна.

Дээрх дүгнэлтийг үнэ төлбөргүй гаргуулж авна. Мөн шүүх үрчлэлтийг хэрхэн шийдвэрлэсэн талаар үрчлэлт зуучлах байгууллагад мэдэгдэнэ.

Хүүхэд, залуучуудын газрын оролцоо(194 дүгээр зүйл)

Насанд хүрээгүй хүүхдийг үрчлүүлэх тохиолдолд шүүх заавал Хүүхэд, залуучуудын газрын байр суурийг сонсоно. Тус байгууллага үрчлэлттэй холбоотой дүгнэт гаргасан бол хамаарахгүй.

Шүүх Хүүхэд, залуучуудын газрын байр суурийг сонссон эсхүл тус газраас дүгнэлт гаргасан бол шүүх үрчлэлтийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тус байгууллагад заавал мэдэгдэнэ. Хүүхэд, залуучуудын газар шүүхийн шийдвэрт давж заалдах эрхтэй байна.

Шүүх үрчлэлтийг шийдвэрлэх(197 дүгээр зүйл)

Шүүх үрчлүүлэхээр шийдвэрлэсэн хууль зүйн үндэслэлээ заавал дурдана. Иргэний хуулийн 1747 зүйлийн 4 дэх хэсэгт заасан эцэг, эхийн хэн алины зөвшөөрөл шаардахгүй байх тохиолдолд мөн шийдвэрт энэ талаар заавал тусгана.

Энэхүү шийдвэрийг үрчлэгчид хүргүүлснээр үрчлэгч нас барсан бол хүүхдэд хүргүүлснээр хууль зүйн үр дагавар бий болно.

Дээрх шийдвэрт давж заалдах эрхгүй байна. Мөн шийдвэрийг өөрчлөх болон дахин шийдвэрлэхийг зөвшөөрхгүй болно.

ХОЁР. ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1. ХБНГУ

Өсвөр насны хүүхдийн шүүхийн эрх зүйн орчин

Тус улсад 1908 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Франкфуртэд анхны өсвөр насны хүүхдийн хэргийг шүүх эрүүгийн хэргийн шүүх байгуулагдсан байна.²⁶⁵ Тухайн үед гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны этгээдийн хэргийн Эрүүгийн хуульд заасан журмын дагуу явуулдаг байсан ба өсвөр насны этгээдэ зориулсан тусгайлсан хууль байхгүй байсан тул шүүхийн баталсан журмын дагуу өсвөр насны этгээдийн хэргийг тусгайлсан танхим хариуцдаг байсан байна. 1923 оны 2 дугаар сарын 16-ны өдрөөс²⁶⁶ эхлэн Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хууль батлагдан гарч энэхүү хуулийн хүрээнд гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг яллах зорилго бүхий эрүүгийн хууль тогтоомжоос хүмүүжүүлэх агуулга бүхий эрх зүйн тогтолцоог бий болгох зорилгыг тавьсан байна.

Тус хувьд өсвөр насны хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэхдээ дээр дурьдсанчлан яллахаас илүүтэй сургаж, хүмүүжүүлэх агуулгын зорилгоо болгодог тул Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хууль өөрийн гэсэн онцлогыг агуулсан байдаг байна. Үүнд:

- **Нэгдүгээрт**, прокурор гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдийн талаар зөвхөн Өсвөр насны хүүхдийн шүүхэд хандах ёстой бөгөөд ингэснээр өсвөр насны хүүхдийн үйлдсэн аливаа гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь бие даасан мэргэжлийн шүүхээр шийдвэрлүүлэх боломжийг бий болгосон байна.²⁶⁷ Ингэснээр шүүх хүүхдийг сурган хүмүүжүүлэх зорилго бүхий хариуцлага ногдуулахаас эхлээд хорих хүртэл арга хэмжээг энэхүү шүүхийн эрх мэдэлд олгосон байна. Энэ өсвөр насны хүүхдийн үйлдсэн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхийн эрх мэдэлд олгож байгаа хэлбэр бөгөөд ойлгож болох юм.

²⁶⁵ 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 192 면.

²⁶⁶ 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 192 면.

²⁶⁷ БНСУ-ын тухайд прокурор нь үйлдсэн гэмт хэргийн хүнд хөнгөнөөс хамаарч ердийн эрүүгийн хэргийн шүүхээр хэргийг шийдвэрлүүлэхээр хандах эсхүл Гэр бүлийн шүүхийн өсвөр насны хүүхдийн хэргийн танхимд хандах боломж байдаг бөгөөд энэ нь ХБНГУ-аас өөр буюу өсвөр хүүхдийн үйлдсэн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг прокурорын эрх мэдэл олгож байгаа явдал юм.

БНСУ-ын хувьд тус улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт²⁶⁸ зааснаар хүүхдийн харгалзах этгээд(асран хамгаалагч) мөн түүнийг орлох этгээдийг тогтоох шийдвэр, Хүүхдийн халамжийн тухай хуульд заасан халамжийн газар, хамгаалах байранд хүмүүжүүлэх тухай шийдвэр гаргах тухайн байрыг тогтоохтой холбоотой шийдвэр мөн эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн биелүүлэх ажиллагаатай холбоотой эрх мэдэл прокурорт байдаг байна.

- **Хоёрдугаарт**, өсвөр насны хүүхдийн хууль зүйн хамгаалалтын тогтолцоог бий болгосон. Энэ нь өсвөр насны хүүхэд гэмт хэрэг холбогдон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэх тэр мөчөөс эхлэн хүүхдийг харгалзах хамгаалах этгээдийг оролцуулж хэргийг хянан шийдвэрлэх бүхий л ажиллагаанд оролцох бөгөөд хүүхдийн өсөж хүмүүмжсэн орчин, зан төлөв зэргийг судлан тайлагнах, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, асран хамгаалагчийн үүргийг гүйцэтгэхээс гадна хүүхдэд авах арга хэмжээ, шүүхээс гарах шийдвэр түүнийг биелүүлэх ажиллагаанд заавал оролцох зэрэг үүргийг хүлээдэг байна.²⁶⁹
- **Гуравдугаарт**, тус улсын өсвөр насны хүүхдийн шүүх нь өсвөр насны хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн боловсрол хүмүүжилд шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоож болох бөгөөд ингэснээр хүүхдийн гэр бүлийн болон нийгмийн амьдралд эргэн хэвийн оролцох боломжийг бий болгодог байна. Мөн насанд хүрсэн хүний үйлдсэн эрүүгийн хэрэгт оногдуулдаг ялын төрөл болох хорих ялаас гадна бусад олон төрлийн сургалт хүмүүжлийн шинжтэй хариуцлагыг хуульд зохицуулсан тул хорих ял оноохоос илүүтэй эдгээр хариуцлагыг оногдуулахыг илүүд үздэг байна. Өсвөр насны хүүхдэд хорих ял оногдуулсан тохиолдолд хүүхдийн сурлага хүмүүжилд шаардлагатай гэж үзвэл хорих ял гүйцэтгэхийг хойшлуулах зэрэг арга хэмжээг авч тухайн хүүхдэд оногдуулж байгаа аливаа хариуцлагыг зөвхөн хүүхдийн сурлага хүмүүжлийн шинжтэй байх түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг хангалттай өргөн хүрээнд зохион байгуулах боломжтой байхаар зохицуулсанд оршино.²⁷⁰

ХБНГУ-д өсвөр насны хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийг баримтлах бөгөөд тус хуульд өөрөөр зааснаас бусад тохиолдолд ердийн эрүүгийн хууль тогтоомжид заасныг баримталдаг байна.

Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуульд хамаарах этгээд

ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хууль нь тус улсын эрүүгийн хууль тогтоомжид заасан гэмт хэргийг үйлдсэн 14-18 насны мөн 18-21 насны

²⁶⁸ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хууль.

<https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EC%86%8C%EB%85%84%EB%B2%95>

²⁶⁹ 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 193 면.

²⁷⁰ 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 194 면.

этгээдэд хамаарна.²⁷¹ 18-21 насны этгээдийн хэрэг үйлдэх үеийн ёс зүй болон сэтгэл зүйн өсөлт хөгжил зэргийг харгалзан үзэхэд өсвөр насны хүний хэмжээнд байх төдийгүй үйлдсэн гэмт хэргийн төрөл, гэмт хэргийн нөхцөл байдал, гэмт хэргийн сэдэл зэргээс харахад өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэрэгт хамааруулах боломжтой байх тохолдолд мөн энэхүү хуульд хамааруулна.²⁷² Гэхдээ 18-21 насны этгээдийн хувьд энэ хуульд заасан дараах зарим зүйл хамаардаг.²⁷³

- 1) 4 дүгээр зүйл. Өсвөр насны хүний үйлдсэн хууль бус үйлдлийн ангилал
- 2) 5 дугаар зүйл. Өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийн үр дагавар
- 3) 6 дугаар зүйл. Бусад үр дагавар
- 4) 7 дугаар зүйл. Бусад хариуцлага
- 5) 8 дугаар зүйл.
- 6) 9 дугаар зүйлийн дэх хэсэг.
- 7) 10 дугаар зүйл.
- 8) 11 дүгээр зүйл.
- 9) 13 дугаар зүйл.
- 10) 14 дүгээр зүйл.
- 11) 15 дугаар зүйл.
- 12) 15а дугаар зүйл.
- 13) 16 дугаар зүйл.
- 14) 17 дугаар зүйл.
- 15) 18 дугаар зүйл.
- 16) 21 дүгээр зүйл.
- 17) 22 дугаар зүйл.
- 18) 23 дугаар зүйл.
- 19) 24 дүгээр зүйл.
- 20) 25 дугаар зүйл.
- 21) 26 дугаар зүйл.
- 22) 26а дугаар зүйл.
- 23) 27 дугаар зүйл.
- 24) 28 дугаар зүйл.
- 25) 29 дүгээр зүйл.
- 26) 30 дугаар зүйл.
- 27) 31 дүгээр зүйл.
- 28) 32 дугаар зүйл.
- 29) 45 дугаар зүйл.
- 30) 47 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1(2-3), 2,3 дахь хэсэг
- 31) 52 дугаар зүйл.
- 32) 52а дугаар зүйл.
- 33) 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.
- 34) 55 дугаар зүйл.

²⁷¹ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 1 дүгээр зүйл. https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015.

²⁷² ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 105 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁷³ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хууль. https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

- 35)66 дугаар зүйл.
36)74 дүгээр зүйл.
37)79 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

Тус улсад энэхүү хуульд хамаарах этгээдийн талаар хууль хэрэглээний эхэн үедээ 18-21 насны хүнийг энэ хуульд хамааруулахгүй ердийн Эрүүгийн хуулийн хүрээнд хариуцлага хүлээх ёстой гэж үзэх эрдэмтэд байсан боловч энэ хуульд хамааруулсан хувь нь 1954 он 22 орчим хувь байсан бол 2011 онд 63 хувь болтлоо өссөн бөгөөд энэхүү хуульд хамааруулж хариуцлага хүлээлгэх нь практикт нэгэнт тогтсон байна. Энэ талаар дүгнэхдээ өнөөдрийн нийгэмд өсвөр насны хүн насанд хүрч бие даасан нийгэмд биеэ авч явах хүртэл хугацаанд сургуульд суралцах хугацаа, мэргэжлийн ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай сургалтад хамрагдах хугацаа, гэр бүлийн орчинд эцэг, эхийн асран хамгаалалтад байх хугацаа зэрэг нь нэмэгдсэнтэй хамраалтай гэж дүгнэдэг байна.²⁷⁴ Өөрөөр хэлбэл насанд хүрч нийгмийн амьдрал хөл тавин биеэ даан амьдрахад нэлээдгүй хугацаа шаардагдах болсон гэж үзэж болох юм.

Түүнчлэн 2001 оны байдлаар тус улсын хойд хэсгийг өмнөд хэсэгтэй харьцуулахад Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийг хэрэглэх нь өндөр хувьтай буюу 18-21 насны хүний үйлдсэн нийт гэмт хэргийн 90 хувийг тус хуулиар шийдвэрлэсэн бол өмнөд хэсэгт 47.9 хувьтай байсан байна. Мөн төв суурин газрыг хөдөө орон нутагтай харьцуулахад тус хуулийн дагуу шийдвэрлэх нь өндөр хувьтай байх бөгөөд хүнд гэмт хэрэгт мөн энэхүү хуулийг хэрэглэх хувь өндөр байгаа тул 18-21 насны хүний үйлдсэн гэмт хэргийг энэхүү хуулиар шийдвэрлэхгүй байх нь зөв гэж үзэх тохиолдолд гарч байгаа юм байна.²⁷⁵

Мөн энэ хуульд бас нэгэн анхаарууштай зүйл нь энэхүү хуулийн хүрээнд хариуцлага хүлээлгэхийн тулд эрүүгийн хариуцлага хүлээх чадварын тухай ойлголт юм. Энэхүү хууль нь өсвөр насны хүн Эрүүгийн хуульд заасан хэрэг хүлээх чадвараас гадна гэмт хэрэг үйлдэх үедээ тухай гэм буруутай үйлдлээ ёс суртахууны болон сэтгэл санааны өсөлт бойжилтын хувьд хангалттай ойлгож ухаарсан байх гэсэн шаардлагыг харгалзан үздэг бөгөөд энэ шаардлагыг хангаагүй байна гэж үзвэл энэхүү хуульд заасан сургалт, хүмүүжлийн зорилго бүхий шийдвэрийг гаргадаг байна.²⁷⁶

Энэхүү хуульд заасан хэрэг хүлээх чадварыг дээрхийн адил гэм буруутай үйлдлээ ёс суртахууны болон сэтгэл санааны өсөлт бойжилтын хувьд хангалттай ойлгож ухаарсан байх гэсэн хүрээнд дүгнэдэг бол ердийн Эрүүгийн хуульд заасан хэрэг хүлээх чадварыг сэтгэцийн эрүүл мэндтэй холбон ойлгодог бөгөөд эдгээр хэрэг хүлээх чадварыг тус тусдаа бие даасан шинжээр тодорхойлох шаардлагатай гэж ойлгож болох юм. Өөрөөр хэлбэл өсвөр насны хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхдээ хэрэг хүлээх чадварыг Эрүүгийн хуульд заасан хэрэг

²⁷⁴ 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 195 면.

²⁷⁵ 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 196 면.

²⁷⁶ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйл.
https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015.

хүлээлгэхэд тавигдах шаардлагаас гадна Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хэрэг хүлээх чадварыг тогтоох шаардлагатай байдаг байна.²⁷⁷

Өсвөр насны хүүхдийн шүүхийн шүүгч, прокурорт тавигдах шаардлага

Тус улсын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 37 дугаар зүйлд зааснаар шүүгч, прокурор нь боловсролын салбарын мэдлэг, өсвөр насны хүүхдийн боловсрол, хүмүүжлийн талаар туршлагатай байх шаарддаг байна. Мөн гэмт явдал судлал, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухаан, өсвөр насны хүүхдийн сэтгэл судлал зэрэг салбарын мэдлэг байх ёстой байдаг байна.²⁷⁸

Гэвч практикт Өсвөр насны хүүхдийн шүүхийн шүүгчийг томилоход дээрх дурьдсан шаардлагыг тусгайлан авч үздэггүй бөгөөд энэхүү шүүхийн шүүгч нь зөвхөн өсвөр насны хүүхдийн хэрэг маргааныг дагнан шийдвэрлэдэггүй байх тохиолдол элбэг байдаг байна. Ялангуяа Фрайбург, Оффенбургын шүүхүүдийн харьяа дүүргийн 29 шүүхийн Өсвөр насны хүүхдийн шүүхийн 33 шүүгчээс авсан санал асуулгаар 66 хувиас дээш нь өсвөр насны хүүхэдтэй хамаарал бүхий нийтийн арга хэмжээнд оролцож байсан туршлагатай, тус шүүхэд ажиллахыг илүүд үздэг эсэх, мөн тус шүүхийн шүүгчийн ажил үүргийн талаар хэр анхаарал хандуулдаг эсэх, насны байдал, хүүхэдтэй эсэх зэрэг нь тус шүүхийн шүүгчээр ажиллахад чухал биш хариулсан байна. Мөн санал асуулгад оролцсон шүүгчдийн дөрөвний нэгд хүрэхгүй хувь нь Өсвөр насны хүүхдийн шүүгчээр дагнан ажиллаж байгаа бөгөөд бусад нь ердийн эрүүгийн хэргийн шүүхийн харьяалалын хэргийн давхар хариуцан ажилладаг гэжээ.²⁷⁹

Өсвөр насны хүүхдийн шүүх

Тус улсын Өсвөр насны хүүхдийн шүүх нь 14-18 насны өсвөр насны хүүхэд, 18-21 насны хүний үйлдсэн гэмт хэргийг харьяалан шийдвэрлэдэг шүүхийн хувьд ердийн иргэний, эрүүгийн хэрэг маргааныг харьяалан шийдвэрлэдэг шүүхийн бүтцэд байж дүүргийн шүүхэд байгуулагдсан байдаг байна. Өсвөр насны хүүхдийн шүүх нь өсвөр насны хүүхдийн хэргийг тусгайлан хариуцсан шүүгчтэй бөгөөд Дүүргийн шүүхийн эрүүгийн хэргийн шүүгчдээс бүрдүүлдэг байна.²⁸⁰

²⁷⁷ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хууль.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁷⁸ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хууль.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁷⁹ 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 198 면.

²⁸⁰ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

Дүүргийн шүүхийн Өсвөр насны хүүхдийн шүүх нь нэг шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр анхан шатны журмаар хэргийг хянаж шийдвэр гаргадаг. Тухайн шүүхийн харьяалах хэрэг нь хөнгөн хэргийг шийддэг бөгөөд энэхүү төрлийн хэрэгт сургалтад хамрагдах, сахилгын арга хэмжээ, Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуульд заасан нэмэгдэл хариуцлага болон жолоодох эрхийг хасах зэрэг шийдвэр гаргадаг байна.²⁸¹

Дүүргийн шүүхийн нэг шүүгчийн бүрэлдэхүүтэй анхан шатны журмаар шийдвэрлэсэн шийдвэрт гаргасан давж заалдах гомдлыг орон нутгийн шүүхийн хүүхдийн хэргийн шүүх гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэх бөгөөд эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх энэхүү хэргийг хянан хэлэлцдэггүй байна.²⁸²

Мөн дүүргийн шүүхэд өсвөр насны хүүхдийн үйлдсэн хөнгөн хэргийг шүүх өсвөр насны хүүхдийн шүүхээс гадна хорих ялтай хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдийн үйлдсэн хэргийг хянан хэлэлцэх шүүхийн тогтолцоог байдаг. Энэхүү хэргийг хянан хэлэлцэх шүүх бүрэлдэхүүнд 3 шүүгч 2 иргэдийн төлөөлөгч байх бөгөөд иргэдийн төлөөлөгчийг иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах хорооноос сонгодог байна. Дээр дурьдсан 2 иргэдийн төлөөлөгчийн нэг нь эрэгтэй нөгөө нь эмэгтэй хүн байхыг шаарддаг байна.²⁸³ Иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах хорооноос гаргасан нэрсийн жагсаалтаас хүүхдийн шүүх дарааллын дагуу тухайн шүүх хуралдаанд оролцох төлөөлөгчийн сонгон оролцуулдаг байна.²⁸⁴

Прокурор

ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлд өсвөр насны хүүхдийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өсвөр насны хүүхдийн прокурорыг томилно гэж заасан²⁸⁵ байх бөгөөд тус хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу шүүгчийн нэгэн адил боловсролын салбарын мэдлэг, өсвөр насны хүүхдийн боловсрол, хүмүүжлийн талаар туршлагатай байх шаарддаг байна.²⁸⁶ Гэхдээ тус улсад энэхүү прокурорыг томилоход тусгайлан дээрх шаардлагыг хангасан эсэхийг харгалзах болон тусгайлан сургалтад хамрагдах тохиолдол бараг байдаггүй бөгөөд хүүхдийн шүүхийн шүүгчийн хувьд 10-30 жил дагнан хүүхдийн шүүхийн шүүгчээр ажилласан байдаг бол прокурорын тухайд прокуророор томилогдоод 2-3 жил ажиллаж буй шинэ прокурорууд томилогдох нь

²⁸¹ 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 198 면.

²⁸² 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 201 면.

²⁸³ ²⁸³ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 33а дугаар зүйл.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁸⁴ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйл.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁸⁵ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хууль.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁸⁶ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хууль.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

элбэг байдаг байна. Мөн 800 орчим прокуророос авсан санал асуулгаар 60 хувь нь шууд томилогдсон гэж хариулсан бол гуравны нэг хувь нь өөрийн хүсэлтээр өсвөр насны хүүхдийн хэргийн прокуророор ажиллаж байгаа гэж хариулсан байна.²⁸⁷

Өсвөр насны хүүхдийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд томилогдсон прокурор өөрийн эрх үүргийн дүүргийн прокурорт шилжүүлэх боломжтой бөгөөд дүүргийн прокурор энэхүү шүүхэд харьяалах хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд түүнийг төлөөлөн оролцох боломжтой байдаг байна.²⁸⁸

Хүүхэд, залуучуудын байгууллагын оролцоо

Тус улсын Хүүхэд, залуучуудын газар нь насад хүрээгүй хүүхэд, залуучуудын эрх ашгийг хамгаалах болон тэднийг дэмжихтэй холбоотой ажлыг эрхлэн хариуцдаг байгууллагын хувьд өмнө дурьдсан өсвөр насны хүүхдийн шүүхийн ажиллагаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг санал болгох эрх бүхий байгууллага байдаг байна. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд өөрийн төлөөлөгчийг оролцуулж тэдний эрх ашгийг хамгаалах, дэмжих үүргийг гүйцэтгэдэг байна. Энэхүү байгууллага нь өсвөр насны хүүхдэд зориулсан сургалт хүмүүжлийн ажил, тэдний гэр бүлийг дэмжих, холбогдох сургалтыг зохион байгуулахаас гадна гэр бүлийн хэрэг маргаанд урьдчилсан эвлүүлэх арга хэмжээг зохион байгуулах зэрэг ажил үүргийг гүйцэтгэдэг байна.²⁸⁹

Тус байгууллага нь Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуульд зааснаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.²⁹⁰

1. Өсвөр насны хүүхдийг хэрэгт холбогдуулан шалгаж эхлэх үеэс эхлэн түүний хувийн байдал, өсөж торнисон орчин зэрэгт шалгалт явуулж нийгмийн халамж, боловсрол, асран хамгаалах болон тэжээн тэтгүүлж байсан байдал зэргийг үнэлж дүгнэн авах арга хэмжээний талаарх тайланг шүүх, прокурорт гаргаж өгөх
2. Шүүхээс өсвөр насны хүнд үүрэг болгосон аливаа шийдвэрийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, биелүүлээгүй тохиолдолд шүүхэд мэдэгдэх
3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өсвөр насны хүнийг хамгаалах, дэмжих, аливаа сөрөг нөлөөллөөс бий болохоос урьдчилан сэргийлэх түүнтэй холбоотой бүхий л арга хэмжээг авах

Дээрхийн адил арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн тулд өсвөр насны хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгч эхнээс нь оролцох²⁹¹, оролцох

²⁸⁷ 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 203 면.

²⁸⁸ 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 203 면.

²⁸⁹ 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 203 면.

²⁹⁰ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 38 дугаар зүйл.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁹¹ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

боломжийг хангахын тулд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэн болон дуусгавар болсон тухай мэдэгдэх түүнд мэдэгдэх²⁹², мөн өсвөр насны хүнийг хорих тухай шийдвэр гарсан тухай мэдэгдэх²⁹³, түүнд шүүх хуралдаан болох өдөр, цаг, газрыг заавал мэдэгдэх ёстой бөгөөд мөн шүүх хуралдаанд үг хэлэх боломжоор хангах ёстой байдаг байна.²⁹⁴

Дээрх хүүхдийн байгууллагын төлөөлөгч нь хүүхдийг хамгаалах түүнийг дэмжих зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог бөгөөд цагдаагийн байгууллага хэрэг үүсгэн шалгаж эхлэх үеэс эхлэх тус байгууллагад энэ тухай мэдэгдэх ёстой байдаг бөгөөд төлөөлөгч нь хэрэгт холбогдон гадуур шалгагдаж байгаа болон хоригдож буй хүүхэдтэй даруй уулзалт зохион байгуулж түүний хувийн байдал, зан төлөв, өсөж бойжсон орчин, амьдарч буй газар зэрэгт хяналт шалгалт явуулаад зогсохгүй хүүхэд сэтгэл зүйн болон бусад туслалцааг үзүүлснээр хуулийн байгууллагын хэрэг шалгах ажиллагаанаас ирэх айдасыг үгүй болгоход тусалж цаашид хэрэг хянан шалгах ажиллагаанд хэвийн оролцох нөхцөл байдлыг бий болгоход тусалдаг байна. Мөн хохирогч талтай эвлэрэх тал дээр зуучлах үүрэг гүйцэтгэж шүүхийн өмнөх шатанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоход мөн туслалцаа үзүүлдэг байна. Цаашлаад шүүх хуралдаанд оролцож шүүгдэгч хүүхдийн хувийн байдал, өсөж бойжсон орчин зэргийн талаар явуулсан шалгалтын талаарх тайланг танилцуулж тухайн хүүхэд оногдуулах хариуцлагын талаар саналаа илэрхийлэх боломжтой байдаг байна. Хүүхэд оногдуулсан сургалтад хамрагдах болон сахилгын арга хэмжээ хорих тухай гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүрэг хүлээдэг хүлээдэг байна. Хоригдож буй хүүхэдтэй уулзалт зохион байгуулж нийгмийн амьдралд эргэн хэвийн оролцоход бүхий л талаар тусалж дэмжих арга хэмжээг зохион байгуулдаг байна.²⁹⁵

Энэхүү өсвөр насны хүүхдийг хамгаалах, дэмжих ажлыг зөвхөн хүүхдийн асуудал хариуцсан дээрх төрийн байгууллагын ажилтан гүйцэтгэхээс гадна бусад төрийн бус хүүхдийн байгууллагын төлөөлөгч гүйцэтгэж болох бөгөөд үйл ажиллагаанд нь төрийн байгууллага хяналт тавьж ажилладаг байна.

Хариуцлага

Тус улсын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн дагуу гэмт хэрэг хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хариуцлаг оногдуулах үндсэн зорилго нь түүнийг сурган хүмүүжүүлэх түүнд нийцсэн хариуцлага оногдуулахад оршдог байна. Энэхүү хариуцлага нь сурган хүмүүжүүлэх шинжтэй, сахилгын шинжтэй болон зорчихыг эрхийг хязгаарлах, хорих зэрэг байдаг байна.

²⁹² ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 70 дугаар зүйл.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁹³ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 72а дугаар зүйл.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁹⁴ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁹⁵ 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도, 203 면.

1. Сурган хүмүүжүүлэх хариуцлага

Энэхүү хариуцлагын шийдвэр нь өдөр тутмын амьдралын хэв маягыг тогтоон түүний боловсролыг дэмжих, баталгаажуулах зорилго бүхий үүрэг болгосон болон хориглосон захирамж гаргадаг байна.

Шүүгч дараах шийдвэрийг гаргах ²⁹⁶ хугацаа нь 2 жилээс хэтрэхгүй байна.²⁹⁷

- 1) Оршин суух газрыг тогтоох
- 2) Гэр бүлд эсхүл халамжийн байгууллагад оршин суух
- 3) Мэргэжлийн сургалтад хамрагдах, ажлын байрыг хүлээн зөвшөөрөх
- 4) Хөдөлмөр эрхлэх
- 5) Бусдын хараа хамгаалалт, хяналтад байх
- 6) Нийгмийн шинжтэй сургалт, үйл ажиллагаанд оролцох
- 7) Хохирогчтой эвлэрэх талаар хичээх
- 8) Тодорхой хүмүүстэй уулзах, зочид буудал, зугаа цэнгээний газар орохыг хориглох
- 9) Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалтад хамрагдах.

Мөн шүүгч эцэг, эх хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийн дагуу донтох эмчилгээг хийлгэх тухай шийдвэр гаргаж болох бөгөөд хүүхэд 16 насанд хүрсэн бол өөрийнх нь зөвшөөрлийг авна.²⁹⁸

Хүүхдийг сурган хүмүүжүүлэхэд шаардлагатай гэж үзвэл дээр дурьдсан үүрэг болгосон болон хориглосон шийдвэрийг хэрэгжүүлэх тухай хугайцааг өөрчлөх эсхүл үүрэг болгосон болон хориглосон үйлдэл үйл ажиллагааг өөрчлөх, цуцлах, болон хэрэгжүүлэх хугацааг 3 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.²⁹⁹

Өсвөр насны хүүхэд дээрх шийдвэрийг дагаж биелүүлэгүй бол түүнийг хорих шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд хорих тухай шүүхийн шийдвэр гаргах бөгөөд 4 долоо хоногоос хэтрэхгүй байна.³⁰⁰

Мөн шүүгч нь Хүүхэд, залуучуудын газрын саналын дагуу Нийгмийн халамжийн тухай хуульд заасан шаардлагад нийцсэн газарт хүмүүжихийг даалгаж болно.³⁰¹

²⁹⁶ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁹⁷ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 11 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁹⁸ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

²⁹⁹ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 11 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

³⁰⁰ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 11 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.
https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

³⁰¹ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйл.
https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

- 1) Нийгмийн халамжийн тухай хуульд заасан хүүхдийн халамжийн байгууллага³⁰²
- 2) Нийгмийн халамжийн тухай хуульд заасан 24 цагийн үйл ажиллагаатай болон бусад оршин суух зориулалт бүхий халамжийн байгууллага³⁰³

2. Сахилгын хариуцлага

Өсвөр насны хүүхдэд эрүүгийн хариуцлага оногдуулаагүй бол түүний үйлдсэн хууль бус үйлдэлд шүүгч нь сахилгын хариуцлага оногдуулдаг байна.³⁰⁴ Энэхүү шийтгэл эрүүгийн хариуцлагын шижгүй байна.³⁰⁵

Сахилгын шийтгэл нь дараах төрөлтэй байна.³⁰⁶

- 1) Сануулах
- 2) Үүрэг хүлээлгэх
- 3) Зорчих эрхийг хязгаарлах

Сануулах

Түүний үйлдсэн нь хууль бус болох талаар түүнд хатуу анхааруулах замаар дахин ийм үйлдэл гаргахгүй байхыг сануулдаг байна.³⁰⁷

Үүрэг хүлээлгэх

Шүүгч дор дурьдсан үүргийг гүйцэтгүүлэхээр шийдвэр гаргаж болно.³⁰⁸

- 1) Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг өөрийн хүчээр нөхөн сэргээх
- 2) Хохирогчоос биечлэн уучлалт гуйх
- 3) Ажил гүйцэтгэх
- 4) Нийтийн байгууламжид тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгө шилжүүлэх

³⁰² ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

³⁰³ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

³⁰⁴ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

³⁰⁵ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

³⁰⁶ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

³⁰⁷ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 14 дүгээр зүйл.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

³⁰⁸ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

Энэ тохиолдолд өсвөр насны хүүхэд хэрэгжүүлэх боломжгүй бол байвал хамаарахгүй

Шүүгч зөвхөн дараах тохиолдолд тодорхой хэмжээний төлбөр төлүүлэхээр үүрэг болгоно.³⁰⁹

- 1) Хөнгөн гэмт гэмт хэрэг үйлдэж хохирлыг өөрөө төлөх боломжтой байх тохиолдолд
- 2) Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болон авсан шан харамжийг хураах боломжтой байх тохиолдолд

Шүүгч шаардлагатай гэж үзвэл үүрэг болгосон шийдвэрээ өөрчлөх, зарим хэсгийг эсхүл бүгдийг хүчингүй болгож болох бөгөөд дээрх үүргийг биелүүлэгүй бол энэ хуулийн 11 дүгээр зүйл 3 дахь хэсэгт заасан зорчих эрхийг 4 хүртэл долоо хоногоор хязгаарлах тухай шийдвэр гаргаж болно.³¹⁰

Зорчих эрхийг хязгаарлах

Энэхүү зохицуулалтын хүрээнд чөлөөт цагийг хязгаарлах болон урт богино хугацаагаар зорчихыг хязгаарлахыг ойлгоно.³¹¹

Дүгнэлт

ХБНГУ-ын өсвөр насны хүүхдийн шүүхийн тогтолцоо нь насанд хүрээгүй хүүхдийн гэм буруугийн асуудлыг шийдвэрлэхдээ эрүүгийн эрх зүйн тусгайлсан өвөрмөц онцлого тогтолцоог бий болгоод зуугаад жил болжээ. Дараах үндсэн дөрвөн онцлогыг бий болгосон байна.

1. Өсвөр насны хүүхдийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн тогтолцоог бий болгосон
2. Ердийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас зайлсхийсэн хэлбэрийг бий болгосон
3. Төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийг ашиглах, татан оролцуулах
4. Эрүүгийн харуцлагаас гадна хүмүүжлийн шинжтэй арга хэрэгсэл, хариуцлагын тогтолцоог бий болгосон

Гэвч энэхүү тогтолцоо нь тухайн улсын улс төр, эдийн засаг, соёлын онцлог болон хэрэгжүүлэх боломж зэргээс ихээхэн хамаарахаар байх тул Монгол Улсын хүн амын нийгэм эдийн үзүүлэлтүүд улс төр, эдийн засаг, соёлын онцлог боловсон хүчний хүрэлцээ гэх мэт олон зүйлээс хамаарч амжилттай хэрэгжихээр байна.

³⁰⁹ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

³¹⁰ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.
https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

³¹¹ ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хуулийн 16 дугаар зүйл.
https://www.gesetze-im-internet.de/englisch_famfg/index.html#gl_p0015

2. Япон

Өсвөр насны хүүхдийн хэргийн харьяалал

Япон улсын Гэр бүлийн шүүхээр гэр бүлийн хэрэг маргаан, эвлэрүүлэн зуучлал, өсвөр насны хүүхдийн хэрэг маргааныг шийдвэрлэдэг байна. Өсвөр насны хүүхэд гэдэгт 20 хүртэл насны хүнийг ойлгодог байна.³¹²

Доор дурьдсан тохиолдолд өсвөр насны хүүхдийг Гэр бүлийн шүүхэд шилжүүлнэ.³¹³

1. Гэмт хэрэг үйлдсэн
2. Гэмт хэрэг үйлдсэн 14 насанд хүрээгүй хүүхэд
3. Доор дурьдсан шалтгаанаар болон зан байдал амьдарч буй орчин зэргийг харгалзан үзэхэд цаашид гэмт хэрэг үйлдэх магадлалтайд тооцогдсон хүүхэд
 - a. Асран хамгаалагчийн зүй ёсны шаардлагыг үл биелүүлдэг хаалттай хүүхэд
 - b. Шалтгаангүйгээр оршин суугаа газраа орхин тэнүүчилдэг хүүхэд
 - c. Гэмт хэрэг үйлдэж байсан эсхүл ёс суртахуун хүмүүжлийн доголдолтой хүнтэй хүнтэй үерхэж нөхөрлөх эсхүл зүй бус газраар үйлчлүүлдэг хүүхэд
 - d. Өөрийн болон бусдын зан чанарт сөргөөр нөлөөлөх үйлдэл хийдэг хаалттай хүүхэд

Шүүхийн харьяалал

Өсвөр насны хүүхдийн оршин сууж байгаа газрын Гэр бүлийн шүүхэд хэргийг шийдвэрлэх бөгөөд зохих хамгаалалтын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл өөр шүүхэд хэргийг шилжүүлж болно. Харин харьяалын бус байх тохиолдолд хэргийг харьяалын Гэр бүлийн шүүхэд заавал шилжүүлнэ.³¹⁴

Шүүхэд шилжүүлэхээр мэдэгдэх

³¹² Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 2 дугаар зүйл.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³¹³ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³¹⁴ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 5 дугаар зүйл.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

Гэр бүлийн шүүхэд шилүүлэх шаардлагатай өсвөр насны хүүхдийг олж мэдсэн бол шүүхэд мэдэгдэнэ.³¹⁵

Цагдаагийн алба хаагч эсхүл асран хамгаалагч нь доор дурьдсан өсвөр насны хүүхдийн тухайд шууд Гэр бүлийн шүүхэд шилжүүлэхээр мэдэгдэхээс өмнө Хүүхдийн халмжийн тухай хуульд заасан арга хэмжээг авах боломжтой гэж үзвэл хүүхдэд зөвлөгөө үзүүлэх төвд мэдэгдэх арга хэмжээг авах ёстой.³¹⁶

- a. Асран хамгаалагчийн зүй ёсны шаардлагыг үл биелүүлдэг хаалттай хүүхэд
- b. Шалтгаангүйгээр оршин суугаа газраа орхин тэнүүчилдэг хүүхэд
- c. Гэмт хэрэг үйлдэж байсан эсхүл ёс суртахуун хүмүүжлийн доголдолтой хүнтэй хүнтэй үерхэж нөхөрлөх эсхүл зүй бус газраар үйлчлүүлдэг хүүхэд
- d. Өөрийн болон бусдын зан чанарт сөргөөр нөлөөлөх үйлдэл хийдэг хаалттай хүүхэд

Цагдаагийн алба хаагчийн мөрдөн шалгах ажиллагаа

Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй 14 насанд хүрээгүй хүүхдийг олж илрүүлсэн бол тухайн хэргийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж болох бөгөөд ингэхдээ хүүхдийн сэтгэл зүй зэргийг сайтар харгалзан үзэж хэргийн үнэн бодит байдлын тогтоохыг эрмэлзэнэ. Мөн хүүхдийн сэтгэл зүйн байдал бусад онцлог байдлыг харгалзан үзэж мэргэжлийн тусгай мэдлэг алба хаагчаар мэдүүлэг авах ажиллагааг явуулна.³¹⁷

Шаардлагатай гэж үзвэл өсвөр насны хүүхдийн хууль ёсны төлөөлөгч болон бусад этгээдийг дуудан ирүүлж болох боловч адбадан ирүүлэхийг хориглоно. Шалгах ажиллагаанд шаардлагатай гэж үзвэл төрийн болон орон нутгийн байгууллагаас лавлагаа, тайлан гаргаж өгөхийг шаардаж болно.³¹⁸ Мөн үзлэг, нэгжлэг хийх, шинжээчийн дүгнэлт гаргуулах ажиллагааг мөн явуулж болно.³¹⁹

³¹⁵ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.
<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³¹⁶ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.
<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³¹⁷ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 6.2 дугаар зүйл.
<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³¹⁸ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйл.
<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³¹⁹ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 6.5 дугаар зүйл.
<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>
<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд 14 насанд хүрээгүй хүүхдийн үйлдэл дор дурьдсан аль нэг тохиолдолд хамаарч байвал хэргийн холбогдох материалын хамт хэргийг хүүхдийн зөвлөгөө өгөх төвд шилжүүлнэ.³²⁰

- a. Хүнийг санаатай алсан
- b. Хүнийг санаатай алахаас гадна цаазаар авах, бүх насаар нь хорих эсхүл 2-оос дээш жилийн хорих ялтай гэм хэрэг үйлдсэн
- c. Дээрхээс бусад гэмт хэрэг үйлдэж Гэр бүлийн шүүхэд шилжүүлэх шаардлагатай гэж үзсэн бол

Гэр бүлийн шүүхийн хянан шалгах ажиллагаа

Гэр бүлийн шүүх өсвөр насны хүүхэд, асран хамгаалагч, гэрчийг асууж шаардлагатай бусад хянан шалгах ажиллагаа явуулахыг Гэр бүлийн шүүхийн хэрэг мөрдөгчид даалгаж болно.³²¹

Дээрх ажиллагааг явуулахдаа өсвөр насны хүүхэд, хууль ёсны төлөөлөгч, бусад этгээдийн зан байдал, туршлага, авъяас чадвар, орчин гэх мэт байдлыг харгалзан анагаах ухаан, сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх, социологийн болон бусад мэргэжлийн мэдлэг, ялангуяа насанд хүрээгүй хүүхдийн сурган хүмүүжүүлэх газарт тусгаарлан ажиглаж гаргасан дүгнэлтийн үр дүнг ашиглахыг хичээх хэрэгтэй.³²²

Мөн **үзлэг, нэгжлэг** хийхээс гадна **хяналт шалгалт** явуулах эрхтэй байна. Энэхүү ажиллагааг явуулахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан үзлэг, нэгжлэг хийх хяналт шалгалт явуулах ажиллагааны зорилго нь Гэр бүлийн шүүхээр өсвөр насны хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилготой нийцэхгүйц байвал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасныг баримтална.³²³

Гэр бүлийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шийдвэр гаргахаас өмнө шаардлагатай гэж үзвэл өсвөр насны хүүхдийг хамгаалах тухай шийдвэр гарж болно. Үнийг хамгаалах арга хэмжээ гэх бөгөөд **өсвөр насны хүүхдийг хамгаалах байранд байлгах шийдвэр** эсхүл **шүүхийн хэрэг**

³²⁰ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 6.6 дугаар зүйл.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³²¹ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³²² Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 9 дүгээр зүйл.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³²³ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 15 дугаар зүйл.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

мөрдөгчийн хамгаалалтад шилжүүлэх шийдвэр гаргаж болно. Түр хамгаалах тохиолдолд 24 цагаас хэтрүүлэхгүй байна. Хамгаалах байранд шилжүүлэх тохиолдолд 14 хоногоос хэтрүүлэхгүй байх бөгөөд шаардлагатай гэж үзвэл шүүхийн шийдвэрээр энэ хугацааг нэг удаа сунгаж болно. Гэвч цаазаар авах, хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн мөн үйлдсэн гэмт хэрэгт нь холбогдуулан гэрчийн мэдүүлэг авах, шинжилгээ хийх, хяналт шалгалт хийхээр шийдвэрлэсэн

Гэр бүлийн шүүх цаазаар авах болон хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн хэргийг хянаж үзээд гэмт хэргийн шинж байдал зэргийг харгалзан үзээд ердийн эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлүүлэх нь зөв гэж дүгнэвэл хэргийг харьяалах прокурорын газарт шилжүүлнэ.³²⁴ Санаатайгаар хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн 16 дээш насны өсвөр насны хүүхдийг хэргийг мөн дээрхийн адил шийдвэрлэж болох боловч гэмт хэрэг үйлдсэн сэдэл, зорилго, хэлбэр, гэмт хэрэг үйлдсэний дараах нөхцөл байдал, зан байдал, нас, биеэ авч яваа байдал болон амьдралын орчин нөхцөл болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзээд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагагүй гэж үзвэл ердийн эрүүгийн шүүхэд хэргийг шилжүүлэхгүй.³²⁵

Шүүх хуралдаан

Гэр бүлийн шүүх нь хянан шалгах ажиллагааг явуулсны дараа шүүх хуралдаан явуулах шаардлагатай гэж үзвэл энэ тухай шийдвэр гаргана.³²⁶

Шүүх хуралдааныг явуулахдаа эелдэг зөөлөн уур амьсгалыг бүрдүүлж, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдийг өөрийн буруу зан үйлийн талаар эргэцүүлэн бодоход түлхэц өгөх ёстой.³²⁷ Шүүх хуралдааныг хаалттай явуулна.³²⁸

Гэр бүлийн шүүх нь цаазаар авах эсхүл бүх насаар нь хорих болон гурваас дээш жилийн хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдийн шүүх хуралд прокурор оролцох шаардлагагтай гэж үзвэл прокурорыг оролцуулах тухай шийдвэр гаргаж болно. Шүүх хуралд оролцох тухай прокурор хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд шүүх прокурорын саналыг урьдчилан авсан байна.³²⁹

³²⁴ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³²⁵ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 20 дугаар зүйл 2 дахь хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³²⁶ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 21 дүгээр зүйл.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³²⁷ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³²⁸ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³²⁹ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 22.2 дугаар зүйл.

Шийдвэр

Гэр бүлийн шүүх хэргийг хянан хэлэлцээд энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаар хүүхдийг халамжийн байгууллагад шилжүүлэх, 20 дугаар зүйлд зааснаар хэргийг прокурорт шилжүүлэх шаардлагатайгаас бусад тохиолдолд дор дурьдсан хамгаалах хариуцлагын арга хэмжээг авах тухай шийдвэр гаргана. 14 насанд хүрээгүй хүүхдийн тухайд шаардлагатай гэж үзвэл 3 дахь хэсэгт заасан арга хэмжээг авч болно.³³⁰

1. Хамгаалах байрны хараа хяналтад шилжүүлэх
2. Хүүхдийн бие даасан байдлыг дэмжих байгууллага эсхүл хүүхдийн асрамжийн газарт шилжүүлэх
3. Хүүхдийн хорих байгууллагад шилжүүлэх

Хамгаалах байрны дарга хүүхдийн гэр бүлийн орчин болон бусад нөхцөл байдлыг судлах арга хэмжээ авч болно.³³¹

Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн хэргийг 18 дугаар зүйлд зааснаар хүүхдийг халамжийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн, 19 дүгээр зүйлд зааснаар хэргийг хэлэлцэх боломжгүй эсхүл зохисгүй гэж шийдвэрлэсэн, 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хамгаалах арга хэмжээ авах тухай шийдвэр гаргах боломжгүй эсхүл шаардлагагүй гэж шийдвэрлэсэн бол дор дурьдсан **хөрөнгийг хураах тухай шийдвэр** гаргана.³³²

1. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө
2. Гэмт хэрэг үйлдэхэд зориулж өгсөн болон өгөхөөр бэлдсэн хөрөнгө
3. Гэмт үйлдлийн улмаас үүссэн буюу үр дүнд нь олж авсан хөрөнгө эсхүл нөхөн төлбөр болгож авсан хөрөнгө
4. Дээр дурьдсан үйлдлийн шан харамж болгон авсан хөрөнгө

Хураах хөрөнгө тухайн этгээдээс өөр хэн нэгний өмчлөлд байгаа бол тухайн этгээдэд хамаарах хэсгийг хураан авна. Гэвч эрүүгийн хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл хийсний дараа тухайн этгээдээс өөр хэн нэгэнд шилжүүлсэн шилжүүлж авсан этгээд тухайн хөрөнгийг хууль бус гэдгийг мэдсээр байж шилжүүлэн авсан бол бусдын өмчлөлд байгаагаас үл хамаарч хураан авч болно.³³³

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³³⁰ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 24 дүгээр зүйл.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³³¹ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 24 дүгээр зүйл 2 дахь хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³³² Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³³³ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 24.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

Цагдаагийн байгууллага хэргийг шүүхэд шилжүүлэх

Цагдаагийн байгууллага хүүхдийн үйлдсэн хууль бус үйлдлийг шалгаад торгох хүртэл ялтай гэмт хэрэг байвал хэргийг Гэр бүлийн шүүхэд шилжүүлнэ. Мөн гэмт хэргийн шинжгүй боловч Гэр бүлийн шүүхэд шилжүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мөн адил байна.³³⁴

Прокурор хэргийг шүүхэд шилжүүлэх

Прокурор хүүхдийн үйлдсэн хууль бус үйлдлийг шалгаад гэмт хэрэг үйлдсэн буруутай гэж үзвэл хэргийг Гэр бүлийн шүүхэд шилжүүлнэ. Мөн гэмт хэргийн шинжгүй боловч Гэр бүлийн шүүхэд шилжүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мөн адил байна.³³⁵

Эрүүгийн хариуцлага

18 насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах ял оноохоор бол бүх насаар хорих ял онооно. Мөн бүх насаар хорих ял оноохоор бол 10-20 жил хорих ял онооно.

3.БНСУ

Өсвөр насны хүүхдийн шүүх

БНСУ-д өсвөр насны хүүхдийн хууль бус үйлдэл, шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, хүлээлгэх хариуцлага, бусад асуудлыг зэргийг өргөн хүрээнд Эрүүгийн хууль, Өсвөр насны хүүхдийн тухай хууль³³⁶, Өсвөр насны хүүхдийг дэмжих тухай хууль³³⁷, Хүүхдийн халамжийн тухай хууль³³⁸, Өсвөр насны хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны журамд хамааруулан ойлгодог байна.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³³⁴ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 41 дүгээр зүйл.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³³⁵ Япон улсын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 42 дугаар зүйл.

<https://laws.e-gov.go.jp/law/323AC0000000168/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/3844>

³³⁶ <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

³³⁷ <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=234763&efYd=20220218#0000>

³³⁸ <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=259717&efYd=20240807>

Мөн Өсвөр насны хүүхдийн үйлдсэн хууль бус үйлдлийг Гэр бүлийн шүүхийн Өсвөр насны хүүхдийн хэргийн танхим, Гэр бүлийн шүүх байхгүй газарт орон нутгийн шүүхийн Өсвөр насны хүүхдийн хэргийн танхим хариуцсан шийдвэрлэдэг байна.³³⁹ Өсвөр насны хүүхдэд хамгаалах хариуцлага ноогдуулах шүүх хурлыг шүүгч дангаар шийдвэрлэдэг байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд **прокурор** оролцох бөгөөд тухайн өсвөр насны хүүхдийн үйлдсэн хууль бус үйлдлийг хамгаалах хариуцлага оногдуулах шаардлагатай эсэх эсхүл эрүүгийн хариуцлага шаардлагатай эсэхийг шийдэх бөгөөд Гэр бүлийн шүүх болон эрүүгийг хэргийн шүүхэд хэргийг шийдвэрлүүлэхээр шилжүүлэх эрхтэй байдаг байна.³⁴⁰

Шүүх хурлыг өсвөр насны хүүхдийн ирээдүйн төлөө хаалттай явуулах³⁴¹ бөгөөд мөн тухайн хүүхдийн хувийн мэдээлэл бүхий мэдээллийг тараахыг хуулиар хориглодог байна.³⁴²

Өсвөр насны хүүхдийг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны чиг үүргээ биелүүлэхэд бүхий л захиргааны байгууллага, сургууль, эмнэлэг зэрэг нийгмийн бүхий салбарыг хамран хамтран ажиллах шаардлагатай.³⁴³

Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг үнэлэх, бодит нөхцөл байдлыг тогтоох зорилгоор анагаах ухаан, сэтгэл судлал, боловсрол судлал болон бусад салбарын мэргэжлийн дүгнэлтийг ашиглах ёстой байдаг.³⁴⁴

Насанд хүрээгүй хүүхдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс бусад төрлийн арга хэмжээг шүүхээс авах ажиллагааны журам

Хэргийг шүүхэд шилжүүлэх

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг үйлдсэн 10-14 насны хүүхдийн хэрэг болон цаашид гэмт хэрэг үйлдлэх магадлалтай 10-аас дээш насны олноороо бүлэглэн бусдад айдас төрүүлэхүйц үйлдэл хийдэг хүүхэд, тодорхой шалтгаангүйгээр гадуур тэнүүчилдэг хүүхэд, согтууруулах ундаа хэрэглэж бусдын

³³⁹ БНСУ-ын Шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=265769&efYd=20241016#0000>

³⁴⁰ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 49.3 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁴¹ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=222435&efYd=20210421#0000>

БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлт. 헌법재판소 2012.7.26. 선고 2011 헌마 232 결정.

³⁴² БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 68 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁴³ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 28 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/IsInfoP.do?IsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁴⁴ БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлт. 헌법재판소 2012.7.26. 선고 2011 헌마 232 결정.

амгалан тайван байдал алдагдуулдаг, зан харилцааны доголдолтой хүүхдийг Гэр бүлийн шүүхэд шийлжүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулна.³⁴⁵

Дээр дурьдсан хүүхдийг олж тогтоосон бол түүний хууль ёсны асран хамгаалагч, сургууль, нийгмийн халамжийн байгууллага, хамгаалах байгууллагын дарга харьяалах Гэр бүлийн шүүхэд мэдэгдэж болно.³⁴⁶

Шүүхээс прокурорт шилжүүлэх

Гэр бүлийн шүүх хүүхдийн үйлдсэн хэргийг хянаж үзээд хорих болон дээш хэмжээний ял оноохоор гэмт хэрэг үйлдсэн төдийгүй энэхүү үйлдэлд зайлшгүй эрүүгийн харицлага хүлээлгэх шаардлагатай үзсэн эсхүл 19 түүнээс дээш насанд хүрсэн нь тогтоогдсон бол энэ тухай шийдвэр гарган харьяалах прокурорын байгууллагад хэргийг шилжүүлэнэ.

Шүүхийн мэдүүлэг авах, шалгах ажиллагаа

Гэр бүлийн шүүхийн шүүгч нь шүүхийн мөрдөгчид хэрэгт холбогдсон хүүхэд, түүний хууль ёсны асран хамгаалагч, гэрч, оролцогчоос мэдүүлэг авах болон бусад шаардлагатай асуудлыг шалгахыг даалгаж болно.³⁴⁷

Хэргийг хянан хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх

Шүүгч хэргийг хянаж үзээд шүүхээр хянан хэлэлцэх шаардлаггүй гэж үзвэл энэ тухай шийдвэр гаргах бөгөөд шүүхийн мэдүүлэг авах, шалгах ажиллагааны болон холбогдох байгууллагаас ирүүлсэн хэргийн материалтай танилцаад хэргийг хянан хэлэлцэх шаардлагатай гэж үзвэл энэ тухай шийдвэр гаргана.³⁴⁸

Шүүгч Өсвөх насны хүүхдийн тухай хуульд заасан хүмүүжүүлэх арга хэмжээг авах боломжгүй эсхүл шаардлагагүй гэж үзвэл энэ тухай шийдвэр гаргах бөгөөд харин шаардлагагүй гэж үзвэл тус хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг авах тухай шийдвэр гаргана.³⁴⁹

1. Хүүхдийг түүний эцэг, эх, асран хамгаалагчаас өөр харгалзан хамгаалах боломжтой этгээдэд хариуцуулах
2. Албадан эмчилгээ болон сургалтад хамруулах
3. Нийгэмд тустай ажил хийлгэх
4. Богино хугацааны хяналт тогтоох(эрх бүхий этгээд)
5. Урт хугацааны хяналт тогтоох(эрх бүхий этгээд)

³⁴⁵ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 4 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁴⁶ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 4 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁴⁷ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 4 дугаар зүйл.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁴⁸ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг. <https://www.law.go.kr/LSW/lsInfoP.do?efYd=20210421&lsiSeq=222435#0000>

³⁴⁹ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хууль.

<https://www.law.go.kr/LSW/lsInfoP.do?efYd=20210421&lsiSeq=222435#0000>

6. Хүүхдийн халамжийн тухай хуульд заасан халамжийн байгууллага эсхүл бусад хүүхэд хамгааллын байгууллагын хяналтад шилжүүлэх
7. Эмнэлэг, сувилал эсхүл Арга хэмжээ авагдсан хүүхдийн тухай хуульд заасан эрүүл мэндийн нөхөн сэргээх төвд шилжүүлэх
8. 1 сар хүрэл хугацаагаар хүүхдийн засан хүмүүжүүлэх төвд хүмүүжүүлэх
9. Богино хугацаагаар хүүхдийн засан хүмүүжүүлэх төвд хүмүүжүүлэх
10. Урт хугацаагаар хүүхдийн засан хүмүүжүүлэх төвд хүмүүжүүлэх

Давж заалдах гомдол гаргах

Дээр дурьдсан арга хэмжээг авах тухай шийдвэрийг гаргахдаа хууль зөрчсөн, бодит байдлыг үнэн зөв тогтоогоогүй, арга хэмжээ тохироогүй зэрэг үндэслэлээр өөрөөр болон хууль ёсны асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөх эрхтэй этгээд нь харьяалах Гэр бүлийн шүүх, орон нутгийн ердийн шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй байна.³⁵⁰ Давж заалдах шүүхийн шийдвэр хууль зөрчсөн гэж үзвэл дээд шүүхэд гомдол гаргах эрхтэй байдаг байна.³⁵¹

Насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх журам

Прокурор

Прокурор нь насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгаад тухай үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс бусад төрлийн арга хэмжээг авах нь зүйтэй гэж үзвэл хэргийг харьяалах Гэр бүлийн шүүхэд шилжүүлнэ.³⁵²

Прокурор нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн дурын хорооны гишүүдийн санал болон гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг хүүхдийн байгууллагын сургалтад хамрагдах, зөвлөгөө авах зэрэг болзол тавьж энэхүү үйл ажиллагаанд хамрагдсаны дараа яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлэхгүй байж болно.³⁵³

Шүүх

³⁵⁰ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 43 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁵¹ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 47 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁵² БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁵³ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

Шүүх гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хянаж үзээд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс илүүтэй эрүүгийн хариуцлагаас бусад төрлийн арга хэмжээ буюу хамгаалах арга хэмжээ авах үндэслэл байвал энэ тухай шийдвэр гарган харяалах Гэр бүлийн шүүхэд шилжүүлнэ.³⁵⁴

Шүүх үйлдсэн гэмт хэргийн талаар шалгах шаардлагатай гэж үзвэл мөрдөгчид даалгавар өгч тодорхой шалгах ажиллагааг явуулж болно.³⁵⁵

Гэмт хэрэг үйлдсэн 18 хүртэлх насны хүүхдэд цаазаар авах эсхүл бүх насаар хорих ял оноохоор байвал 15 жилийн хорих ял оноох³⁵⁶, 2 жилээс дээш хугацаагаар хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн бол гэмт хэргийн төрлөөс хамаарч дээд хугацааг 10 хүртэл жилээр, доод хугацааг 5 хүртэлх жилээр хорих ял онооно.³⁵⁷

Хорих ялаар шийтгүүлсэн хүүхдийг хүүхдийн хорих байгууллагад эсхүл ердийн хорих ангид хүүхдэд тусгайлан зориулж тусгаарласан байранд ял эдлүүлэх бөгөөд ял эдэлж байх хугацаандаа 23 насанд хүрсэн бол ердийн хорих ангид шилжүүлэн ял эдлүүлнэ.³⁵⁸

³⁵⁴ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 50 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁵⁵ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 56 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁵⁶ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 59 дүгээр зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁵⁷ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 60 дугаар зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

³⁵⁸ БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хуулийн 59 дүгээр зүйл.
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=222435&efYd=20210421#0000>

ДҮГНЭЛТ

Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хүрээнд

1. Харьцуулан судалсан улс орнуудад гэр бүлийн хэрэг маргааныг Гэр бүлийн шүүхэд харьяалан шийдвэрлэж байна.
2. Мөн гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх бие даасан хуулиар тухайн харилцааг зохицуулж байна. Энэхүү хуулиас гадна Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар гэр бүлийн хэрэг маргааны үндсэн асуудлыг зохицуулж байна.
3. Үрчлэлтийг манай улсад захиргааны байгууллага хариуцан шийдвэрлэж байгаа бол харьцуулан судалсан орнуудад шүүх ялангуяа Гэр бүлийн шүүхээр шийдвэрлэж байна.
4. Гэрлэлтийг талууд харилцан тохиролцож буюу захиргааны эсхүл шүүхийн журмаар цуцлуулж байгаа нь манай улстай адил байх боловч захиргааны журмаар гэрлэлт цуцлуулах ажиллагааг Гэр бүлийн шүүхэд харьяалуулан шийдвэрлэж байна.
5. Гэр бүлийн шүүх талууд насанд хүрээгүй хүүхэдтэй эсэх, хүүхэдтэй бол хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг тэжээн тэтгэх талаарх тохиролцоо, тэтгэлэгийн хэмжээ, хүүхэдтэй уулзах болзол нөхцөл, эцэг, эх байх үүргээ

хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л тохиролцоог харгалзан үзэж шийдвэр гаргадаг байна.

6. Эд хөрөнгө хуваах тухай тохиролцохдоо хүүхдийн асран хамгаалагчаар тогтоогдсон этгээдийн хувийн байдал, орлого, хөдөлмөр эрхлэх боломж, чадвар зэргийг хэрхэн харгалзан үзсэн талаар дүгнэж шаардлагатай бол хүүхдийн сайн сайхны төлөө гэр бүлийн дундын хөрөнгийг ялгамжтай байдлаар хуваах тухай шийдвэрлэж болдог байна. Дээр 4,5,6-д дурьдсан ажиллагааг Гэр бүлийн шүүхэд явуулснаар гэр бүл цуцалснаар гэр бүлийн гишүүдийг эрх ашиг зөрчигдөх эсэхийг хууль зүйн хувьд нарийн шалган тогтоох боломжийг нэмэгдүүлдэг бөгөөд талуудын тохиролцоо хууль ёсны байгаа эсэхэд шүүх мэргэжлийн дүгнэлт өгөх боломжийг нэмэгдүүлж байна гэж дүгнэхээр байна.
7. Гэр бүлийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах, лавлагаа, мэдээлэл гаргуулах, шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн орчин, нөхцөл байдлын талаар судлах, шалгах ажиллагааг шүүхийн ажилтны тусламжтайгаар хэрэгжүүлэх хүртэл арга хэмжээг авч болдог байна. Энэхүү тогтолцоо нь Гэр бүлийн шүүхэд байх өвөрмөц тогтолцоо байх бөгөөд Гэр бүлийн шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхийн тулд илүү мэргэжлийн байгууллагын оролцоог хангахаас гадна гэр бүлийн орчин нөхцлийг бодиттой судлан түүнд үнэлэлт дүгнэлт өгөх байдлаар шийдвэрлэхийг эрмэлзэх нь гэр бүлийн хэрэг маргааныг онцлогыг харгалзах зайлшгүй шаардлагатай байгааг илэрхийлж байна гэж дүгнэж болох юм.
8. Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах үндэслэл шалтгааныг хуульд тодорхой заахаас гадна гэрлэлт цуцлуулах бусад шалтгаан байгаа тохиолдлыг мөн хуульчилан зохицуулсан байна. Япон улсын тухай Иргэний хуульдаа гэрлэлт цуцлуулах шууд заасан үндэслэлээс гадна шууд бус үндэслэлийг заасан байх бөгөөд энэ нь шүүхээс гэрлэлтийг цуцлахаас гадна гэрлэлт цуцлахыг хүлээн зөвшөөрөхгүй байж болохоор зохицуулсан байна.
9. Буруутай гэрлэгчийн гаргасан гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлийг шүүх хүлээн авахгүй байх жишгийг тогтоосон улсууд байна. Япон болон БНСУ-ын тухайд хуульд шууд зохицуулсан агуулга бүхий заалт байхгүй боловч гэрлэгсэдийн хэн нэгний илт буруутай зүй бус үйлдлээс болж гэрлэлт цуцлуулахаар гаргасан нэхэмжлэлийг шүүх хүлээн авахгүй буюу тухайн этгээдийг нэхэмжлэл гаргах эрхгүй гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илт буруу зүй бус үйлдэл гаргаж түүний үр дүнд гэрлэлтээ цуцлуулах бол зөвхөн нөгөө талын зөвшөөрснөөр шүүхийн журмаар гэрлэлт цуцлуулах нь шударга ёсонд нийцнэ гэж үздэг байна. Энэ нь гэрлэлтийн үр дүнд бий болсон гэр бүлийн гишүүдийн эрх ашгийг гуравдагч этгээдээс хамгаалах зорилготойгоос гадна гэрлэлт цуцлалт нь гэм буруугийн үндэслэл шалтгаанаар хэмжигдэх ёстой гэсэн зарчмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримталж буй хэлбэр гэж дүгнэж болохоор байна.

10. Япон улсын тухайд эвлэрүүлэн зуучлах зөвлөл эвлэрүүлэн зуучлалыг хариуцан явуулдаг байна. Энэхүү зөвлөл нь Гэр бүлийн шүүхийн нэг шүүгч, эвлэрүүлэн зуучлагч хоёроос дээш гишүүнээс бүрддэг бөгөөд маргаан тус бүрээр байгуулагддаг байна. Зөвлөл орон тооны бус байдлаар ажиллах бөгөөд гишүүдийг томилох, чөлөөлөх асуудлыг Дээд шүүхээс баталсан журмаар зохицуулдаг байна. Энэхүү зөвлөлд шүүгч биечлэн оролцож байгаа нь анхуурууштай байх бөгөөд шүүх гэрлэлтийг цуцлахаас илүүтэй тэдэнд илүү зөвлөн тусалж нөлөөлөх байдлаар гэрлэлтийн харилцааг цаашид үргэлжлүүлэх боломжийг нэмэгдүүлэх зорилго агуулж байна гэж үзэж болох юм.
11. Гэрлэгчийн хэн нэг нь нас барсан зэрэг шалтгаанаар гэр бүлийн хэрэг маргааныг шүүхээр шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн бол прокурорыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаар БНСУ-ын хуульд зохицуулсан байна. Гэрлэлт анхнаасаа хууль бус байсан тохиолдолд гэрлэлтийг хүчингүй болгох шаардлага гарах бөгөөд хэн нэг нь нас барсан шалтгаанаар шүүхээр шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн бол прокурорыг оролцуулан шүүхээр шийдвэрлэдэг байна. Энэ нь хэн нь нэг нь нас барсан шалтгаанаар нэхэмжлэл гаргах боломжгүй болсон тохиолдлыг ойлгох бөгөөд гэрлэлтийг хүчингүй болгуулсан тухай шүүхийн шийдвэргүйгээс шалтгаалан гэрлэж байсан гэх хууль зүйн үр дүр дагавар бий болохоос сэргийлэх ач холбогдолтой гэж дүгнэхээр байна.

Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд

1. Харьцуулан судалсан улс орнуудад насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн эрүүгийн хэргийн шүүхээр хянан шийдвэрлэхээс илүүтэй Гэр бүл, хүүхдийн шүүхэд харьяалан шийдвэрлэж байна.
2. Хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөхөөс гадна хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг хянан хэлэлцэх тухай болон хариуцлага хүлээлгэх, хүмүүжүүлэхтэй холбоотой авах арга хэмжээг зохицуулсан тусгайлсан хуулийг мөн дагаж мөрдөж байна.
3. ХБНГУ-ын хувьд Хүүхдийн шүүхээр тус улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэдэг бөгөөд прокурор, шүүгч нь зөвхөн энэхүү хэргийг дагнан хянан шийдвэрлэдэг байхаар хуульчилсан нь нэлээдгүй онцлог байна.
4. БНСУ, ХБНГУ, Япон улсын тухайд Гэр бүлийн шүүхээр насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг хянан хэлэлцээд зогсохгүй Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг үйлдээгүй боловч цаашид гэмт хэрэгт холбогдох боломжтой үйлдлийг гаргадаг хүүхдийн асуудлыг хянан хэлэлцэж зохих

хүмүүжлийн арга хэмжээг авдаг байна. Үүнд бөөнөөрөө бүлэглэн явж олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах, тодорхой шалгаангүйгээр гадуур тэнүүчлэх, гэрээсээ явах гэх мэт үйлдлүүдийг хамааруулж байна. Мөн гэмт хэрэг үйлдсэн боловч нийгмийн хор аюул, хохирогчтой тохиролцсон байдал, хохирол барагдуулсан эсэх зэргийг харгалзан үзэж ердийн эрүүгийн хэргийн шүүхээр хэргийг хянан хэлэлцэж ял оноолгүй Гэр бүлийн шүүхээр хэргийг хянан хэлэлцээд эрүүгээс өөр төрлийн хариуцлага буюу хүмүүжүүлэх, сургахад чиглэгдсэн хариуцлага хүлээлгэдэг байна. Эндээс дүгнэхэд Гэр бүлийн шүүхээр насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг хянан хэлэлцэж байгаа гол зорилго нь хүүхдийн биеийн болон оюун санааны өсөлт бойжилтыг харгалзан үзэж тухайн хүүхэд хийсэн үйлдлийнхээ учир холбогдлыг бүрэн ухаарах хэмжээнд хүрээгүй зэргээс шалтгаалан гэмт хэрэгт холбогддог тул түүнд насанд хүрсэн хүний нэгэн адил ял оноох нь зохисгүй байх бөгөөд хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа мөн тусгайлсан журмаар явагдах нь зүйтэй гэж үздэг байна. Насанд хүрээгүй хүүхдийг яллахаас илүүтэй хүмүүжүүлэх, сургах, нийгэмшүүлэх гол зорилгыг агуулдаг тул үүнд тохирсон хариуцлагын болон хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоог бий болгосон гэж дүгнэхээр байна.

5. Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийг БНСУ-д прокурор хянан үзээд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс бусад төрлийн хариуцлага, арга хэмжээг авах шаардлагатай гэж үзвэл хэргийг Гэр бүлийн шүүхэд шилжүүлж байх бөгөөд ингэхдээ тухайн хүүхдийг Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх сайн дурын хороо нь болон хүүхдийн байгууллагын сургалтад хамрагдах, зөвлөгөө авах зэрэг болзол тавьж энэхүү үйл ажиллагаанд хамрагдсаны дараа яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлэхгүй байж болдог байна.
6. Мөн ХБНГУ-д хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн байгууллагын төлөөллийг эхнээс нь заавал оролцуулахаас гадна тухайн байгууллагаар хүүхдийн хувийн байдлын талаар болон түүний гэр бүлийн талаар дүгнэлт гаргуулж шийдвэр гаргахдаа харгалзан үздэг байна. Хүүхдийн байгууллагын төлөөлөгч шүүх хуралд оролцон үг хэлэх эрхтэй байх бөгөөд энэхүү эрхийг нь хангахын тулд түүнд шүүх хурлын тов, болох газрыг заавал мэдэгдэхээс гадна хүүхдийг хорьсон тухай шийдвэр гаргасан бол заавал мэдэгдэх ёстой байдаг байна. Мөн шүүхээс хүүхдэд үүрэг болгосон аливаа шийдвэрийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж биелүүлээгүй бол шүүхэд мэдэгдэх үүргийг хуульчилсан байна. Тус улсын тухайд хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн байгууллагын оролцоог илүү тодорхой хуульчилсан нь харагдаж байна. Ингэснээр тухайн байгууллага хүүхэд хамгаалах үндсэн зорилгоо хууль шүүхийн байгууллагын оролцоо хамтын ажиллагааны хүрээнд үр дүнтэй биелүүлэх боломж дээшлэх бөгөөд магадгүй шүүх хуулийн байгууллагаас хүүхдийн эрхийг зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүсэхэд тэдний эрхийг хамгаалахад маш чухал гэж дүгнэхээр байна. Хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд эхнээс нь оролцох боломжийг дээрхийн адил хангаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд

хүүхдийн талаар хангалттай хяналт тогтоох боломжтой болох бөгөөд хүүхэд бүрийн хувийн болон гэр бүлийн байдлыг тогтоож түүнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломж бүрдэх боломжтой юм.

7. ХБНГУ-д хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх шүүгч, прокурорт боловсролын салбарын мэдлэг, хүүхдийн боловсрол, хүмүүжлийн талаар тодорхой туршлагатай байхаар хуульчилсан байна. Гэхдээ энэхүү шаардлага практикт төдийлөн мөрдөгддөггүй байна. Шүүгчийн тухайд 10-30 жил дагнан хүүхдийн хэргийн шүүгчээр ажилласан шүүгчид ихэвчлэн байдаг бол прокурорын тухайд 2-3 жил ажиллаж байгаа шинэ прокурорууд хүүхдийн хэргийн прокуророор ажиллах нь элбэг байдаг байна. Шүүгчийн тухайд мэргэшсэн шүүгчийг тус улс шүүхийн захиргааны практикаараа нэгэнт бэлдэж хэвшсэн гэж үзэхээр байна. Прокурорын тухайд шинэ прокурор дундаас шууд томилогдож буй хувь нь 60 хувь байгаа бол томилогдсон прокурорын гуравны нэг хувь өөрийн хүсэлтээр хүүхдийн хэргийн прокуророор томилогдсон байдаг байна.
8. БНСУ, Япон улсад Цагдаагийн байгууллага нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдээгүй боловч эрүүгээс бусад төрлийн хариуцлага хүлээлгэхээр үйлдэл гаргасан хүүхдийг олж илрүүлсэн бол Гэр бүлийн шүүхэд шилжүүлэх үүрэг хүлээдэг байна. Асран хамгаалагчийн зүй ёсны шаардлагыг үл биелүүлдэг хаалттай хүүхэд, шалтгаангүйгээр оршин суургаа газраа орхин тэнүүчилдэг хүүхэд, гэмт хэрэг үйлдэж байсан эсхүл ёс суртахуун, хүмүүжлийн доголдолтой хүнтэй үерхэж нөхөрлөдөг эсхүл зүй бус газраар үйлчлүүлдэг хүүхэд, өөрийн болон бусдыг зан чанарт сөргөөр нөлөөлөх үйлдэл хийдэг хаалттай хүүхдүүд үүнд хамаардаг байна. Гэр бүл, хүүхдийн шүүх нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн хэргийг хянан хэлэлцэж хариуцлага ноогдуулахаас гадна гэмт хэрэгт холбогдож болзошгүй хүүхдийг урьдчилан илрүүлж гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдагаараа нэлээдгүй онцлог байна. Түүнчлэн Эрүүгийн хуульд зааснаас бусад төрлийн үйлдлийг хуульчилж тухайн хориглосон үйлдлийг хийсэн тохиолдолд түүнд сургалт хүмүүжлийн шинжтэй арга хэмжээг авч байхаар хуульчилсан төдийгүй үүнтэй холбоотой шийдвэрийг шүүх гаргадаг байх тогтолцоог бий болгосон байна. Энэхүү хянан шийдвэрлэх ажиллагаанд мөн хүүхдийн байгууллагын оролцоог бүрэн хангахаар зохицуулсан зэргээс харахад хүүхдийг хамгаалах тогтолцоог бүрэн хэмжээнд оролцогч талуудын хяналт дор явуулах боломжийг бий болгосон гэж дүгнэхээр байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж

1. БНСУ-ын Өсвөр насны хүүхдийн тухай хууль.
2. БНСУ-ын Иргэний хууль.
3. БНСУ-ын Үндэсний татварын тухай хууль.
4. БНСУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.
5. БНСУ-ын Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.
6. БНСУ-ын Иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын тухай хууль.
7. БНСУ-ын Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.
8. БНСУ-ын Шүүхийн тухай хууль.
9. БНСУ-ын Хүүхдийн тэтгэлэг төлүүлэх, дэмжих тухай хууль.
10. БНСУ-ын Гэр бүлийн бүртгэлийн тухай хууль.
11. БНСУ-ын Гэр бүлийн улсын бүртгэлийн журам.
12. Япон Улсын Өсвөр насны хүүхдийн тухай хууль.
13. Япон Улсын Иргэний хууль.
14. Япон Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.
15. Япон улсын Гэрлэлт, гэр бүлийн харилцааны тухай хууль.
16. Япон улсын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль.
17. Япон улсын Гэр бүлийн бүртгэлийн тухай хууль.
18. ХБНГУ-ын Иргэний хууль.
19. ХБНГУ-ын Өсвөр насны хүүхдийн шүүхийн тухай хууль.
20. ХБНГУ-ын Гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль.

Ном, сурах бичиг, тайлан

21. 송덕수, 민법강의, 박영사, 2023.
22. 법원행정처, 외국사법제도연구(5), 각국의 소년제도.
23. 법원행정처, 외국사법제도연구(4), 각국의 이혼제도.

Шүүхийн шийдвэр

24. БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлт. 헌법재판소 2012.7.26. 선고 2011 헌마 232 결정.
25. БНСУ-ын Сөүл хотын Гэр бүлийн шүүхийн шийдвэр, 서울가법 1993. 12. 9. 선고 92 드 68848 판결,
26. БНСУ-ын Дээд шүүхийн шүүхийн шийдвэр. 대법원 1994. 2. 8. 선고 93 도 2869 판결,
27. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대법원 1984. 3. 27. 선고 84 므 9 판결,
28. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대법원 1994. 4. 26. 선고 93 므 1273 판결,
29. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대법원 1993. 5. 27. 선고 92 므 143 판결,
30. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대법원 2001. 5. 8. 선고 2000 다 58804 판결,
31. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 1965.7.6, 65 므 12 등, 대판 2001.4.13, 200 다 52943.
32. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 1999.6.11, 96 므 1397.
33. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대결 1993.5.11, 93 스 6.
34. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 1999.6.11, 96 므 1397.
35. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대결 2002.8.28, 2002 스 36.
36. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 2009.11.12, 2009 므 2840·2857.
37. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 1998.4.10, 96 므 1434, 대결 2009.6.9, 2008 스 111.
38. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 1997.12.26, 96 므 1076, 1083.
39. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대법원 1995. 10. 12. 선고 95 므 175, 95 므 182.
40. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판 1995.3.28, 94 므 1584.
41. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대결 2002.8.28, 2002 스 36.
42. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대결 2000.5.2, 2000 스 13.
43. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판(정원) 2014.7.16, 2013 므 2250.
44. БНСУ-ын Дээд шүүхийн шийдвэр, 대판(정원) 2014.7.16, 2012 므 2288.

Цахим эх сурвалж

- 45. world.moleg.go.kr.
- 46. www.law.go.kr.
- 47. www.gesetze-im-internet.de.
- 48. web.archive.org.
- 49. www.e-gov.go.jp.
- 50. laws.e-gov.go.jp/law/.
- 51. www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/.